**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

# УНДНЫ УСНЫ ХУДАГ (ХӨВСГӨЛ, МӨРӨН СУМ 10,11,12,13,14 ДҮГЭЭР БАГ)-ЫН ГУРВАН ХУДАГ СМАРТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖТЭЙ БОЛГОХ БАРАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

**Тендерийн нэр: Ундны усны худаг (хөвсгөл, мөрөн сум 10,11,12,13,14 дүгээр баг)-ын гурван худаг смарт тоног төхөөрөмжтэй болгох нийлүүлэх гүйцэтгэгч сонгох**

Тендерийндугаар:

БАТЛАВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Л.ГАНБОЛД

ХЯНАСАН: ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Б.БОЛД

**Зөвшөөрсөн:**

**Үнэлгээний хорооны дарга** ........................... / /

**Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга**........................./ /

**Үнэлгээний хорооны гишүүд** ................................ / /

................................./ /

................................../ /

**Мөрөн хот**

**БАРАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

**<u>ГАРЧИГ</u>**

**ХЭСЭГ 1 – ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ**

**Бүлэг I.** **Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа (ТОӨЗ)**

Энэ бүлэг нь тендер бэлтгэхэд шаардлагатай бүх мэдээллийг тендерт оролцогчдодөгнө. Тендер ирүүлэх, тендер нээх, үнэлж шалгаруулах болон гэрээ байгуулах эрх олгохтой холбоотой мэдээлэл, мөн хамгийн сайн тендерийг шалгаруулах үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал болон тендерт оролцогч тухайн гэрээг гүйцэтгэх чадвартай эсэхийг тогтоох чадварын шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах чадварын доодшаардлагууд энд бичигдсэн байна. Нэгдүгээр бүлэг дэх зүйл заалтуудыг захиалагч өөрчлөхгүйгээр ашиглах ёстой.

**Бүлэг II.** **Тендер шалгаруулалтын өгөгдөлийн хүснэгт (ТШӨХ)**

Энэ бүлэг нь тухайн худалдан авах ажиллагаа бүрт тохирсон онцлог заалтуудыг агуулах бөгөөд эдгээр нь нэгдүгээр бүлгийн холбогдох зүйл заалтуудыг тодруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.

**Бүлэг III** **Тендерийн үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт**

Энэ хэсэг нь ТОӨЗ-ны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үүнд захиалагч “хамгийн сайн” гэж үнэлэгдэх тендерийг шалгаруулахад мөрдөхнэмэлт шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

**Бүлэг IV.** **Тендер шалгаруулалтын маягт**

Энэ бүлэгт тендер ирүүлэх маягт, үнийн хуваарийн хүснэгт, тендерийн баталгааны маягт болон үйлдвэрлэгчийн зөвшөөрлийн маягт зэрэг тендерт оролцогчоос өөрийн тендерийн хамт бөглөж ирүүлэх шаардлагатай маягтууд багтана.

**ХЭСЭГ 2 –БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

**Бүлэг V.** **Техникийн тодорхойлолт болон бусад шаардлага**

Энэ бүлэгт худалдан авах бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний жагсаалт,тэдгээрийг захиалагчид хүргэххуваарь, техникийн тодорхойлолт болон дагалдах үйлчилгээг тайлбарласан, дүрсэлсэн зураг зэрэг мэдээлэлбагтана.

**ХЭСЭГ 3 – ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ**

**Бүлэг VI.** **Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН)**

Энэ бүлэг нь захиалагч байгууллагаас бараа болон түүнийг дагалдах үйлчилгээг худалдан авах гэрээний харилцааг зохицуулсан ерөнхий нөхцөл, заалтуудыг агуулна. ГЕН-ийн заалтуудын үг, үсэг, агуулгыг өөрчилж үл болно.

**Бүлэг VII.** **Гэрээний тусгай нөхцөл (ГТН)**

Энэ бүлэгт тухайн худалдан авах барааны онцлогт тохируулан гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйл заалтыг тодруулсан нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ..

**Бүлэг VIII.** **Гэрээний маягт**

Энэ бүлэгтгэрээний маягт болон захиалагч шаардсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгогдсоны дараа шалгарсан тендерт оролцогчийн бөглөж ирүүлэх гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтууд багтана.

**Хавсралт:** **Тендерийн урилга**

Тендерийн урилгын маягтыг энэхүү тендерийн баримт бичгийн төгсгөлд жишээ болгон оруулав.

**Жич:** Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн хэсэг, бүлгийн оноосон нэр,гарчиг нь уг баримт бичгийг ойлгоход хялбар дөхөм болгох зорилгоор хэрэглэсэн бөгөөд ямар нэгэн хэм хэмжээ илэрхийлэхгүй болохыг анхаарна уу.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

**Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг бөглөх санамж**

Захиалагчийн шаардлагад нийцсэн тендер бэлтгэхтэй холбоотойгоор тендерт оролцогчдод шаардагдах бүрэн мэдээллийг энэ бүлэгт тусгана. Түүнчлэн тендер хүлээн авах, нээх, үнэлэх, "хамгийн сайн" тендерийг шалгаруулах болон гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг багтаана. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ захиалагч ТОӨЗ-г чанд мөрдөнө.

Нийлүүлэгчийн гэрээний үүрэг, гэрээний төлбөр, талуудын эрх, үүрэг, хүлээх эрсдэлтэй холбогдсон нөхцөлийг энэ бүлэгт бус харин 6дугаар бүлэг (гэрээний ерөнхий нөхцөл) болон7дугаарбүлэг (гэрээний тусгай нөхцөл)-т тус тус заана.

Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа нь тендерийн баримт бичгийн бүрэлдэхүүн болох ба харин гэрээний хэсэг болохгүй.

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

## ГАРЧИГ


**А. Ерөнхий зүйл**
1. Тендерийн цар хүрээ
2. Санхүүжилтийн эх үүсвэр
3. Залилан мэхлэх болон авилгын үйлдэл
4. Эрх бүхий тендерт оролцогч
5. Эрх бүхий бараа
6. Түншлэл

**Б. Тендерийн баримт бичиг**
7. Тендерийн баримт бичгийн агуулга
8. Тендерийн баримт бичгийг тодруулах
9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах

**В. Тендер бэлтгэх**
10. Тендер шалгаруулалтад оролцох зардал
11. Тендерийн хэл
12. Тендерийн иж бүрдэл
13. Тендерийн маягт болон үнийн хуваарь
14. Хувилбарт тендер
15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт
16. Тендерийн валют
17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт
18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт
19. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох баримт
20. Тендер хүчинтэй байх хугацаа
21. Тендерийн баталгаа
22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

**Г. Тендер ирүүлэх**
23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа
25. Хугацаа хоцорсон тендер
26. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх
27. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах

**Д. Тендерийг нээх, үнэлэх**
28. Тендерийг нээх
29. Нууцлал
30. Тендерийн тодруулга
31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцэх эсэхийг тогтоох
32. Алдааг залруулах
33. Нэг валютэд хөрвүүлэх
34. Дотоодын тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцох
35. Тендерийг үнэлэх, харьцуулах
36. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах
37. Аливаа тендерийг сонгох, эсвэл тендерүүдээс татгалзах захиалагчийн эрх

**Е. Гэрээ байгуулах эрх олгох**
38. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур
39. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
40. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх
41. Гэрээнд гарын үсэг зурах
42. Гүйцэтгэлийн баталгаа


## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

| | | |
|---|---|---|
| **1. Тендерийн цар хүрээ** | 1.1. | Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид ТШӨХ гэж товчлох)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан бараа, материал болон тоног төхөөрөмж (цаашид “бараа” гэх) худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. |
| | 1.2. | Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна. |
| | 1.3. | Олон багцтай тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийг багц тус бүрээр үнэлж зарахыг хориглоно. |
| | 1.4. | Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй. |
| **2. Санхүүжил-тийн эх үүсвэр** | 2.1. | Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-дтодорхойлсон эх үүсвэрээрсанхүүжүүлнэ. |
| **3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл** | 3.1. | Төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцожгэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой. |
| | 3.2. | Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй. |
| **4. Эрх бүхий тендерт оролцогч** | 4.1. | Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрт нээлттэй. хуулийн9 дүгээр 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харъяалалтай байж болно. |
| | 4.2. | Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:<br>4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;<br>4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;<br>4.2.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол;<br>4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон; |

4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;

4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;

4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;

4.2.9. Энэхүү тендерийн баримт бичгийн ТОӨЗ-ны 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол;(Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)

4.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

**5. Эрх бүхий бараа**

5.1. Гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТОӨЗ-ны 1.1-д дурдсан барааг хүлээн авснаар төлнө.

5.2. Энэхүү зааварчилгааны 5.1-д дурдсан барааны гарал үүсэл гэдэгт тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

**6. Түншлэл**

6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер ирүүлэх тохиолдолд ТШӨХ-дөөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

(а) түншлэлийн бүх гишүүний хувьд тендер хүчин төгөлдөр байхаар тендерт гарын үсэг зурсан байх;

(б) ТОӨЗ-ны 1.1-д заасан бараа нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхойлж хамтран ажиллах гэрээнд тодорхойлсонбайх;

(в) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;

(г) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоогзөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухайхамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;

(д) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.

## Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

**7. Тендерийн баримт бичгийн агуулга**

7.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд:

I ХЭСЭГ

Бүлэг 1. Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
Бүлэг 3 Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт
Бүлэг 4. Тендер шалгаруулалтын маягт

- Тендерийн маягт
- Үнийн хуваарь
- Тендерийн баталгааны маягт
- Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт

II ХЭСЭГ

Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт

III ХЭСЭГ

Бүлэг 6. Гэрээний ерөнхий нөхцөл
Бүлэг 7. Гэрээний тусгай нөхцөл
Бүлэг 8. Гэрээний маягт

- Гэрээний маягт
- Гүйцэтгэлийн баталгааны маягт
- Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт

Хавсралт: Тендерийн урилга

7.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

7.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.

**8. Тендерийн баримт бичгийг тодруулах**

8.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо (“утсан холбоо”-нд зөвхөн телекс болон факсыгхамруулна)-гоор ТШӨХ-дзаасан захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө.

Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

8.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахшаардлагатай гэж үзвэл энэхүү ТОӨЗ-ны 9дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

**9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах**

9.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

9.2. Ийнхүү оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.

9.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийгбэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

## B. ТЕНДЕР БЭЛТГЭХ

**10. Тендер шалгаруулалтад оролцох зардал**

10.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.

**11. Тендерийн хэл**

11.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн барим бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.

11.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТОӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийгхянан үзэх, үнэлэхэд харгалзана.

**12. Тендерийн иж бүрдэл**

12.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

(а) ТОӨЗ-ны 13, 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болон үнийн хуваарь;

(б) захиалагч шаардсан бол ТОӨЗ-ны 21 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлэх тендерийн баталгаа;

(в) тендерт оролцогчийг төлөөлж ТОӨЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл;

(г) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;

(д) тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;

(е) нийлүүлэх бараа болон түүнийг  дагалдах үйлчилгээ нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТОӨЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримт;

(ё) ТШӨХ-д шаардсан ТОӨЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэхбусад материал.

**13. Тендерийн маягт болон үнийн хуваарь**

13.1. Тендерт оролцогч нь Бүлэг 4-т заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.

13.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэгтзаасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.

**14. Хувилбарт тендер**

14.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.

**15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт**

15.1. Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буйүнэ болон, үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.

15.2. Үнийн хуваарьт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.

15.3. Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.

15.4. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.

15.5. Олон улсын худалдааны EXW, CIP болон ижил төстэй бусад нөхцөлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхэлэн гаргасан Incoterms-ийн хамгийн сүүлийнхувилбарыг удирдлага болгоно.

15.6. Нийлүүлэх барааны үнийг тендерийн маягт (Бүлэг 4)-д заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгаж ирүүлнэ. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

15.7. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14

хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.

15.8. Барааг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТӨӨЗ-ны 1.2 дахь заалт болон түүнд харгалзах ТШӨХ-ийн заалтаасүзнэ үү. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.

15.9. Үнийн хуваарьт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна. Үүнд:

(а) Монгол Улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:

1. барааны EXW үнэ (үйлдвэрийн, агуулахын, эсхүл лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд барааг үйлдвэрлэх, угсрахад ашигласан үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, үйлдвэрлэлийн бусад өртөг багтана;
2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг нэмэгдсэн өртгийн болон бусад адилтгах албан татвар;
3. барааgТШӨХ-д заасанэцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(б) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:

1. ТШӨХ-дзахиалагчийн нэрлэсэн хилийн боомт хүртэлх СИФ/CIF/ үнэ, эсхүл захиалагчийн нутаг дэвсгэр дэх нэрлэсэн байрлал хүртэлх СИП /CIP/ үнэ;
2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох гаалийн, нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
3. барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(в) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:

1. барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл/эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;
2. импортлогдсон бараанд урьд төлсөн(нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;
3. тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 –ын ялгавар;
4. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
5. барааgТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(г) Барааны Техникийн тодорхойлолт болон холбогдох үйлчилгээний талаарх шаардлагад тодорхойлсон Дагалдах үйлчилгээний хувьд:

Гэрээ байгуулах эрх олгогдсоноор Дагалдах үйлчилгээнд ногдох Худалдан авагч орны гаалийн, худалдааны болон бусад адилтгах албан татварыг тооцож

(1) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн дотоодын валютаар илэрхийлэгдэх зардлын өртөг;
(2) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн гадаадын валютаар илэрхийлэгдэх зардлын өртгийг тус тус харуулна.

15.10. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТӨЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

15.11. ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

15.12. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**16. Тендерийн валют**

16.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.

**17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт**

17.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:

(а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар,

(б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;

(в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.

**18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт**

18.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:

(а) хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 4 дүгээр бүлгийнмаягтаас тохирох маягтыг ашиглан ирүүлнэ;

(б) санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан too бүхий жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;

(в) гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;

(г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;

(д) хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;

(е) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;

(ё) одоогийн ба сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;

(ж) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.

18.2. Тендерт оролцогч ТОӨЗ-ны 1.1-д заасан барааг нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна.Үүнд:

(а) сүүлийн 5 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;

(б) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо]жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага;

(в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;

(г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.

(д) сүүлийнТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

18.3. Тендерт оролцогч түншлэл нь 18.2(а) ба (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 18.2 (а), (б), (г) -д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна.

Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана. ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт

оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй.

Тендерт оролцогч 18.2(б) ба (в)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.

18.4. ТШӨХ-д тусгайлан заасан бол Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлэхтендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол энэ тухайгаа нотлоход шаардлагатай баримт, материалыг тендертэй хамтируүлэх үүрэгтэй.

**19. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт**

19.1. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:

(а) барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;

(б) барааг [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана;

(в) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;

(г) захиалагчийнтехникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 19.1.(в)-ийн дагуу тайлбар ирүүлнэ.

Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.

**20. Тендер хүчинтэй байх хугацаа**

20.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.

**21. Тендерийн баталгаа**

21.1. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь ТШӨХ-д заасан үнийн дүнтэй тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ.

21.2. Тендер шалгаруулалт олон багцтай болнэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.

21.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.

21.4. Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно. Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэг дэх маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

21.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.

21.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

21.7. Энэ зүйлдшаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

21.8. Тендер нь шалгараагүй оролцогчийн тендерийн баталгааг 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногт багтаан хүчингүй болгоно.

21.9. Тендер нь шалгарсан оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 41дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТОӨЗ-ны 42 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн тохиолдолд хүчингүй болгоно.

21.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд:

(а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;

(б) тендерт оролцогч 32.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ТОӨЗ-ын 38.2-т заасан нөхцөл үүссэн бол;

(в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:

(1) ТОӨЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй;

(2) ТОӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй.

**22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах**

22.1. Тендерт оролцогч 12 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэгбүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.

22.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.

22.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

## Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

**23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх**

23.1. Тендерт оролцогч өөрийн тендерийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.

23.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжилнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТОӨЗ-ны 23.3, 23.4 –т заасныг баримтална.

23.3. Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

(а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх;

(б) **ТШӨХ-д заасан** хаягаар ТОӨЗ-ны 1.1-т заасан захиалагчийн нэр дээр хаяглах;

(в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТОӨЗ-ны 1.1 болон **ТШӨХ-д**тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаарыг тодорхой бичсэн байх;

(г) ТОӨЗ-ны 28.1-т заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх.

23.4. Хэрэв бүх дугтуйг 23.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.

23.5. ТОӨЗ-ны 23.1-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.

**24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

24.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

24.2. Захиалагч ТОӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.

**25. Хугацаа хоцорсон тендер**

25.1. Захиалагч ТОӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.

**26. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх**

26.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.

**27. Тендерт нэмэлт**

27.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт

**өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах**

нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.

27.2. Тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, тендерийг солих эсвэл буцааж авах мэдэгдлийг 22, 23 дугаар зүйлийн дагуу бэлтгэн, битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторх ба гаднах дугтуй дээр “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл хийнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.

27.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй.

27.4. ТОӨЗ-ны 27.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно.

27.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцааж авах нь 21 дүгээр зүйлийн дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.

---

## Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

---

**28. Тендерийг нээх**

28.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.

28.2. Захиалагч эхлээд “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлтийг ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана. Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн оролцогчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно. “ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” бичиглэл бүхий дугтуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана.

28.3. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

28.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:

(а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ сольсон эсэх;

(б) тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт(зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ).Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;

(в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

**29. Нууцлах**

29.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.

29.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.

29.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоозөвхөн бичгээр харилцана.

**30. Тендерийг тодруулах**

30.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна.Гэхдээ 31 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

**31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох**

31.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараахь шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:

(а) ТӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;

(б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;

(в) зөвшөөрөгдсөн маягтын дагуу захиалагчийн шаардлагыг хангасан тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;

(г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;

(д) тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасан эсэх.

31.2. ТӨЗ-ны 31.1 дэх заалтын (а) - (д)-д заасан заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

31.3. Шаардлагад нийцсэн тендер гэж тендерийн баримт бичгийн бүх нөхцөл болзол, тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санал болгосон бараа нь ТӨЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг зөрүүгүйгээр хангаж буй тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ. Үүнд:

(а) тендерт санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;

(б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;

(в) зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

31.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

**32. Алдааг залруулах**

32.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:

(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоондүнг засварлах;

(б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулах;

(в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

32.2. Захиалагч,“хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн үнэндзалруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

**33. Нэг валютад хөрвүүлэх**

33.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТОӨЗ-ны 16 дугаар зүйлд зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг тендер зарласан өдрийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

**34. Дотоодын давуу эрх**

34.1. ЗахиалагчТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй бараа санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй.

**35. Тендерийг үнэлэх, харьцуулах**

35.1. Захиалагч зөвхөн 31 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.

35.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:

(а) ТОӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах;

(б) ТОӨЗ-ны 31.3дугаарзүйлийн дагуу томоохон зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийх;

(в) тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах;

(г) захиалагч энэ тендерийн баримт бичгийн 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг түүнд холбогдох аргачлалын дагуу тооцон мөнгөөр илэрхийлж, түүнийг тендерийн үнэд нэмж тооцох;

(д) ТШӨХ-д зөвшөөрсөн бол дотоодын давуу эрхийн зөрүүг холбогдох аргачлалын дагуу тооцох.

35.3. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 35.2-т заасны дагуу үнэлгээ хийжтендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна.

35.4. ТШӨХ-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

35.5. Барааг ТӨЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгохдоо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.

35.6. Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн үр ашигтай хувилбарыг сонгохдоозахиалагч 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт дэх олон багцтай тендерийг үнэлэх тухай тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.

**36. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**

36.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.

36.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТӨЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТӨЗ-ны 18.2–т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуурүзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.

36.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

**37. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах захиалагчийн эрх**

37.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

## E. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

| | |
|---|---|
| **38. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур** | 38.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 35.3-т заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно. |
| | 38.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТОӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзах бөгөөд 21.9(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно. |
| **39. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл** | 39.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрээгаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ. |
| | 39.2. Шалгарсан тухаймэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |
| | 39.3. Захиалагч Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mnцахим хуудсанд тендерийн нэр болон багцын дугаарыг дараахь мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ. Үүнд:<br>1) тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;<br>2) тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;<br>3) нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;<br>4) тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;<br>5) тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн. |
| | 39.4. Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийн үнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө. |
| | 39.5. Тендер нь шалгарсан оролцогч ТОӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа гаргаж,гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсэн даруй захиалагч ТОӨЗ-ны 21.8-д заасны дагуу тендерийн баталгааг хүчингүй болгож, энэ тухайг шалгараагүй бусад тендерт оролцогчид мэдэгдэнэ. |
| **40. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх** | 40.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй. |
| **41. Гэрээнд гарын үсэг зурах** | 41.1. Захиалагч гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэглийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ. |

41.2. Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаантүүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

41.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТОӨЗ-ны 39.4-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

**42. Гүйцэтгэлийн баталгаа**

42.1. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанд багтаан, ТШӨХ, гэрээний тусгай нөхцөлд тусгайлан заасан хэлбэр, дүнгээр ирүүлнэ.

42.2. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно.

42.3. Шалгарсан тендерт оролцогч ТОӨЗ-ны 42.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.

**НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

| **ТОӨЗ-ны холбогдох заалт** | **А. Ерөнхий зүйл** |
|---|---|
| **ТОӨЗ 1.1** | Захиалагч нь: ***Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар, Мөрөн сумын 8 дугаар баг, Аймгийн нутгийн удирдлагын удирдлагын ордон*** |
| **ТОӨЗ 1.1*** | Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: ***Унды усны худаг (Хөвсгөл, Мөрөн сум 10,11,12,13,14 багт) гүйцэтгэлтэй ажлын гүйцэтгэгч сонгох*** |
| **ТОӨЗ 1.2** | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: **Багцтай:**<br>Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, олны өтөгт гүний худаг -70,000,000 төгрөг<br>Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох - 30,000,000 төгрөг |
| **ТОӨЗ 1.4** | Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд ТОӨЗ 15.9 –ын “а”-д цэгт хүргэх үүрэгтэй. |
| **ТОӨЗ 2.1** | ***Нийт батлагдсан төсөв: 100,000,000 (Дөрвөн зуун сая) төгрөг.***<br>*Үүнээс:*<br>*2020 онд санхүүжих дүн- 100,000,000 (Дөрвөн зуун сая) төгрөг*<br>Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, олны өтөгт гүний худаг - 70,000,000 төгрөг<br>Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох - 30,000,000 төгрөг |
| **ТОӨЗ 4.2.2** | Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын цахим мэдээллийн системээс татсан “QR” кодтой тодорхойлолт ирүүлэх шаардлагатай ба Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар мэдээллийг шалгана. |
| **ТОӨЗ 6.1** | Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер ирүүлэх тохиолдолд “Иргэний тухай” хууль, ТШӨХ-ийн 6.1-ийн “а”, “б”, “в”, “г”-д заасан шаардлагыг хангасан түншлэлийн гэрээг байгуулж, гэрээний эх хувийг ирүүлнэ. |
| | **Б. Тендерийн баримт бичиг** |
| **ТОӨЗ 7.3** | *Тендерт оролцогч тендерийн баримт, бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх шаардлагатай бөгөөд тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, нотлох баримт материалыг ирүүлээгүй байх, маягтыг дутуу ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.* |

| | |
|---|---|
| **ТӨЗ 8.1** | Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:<br>**Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар, АЗДТГ-ын А корпус 112 тоот. Утас: 70388848, 70388821, 70384908, 95490203** Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчаас авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Ирүүлсэн тодруулгын хариуг Төрийн худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн тодруулга хэсэгт бичгээр нийтлэх тул тодруулга, нэмэлт мэдээлэл хүссэн этгээд, тендерт оролцох хүсэлтэй бусад этгээд тендер нээх өдрийг хүртэл Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд сайтад хандаж байхыг анхаарна уу |
| | **В. Тендер бэлтгэх** |
| **ТӨЗ 11.1** | Тендерийн хэл нь Монгол хэл байна. *Тендерт оролцогч Монгол хэл дээр тендерээ бэлтгэж ирүүлнэ. Шалгарсан тендерт оролцогчтой байгуулах гэрээг түүний тендер ирүүлсэн хэл дээр байгуулна.* |
| **ТӨЗ 12.1 (в)** | 1.Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах, гэрээг удирдах эрх бүхий албан тушаалтанд олгосон итгэмжлэлийг тендерийн баримт бичгийн 4 дүгээр бүлгийн МАЯГТ № ТШМ 1-2 маягтын дагуу гаргаж ирүүлнэ.<br>2. Тендерийн маягтад гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан нь гүйцэтгэх захирал байгаа тохиолдолд компанийн төлөөлөн удирдах зөвлөл (удирдлага)-өөс олгосон итгэмжлэл ирүүлнэ. |
| **ТӨЗ 12.1 (ё)** | Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:<br>*1. Тендерийн маягтыг тендерийн баримт бичигт заасан МАЯГТ №:ТШМ-1-ийн дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.*<br>*2. Үнийн болон бараа нийлүүлэлтийн хуваарийг тендерийн баримт бичгийн МАЯГТ №:ТШМ-2А, 2Б, 2В-ийн аль тохирох маягтаар боловсруулж баталгаажуулан ирүүлнэ.*<br>*3. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтад заасан хугацааны дагуу баталгаажуулан ирүүлнэ,*<br>*4. Бараа нь захиалагчаас баталсан техникийн тодорхойлолт, олон улсын болон Монгол Улсын чанарын стандартыг хангасан эсэхийг гэрчлэх барааны техникийн тодорхойлолт, чанарын болон тохиролын гэрчилгээ, техникийн паспорт, ашиглалтын зааврыг тус тус ирүүлнэ. Барааны техникийн тодорхойлолтыг тендерийн баримт бичгийн хоёр дугаар бүлэгт заасан загвараар гаргасан байна. Барааны чанарын болон тохиролын гэрчилгээ, техникийн паспорт, ашиглалтын заавар зэрэг баримт бичиг нь гадаад хэл дээр байгаа тохиолдолд баталгаат орчуулгаар Монгол хэл дээр хөрвүүлсэн байна.*<br>*5.Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, захиалагчийн санал болгосон бараа, нийлүүлэлтийн хуваарь, техникийн тодорхойлолтыг зөвшөөрч байгаа талаарх мэдэгдэлийг эрх бүхий албан тушаалтны гарын үсэн тамгаар баталгаажуулж ирүүлнэ. ирүүлнэ.*<br>*6.Тендерийн баримт бичгийн ТӨЗ-ын 4.2-д заасан нөхцөл байдал үүсээгүй талаарх мэдэгдэл ирүүлнэ.*<br>*7.Олон багц барааны тендерт эсхүл гэрээ байгуулах эрх авсан бусад төсөл арга хэмжээний гэрээнд ажиллах хүн хүч, машин механизмын мэдээллийг тус тус ирүүлнэ. Энэ тендерт санал болгосон ажиллах хүчин, машин механизм нь олон багц болон давхцсан хэрэгжих гэрээнд ажиллах хүн хүч, машин механизмтай давхцсан тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.*<br>*9.Тендерт оролцогчийн ирүүлсэн тендер шалгарсан тохиодолд уг тендерийн баримт бичгийг олон нийтэд ил болгоход татгалзахгүй талаарх тендерт оролцогчийн мэдүүлэгийг эрх бүхий албан тушаалтны тамга, гарын үсгээр баталгаажуулж ирүүлнэ.*<br>*10.Захиалагчийн санаачлагаар Шүүх, харилцагч банк, Эрүүл мэнд нийгмийн* |

| | |
|---|---|
| | *даатгалын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, татварын хэлтэс, өмнө үйлчлүүлсэн захиалагчаас болон бусад холбогдох байгууллагаас тендерийн бичиг баримттай холбоотой асуудлаар тодорхойлолт, лавлагаа авахад татгалзах зүйлгүй гэсэн агуулга бүхий мэдэгдлийг тендерт оролцогч баталгаажуулан өөрийн тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ. Нийлүүлэхээр санал болгож буй тоног төхөөрөмж, программ хангамж нь Зохиогчийн эрхийн гэрчилгээтэй байна.*<br>*11. Тендерт санал болгож буй барааны зураг төслийг ирүүлэх шаардлагатай бол тендерийн баримт бичгийн хоёр дугаар хавсралтын "4"-т заасан хүснэгтээр уг мэдээллийг фото зургын хамт тод харагдахуйцаар ирүүлнэ. Мөн уг тоног төхөөрмөжийг суурилуулж угсруулж өгөхөөр тооцож ирүүлнэ.*<br>*12. Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолд тусгагдсан дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад тусгагдсан барааны нэр төрөлд хамаарах барааг импортын бараагаар орлуулахыг хориглох тул тендерт оролцогч дээрх жагсаалтад хамаарах бараанд зөвхөн дотоодын үйлдвэрт үйлдвэрлэсэн барааг санал болгоно.*<br>*13. Захиалагчаас санал болгосон дотоодын барааны багцад хамаараах барааг тусад нь багцлан нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртөг, барааны техникийн тодорхойлолт, үйлдвэрлэгчийн нэр гэх мэдээлийн дагуу импортын бараанаас тусад гаргаж* **МАЯГТ №: ТШМ-2А** *хүснэгтээр ирүүлнэ.*<br>*14. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материалын бичвэр дэх үсэг тоо, тэмдэгтүүдуншиг дахуйц тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй тод биш баримт бичиг бүхий тендерийг ирүүлээгүйд тооцож татгалзана.* |
| **ТӨЗ 13.1** | Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн дөрөв дүгээр бүлэгт заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. *Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.*<br>*Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.* |
| **ТӨЗ 13.2** | Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. *Үнийн хуваарийг тендерийн баримт бичгийн 4 дүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг сонгон бэлтгэнэ.* |
| **ТӨЗ 14.1** | Хувилбарт тендер ирүүлэхийг ***"зөвшөөрөхгүй":*** |
| | Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна. *Үүнд:*<br>*1. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.*<br>*2. Нийлүүлэх барааны үнийг тендерийн баримт бичгийн дөрөв дүгээр бүлэгт заасан тендерийн маягтад заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгаж ирүүлнэ. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.*<br>*3. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.*<br>*4. Дотоодын болон импортын барааны хувьд барааны нийлүүлэх үнэнд барааг захиалагчийн заасан эцсийн цэгт хүргэх тээврийн болон бүх төрлийн татвар, даатгал, компанийн ашиг тооцсон зардлууд шингэсэн гэж үзнэ..* |

| | |
|---|---|
| **ТӨӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)** | "Бараа хүргэгдэх эцсийн цэг: 10,11,12-р багын худагт тоног төхөөрөмж байршуулж угсрах . |
| **ТӨӨЗ 15.10** | Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад ***"тохируулахгүй тогтмол байна."*** Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТӨӨЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. |
| **ТӨӨЗ 16.1** | Тендерийн валют: ***[Төгрөг байна. ]*** |
| **ТӨӨЗ 17.1** | Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагчид дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх: Үүнд:<br>1. *хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээ; (Улсын бүртгэлийн гэрчилгээний үйл ажиллагааны чиглэлд тухайн барааны чиглэлээр гадаад, дотоод худалдаа эрхлэх чиглэлтэй байна.)*<br>2. *Тухайн үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр ажлын байрны дүгнэлтийг ирүүлнэ: "Шаардлагатай", "Шаардлаггүй" аль нэгийг сонгох*<br>3. *тухайн барааг тусгай зөвшөөрлийн дагуу нийлүүлэх шаардлагатай бол уг барааг нийлүүлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг наториатаар батлуулан ирүүлсэн байх; Үүнд:*<br>*БА-2.2.1 Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээ*<br>*БА-2.2.2 Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын ёйётем угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт*<br>*БА-2.2.4 Дулаан болон усан хангамжийн гол/ магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралтын тусгай зөвшөөрөлтэй байх.*<br>4. *тендерт оролцогчийг төлөөлж тендерийн баримт бичиг, гэрээ, бусад холбогдох баримт бичигт гарын үсэг зурах гэрээний хэрэгжилтийг удирдах этгээдийн итгэмжлэл;*<br>5. *Тендер оролцогч аж ахуйн нэгж, түүний эрх бүхий албан тушаалтан нь хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай болон сүүлийн 3 жилд аливаа шүүхийн зарга маргаанд хариуцагчаар оролцож ял шийтгэл, өр төлбөртэй нь тогтоогдож байгаагүй тухай Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт; Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтууд нь гаргасан өдрөөс хойш нэг сарын хугацаанд хүчинтэй байх бөгөөд тендер нээх өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.*<br>6. *Тендерт оролцогч аж ахуйн нэгж, түүний эрх бүхий албан тушаалтан тендер нээх өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлгүй талаар Монгол банкны зээлийн нэгдсэн мэдээллийн сангаас гаргасан тодорхойлолт, чанаргүй зээлтэй бол Монгол банкны мэдээллийн сангаас гаргасан зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарийг тус тус;*<br>7. *байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийг дараах хүснэгтээр тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны тамга гарын үсгээр баталгаажуулсан байна..* |

<table>
<tr><td></td><td>
<table>
<tr><td>Мэдээллийн нэр</td><td>Мэдээллийн агуулга, мэдээлэл</td></tr>
<tr><td>Байгууллагын нэр, регистрийн дугаар</td><td></td></tr>
<tr><td>Байгууллагын хаяг</td><td></td></tr>
<tr><td>Байгууллагын шуудангийн хаяг</td><td></td></tr>
<tr><td>Байгууллагатай харилцахын тулд холбогдох 3-аас доошгүй албан тушаалтан (тухайн тендер оролцогчийг төлөөлөх эрхтэй, тухайн байгууллагад ажилдаг)-ны утасны дугаар</td><td></td></tr>
<tr><td>Байгууллагатай харилцах албан ёсны мэйл хаяг</td><td></td></tr>
<tr><td>Харилцах банкны дансны дугаар</td><td></td></tr>
</table>
8. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд тендерт ирүүлсэн гэрээний үнэ, нийлүүлэлтийн хуваарьт багтаан захиалагчийн баталсан техникийн тодорхойлолт, холбогдох стандартыг хангасан барааг нийлүүлэлтийн хуваарьт заасны дагуу хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж ирүүлнэ.
9. Татвар, Нийгмийн даатгалын байгууллагад тендер нээх өдрийн байдлаар өр төлбөргүй талаар тус байгууллагуудын цахим мэдээллийн сангаас лавлагаа авч тендерт хавсарган ирүүлнэ.
</td></tr>
<tr><td>ТӨЗ 18.1 (а)</td><td>Үйлдвэрлэгч, борлуулагчийн зөвшөөрөл: “шаардлагатай” тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгч, борлуулагчийн зөвшөөрлийг тендерийн баримт бичгийн дөрөв дүгээр бүлгийн маягтаас тохирох маягтыг ашиглан ирүүлнэ. Үйлдвэрлэгч, борлуулагчийн зөвшөөрөл нь гадаад хэл дээр байгаа тохиолдолд түүнийг баталгаат орчуулгаар Монгол хэл дээр хөрвүүлсэн байна.</td></tr>
<tr><td>ТӨЗ 18.1 (б)</td><td>
Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил / 2017, 2018, 2019 он/
Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: “тийм”,
2017, 2018, 2019 онуудын санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх.
2017, 2018, 2019 оны санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайланг e-balance цахим бүртгэлд шивээгүй, баталгаажуулаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.
</td></tr>
<tr><td>ТӨЗ 18.1 (в)</td><td>
Тухайн төсөл дээр ажиллуулахаар санал болгож буй инженер техникийн ажилтнууд нь дараах хүснэгтэд заасан мэргэжил ур чадвар, шалгуур, шаардлагад нийцсэн байхаар ирүүлнэ. Үүнд: №ТШМ-2-1.5
<table>
<tr><th>Албан тушаал</th><th>Хүний Тоо</th><th>Ажлын туршлага</th><th>Мэргэжил</th></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>
</td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td>
ТОӨЗ 18.1-ын (б)-ын 1. № ТШМ-2-1.5 хүснэгтээр санал болгосон инженер, техникийн ажилтан, ажилчдын 50 –иас доошгүй хувийн нэр дээр нийгмийн даатгалын шимтгэлийг 2019 оны сүүлийн хагас жил (6, 7, 8, 9 ,10, 11, 12 дугаар сарууд) оролцогч аж ахуйн нэгж өөрөө төлсөн болохыг Нийгмийн даатгалын байгууллагаас баталгаажуулсан НД№7, НД№8 маягтаар гаргасан тайланг тендерт оролцогч баталгаажуулж ирүүлнэ.
ТОӨЗ 18.1-ын (б)-ын 2. № ТШМ-2-1.5 хүснэгтэд байгаа инженер, техникийн ажилтнууд, ажиллуулахаар санал болгож бусад мэргэжлийн ажилчдын иргэний үнэмлэх, диплом, мэргэжлийн үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар, ИТА-ны туршлагын талаархи мэдээллийг PDF хэлбэрт шилжүүлж тус тус ирүүлнэ. /Уг төсөлд санал болгож буй бүх ИТА, ажилчдад хамаарна/
</td>
</tr>
<tr>
<td>ТОӨЗ 18.1 (г2)</td>
<td>Сүүлийн 2 жил / 2018,2019 он/-д нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангалтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолт болон хяналт шалгалтын байгууллагын хяналтын аль нэгээр нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</td>
</tr>
<tr>
<td>ТОӨЗ 18.1 (г3)</td>
<td>
1.Ижил төстэй барааг гэрээгээр нийлүүлсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 3 жил ( 2017, 2018,2019 он) байх бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй бараатай ижил төстэй барааг нийлүүлэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх ба энэхүү туршлагад тооцуулах гэрээ (ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн тэр гэрээ)-ний үнэ нь энэ тендерт санал болгож буй барааны төсөвт өртгийн 30 хувиас доошгүй байна.
/"тендерээр нийлүүлэх барааны нэрийг бичнэ"-тэй ижил төрлийн барааг нийлүүлж байсан гэрээний тухай мэдээлэл/-ийг дараах хүснэгтээр ирүүлнэ:
<table>
<tr><td rowspan="2">№</td><td rowspan="2">Гэрээний нэр</td><td rowspan="2">Бараан ы нэр</td><td rowspan="2">Гэрээний үнэ /мян.төг/</td><td colspan="3">Захиалагчийн мэдээлэл</td></tr>
<tr><td>Нэр</td><td>Хаяг</td><td>Утасны дугаар</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>
2.Сүүлийн 3 жил ( 2017, 2018, 2019 онууд)-ийн хугацаанд гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж нийлүүлсэн ижил төстэй барааны жагсаалт, бараа нийлүүлсэн гэрээ тус бүрийн гэрээний эх хувиас татсан хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээ бүрийн гүйцэтгэл бүрэн, чанартай байсан талаар өмнөх захиалагчийн тодорхойлолт, барааг хүлээн авсан захилагчийн актын хуулбаруудыг нотариатаар баталгаажуулж, PDF хэлбэрт шилжүүлэн ирүүлнэ. Ижил төстэй барааны нийлүүлэлтэд тооцуулах гэрээ бүрийн гүйцэтгэл бүрэн, чанартай байсан талаарх өмнөх захиалагчийн тодорхойлолтыг дараах этгээдээс гаргуулсан байна. Үүнд: Улсын төсвөөс орон нутагт эрх шилжүүлсэн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн гэрээний гүйцэтгэлийн тодорхойлолтыг захиалагчаар ажилласан аймаг, сумын Засаг даргын тамгын газраас, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн гэрээний гүйцэтгэлийн тодорхойлолтыг захиалагчаар ажилласан яамнаас бусад эх үүсвэрээр гүйцэтгэсэн гэрээний хэрэгжилтийн талаарх тодорхойлолтыг үндсэн захиалагчаас тус тус авч ирүүлнэ. Хувийн аж ахуйн нэгж, иргэнтэй байгуулсан гэрээний мэдээллийг ижил төстэй ажилд тооцохгүй. Худаг автоматжуулалтын гэрээ байх бөгөөд захиалагч талаас хэвийн ажиллаж байгаа эсэхэд тодорхойлолт ирүүлнэ
ТШӨХ-ийн ТОӨЗ 5.2-ын (д)-ын 1, ТОӨЗ 5.2-ын (д)-ын 2, ТОӨЗ 5.2-ын (д)-ын 3-д заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.
</td>
</tr>
</table>

<table>
<tr><td>ТӨӨЗ 18.1 (д)</td><td>Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: “шаардлагатай” Техникийн тодорхойлолтод заасан чанар стандартын шаардлага хангаагүй барааг шинэ бараагаар солих үүрэг хүлээнэ.</td></tr>
<tr><td>ТӨӨЗ 18.2 (а)</td><td>Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь захиалагчийн санал болгож буй төсөл арга хэмжээ (багц)-ний төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх.</td></tr>
<tr><td>ТӨӨЗ 18.2 (б)</td><td>Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 3 жил</td></tr>
<tr><td>ОӨЗ 18 (в)</td><td>Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: Тендерт оролцогч нь доорх хүснэгтэд заасан шалгуур, шаардлагыг хангасан машин, тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг ирүүлнэ. Үүнд: / Маягт № ТШМ-2-1.4 хүснэгт, ТӨӨЗ 18 (в)-1/
<table>
<tr><td>Машин тоног төхөө-рөмж, багаж хэрэгслийн нэр, зориулалт</td><td>Тоо, хэмжээ</td><td>Улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспортын дугаар</td><td>Эзэмшдэг байгууллага иргэний нэр</td><td>Чанар байдал,ашиглал ад орсон огноо</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>
ТӨӨЗ 18 (в)-2: Маягт № ТШМ-2-1.4 хүснэгт заасан машин механизмын 50-аас багагүй, тоног төхөөрөмжийн 50-иас багагүй хувь нь тус тус тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх, үлдсэн нь түрээсийн байж болно. Түрээсийн машин тоног төхөөрөмжийг ашиглах тохиолдолд түрээслүүлэгчтэй машин тоног төхөөрөмж ашиглах түрээсийн гэрээг Иргэний хуулийн холбогдох зүйлд нийцүүлэн 2020 онд байгуулсан байна. Машин тоног төхөөрөмж нь тендерт оролцогчийн эсхүл түрээсийн болохыг дараах баримт баримт бичгээр нотлоно. Үүнд:
ТӨӨЗ 18 (в)-3: Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж бүрийн техникийн болон тээврийн хэрэгслийн гэрчилгээний натариатоор батлуулсан хуулбар ирүүлнэ. Тээврийн хэрэгсэл, механизмийн техникийн улсын бүртгэл тооллогод орсон хугацаа нь тендер нээх өдөр түүнээс хойш хүчинтэй байна.
ТӨӨЗ 18 (в)-4: Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан түрээсийн гэрээ
ТӨӨЗ 18 (в)-5: Бараа нийлүүлэлтэд ашиглах хэмжих, хянах багаж хэрэгсэл бүр нь холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажилтын гэрчилгээтэй болохыг нотолж гэрчилгээний нотариатоор батлуулсан хуулбарыг PDF хэлбэрт шилжүүлэн ирүүлнэ. Уг гэрчилгээний хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрөөс хойш хүчинтэй байх шаардлагыг хангасан байна.
Дээрхи тоног төхөөрөмж нь тендерт оролцогч аж ахуйн нэгжийн өөрийн өмчлөлийн хөрөнгө болох нь тээврийн хэрэгслийн техникийн гэрчилгээнд бичигдсэн эзэмшигчийн нэр, авто тээврийн үндэсний төвөөс олгогдсон лавлагаа тодорхойлолтоор нотлогдоно.
ТӨӨЗ 18 (в)-1, ТӨӨЗ 18 (в)-2, ТӨӨЗ 18 (в)-3, ТӨӨЗ 18 (в)-4, ТӨӨЗ 18 (в)-5-д заасан шаардлага нөхцлийн аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. </td></tr>
</table>

| | |
|---|---|
| **ТӨЗ 18.2 (г)** | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн[1] нийт дүн: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: *Захиалагчаас санал болгож буй төсөл арга хэмжээ (багц)-ний төсөвт өртгийн* **30%-иас** *багагүй байх*<br><br>**ТӨЗ 5.3 (д)-ын 1.***Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн заавар”-ын 3.2.2-ийн “е”-д “ Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө =МөнгөТүүнтэй АдилтгахХөрөнгө +Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтээр дүгнэнэ” гэж заасны дагуу буюу дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:*<br><br>*1.1. Байгууллагын харилцагч банкин дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа (Үүгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө тооцуулах саналтай тохиолдолд дансны хуулгыг харилцагч банкаар баталгаажуулж дансны үлдэгдлийг баталгааны хамт ирүүлсэн байна)*<br><br>*1.2. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн мэдэгдлийг үнэлгээнд харгалзахгүй/*<br><br>*1.3 Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд.*<br><br>***Дараах тохиолдолд тендерээс татгалзана. Үүнд Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах зээл нь ТШӨХ-ийн ТӨЗ 5.3 (д)-д заасан хэмжээ, өгөгдөл, шаардлагыг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.*** |
| **ТӨЗ 18.2 (д)** | Ашигтай ажилласан байх жилийн тоо: ***Сүүлийн 3 жил / 2017, 2018, 2019 он/-д ашигтай ажиллсан байна.*** |
| **ТӨЗ 18.3** | Тендерт оролцогч түншлэл нь 18.2(а) ба (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 18.2 (а), (б), (г) -д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна.<br><br>Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана. ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй.<br>Тендерт оролцогч 18.2(б) ба (в)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно. |
| **ТӨЗ 18.4** | Дотоодын давуу эрхийн зөрүү: ***“тооцно ”*** Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. *Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол ТӨЗ 12.1 (ё)-ийн 4, 13 дахь хэсэгт заасан дотоодын бараа болохыг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:*<br>***1.*** *Барааны гарал үүслийн гэрчилгээ*<br>***2.*** *Дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт*<br>***3.*** *Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, чанарын сертификат, барааны техникийн тодорхойлолт, холбогдох* стандарт,<br>*ТБОНӨХБАҮХАТХуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2015 оны 18 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 58 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ын дагуу тооцно, Энэ төсөл арга хэмжээ нь бараа нийлүүлэх* |

[1] Авах боломжтой зээл гэдэгт зээлжих баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.

| | |
|---|---|
| | *гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер тул ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10[1]-т заасны дагуу дотоодын давуу эрх тооцно.* |
| **ТОӨЗ 19.1.(а)** | барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт; |
| **ТОӨЗ 19.1.(б)** | Тендерт оролцогчийн санал болгосон барааг [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана; |
| **ТОӨЗ 19.1.(в)** | нийлүүлэх бараа нь захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл, нотлох баримт; |
| **ТОӨЗ 19.1.(г)** | Захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 19.1.(в)-ийн дагуу тайлбар ирүүлнэ. Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна. |
| **ТОӨЗ 20.1** | Тендерийн баталгааны хүчинтэй хугацаа нь: *Тендер нээснээс хойш **30** хоногийн туршид хүчинтэй байна.* |
| **ТОӨЗ 21** | Тендерийн баталгааны үнийн дүн: (төсөвт өртөгийн 2 хувиар)<br><br>***Төсөвт өргийн 2 хувиар баталгааны хэмжээг тогтоож*** **МАЯГТ №: ТШМ-3А** ***-аар ирүүлнэ.***<br>Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, олны өтөгт гүний худаг – 1,400,000 төгрөг<br><br>Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох - 600,000 төгрөг<br><br>***Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацааг он, сар, өдрөөр тогтооно.*** Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 7 дугаар сарын 15-ы өдрийг дуустал<br><br>*Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.*<br><br>***Дараах тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно. Үүнд:*** *Тендерийн баталгааны үнийн дүн:*<br><br>*1. Тендерт оролцогч тендерийг нээсний дараа тендерийн хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс татгалзсан. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.1 дэх заалт.*<br><br>*2. "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.2 дэх заалт.*<br><br>*3. Тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалт*<br><br>*Тендерийн баталгааны дүнг тендерийн баримт бичигт заасан мөнгөн дүнгээс бага эсхүл илүү тооцсон, тендерийн баталгааны хүчинтэй хугацааг дутуу тооцсон тохиолдолд уг тендерийн баталгааг "хуулд"-д нийцээгүй тендерийн баталгаа гэж үзэж татгалзана.* |

| | |
|---|---|
| | *4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.*<br>5. *Тендер нь шалгарсан оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТОӨЗ-ны 42 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн тохиолдолд хүчингүй болгоно.* |
| **ТОӨЗ 22.1** | Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: *Тендерийн баримт бичгийг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн цахим гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Тендерийг цахимаар зохион байгуулах тул хуулбар хувь шаардлагагүй.* |
| **Г. Тендер ирүүлэх** | |
| **ТОӨЗ 23.3 (б)** | Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: *Тендерийн баримт бичгийг электрон файл хэлбэрээр хэсэг тус бүр нь 15 Mb-с хэтрэхгүй байхаар 100 Mb хүртэл хэмжээтэй PDF форматаар бэлдэж http:www.tender.gov.mn хаягаар илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.*<br>*Тендер хүлээн авах этгээд: Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Д.Төмөр*<br>*Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын “А” байр, худалдан авах ажиллагааны ил тод байдлын танхим.*<br>*Давхар болон өрөөний дугаар: Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын , өрөөний дугаар 114 тоот.*<br>*Аймаг, хот: Хөвсгөл аймаг Мөрөн хот*<br>*Улс:“Монгол Улс”*<br>Аймаг, хот: ***Хөвсгөл аймаг, Мөрөн сум***<br>Шуудангийн дугаар: |
| **ТОӨЗ 24.1** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: *Огноо:* ***2020 оны 5 дугаар сарын 18-ны өдөр***<br>*Цаг:* ***11 цаг 20 минут***<br>*Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.* |
| | **Д. Тендерийг нээх, үнэлэх** |
| | *Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.* |
| **ТОӨЗ 28.1** | Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: |

| | |
|---|---|
| | Байшин, гудамжны нэр: *Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын "А" байр, худалдан авах ажиллагааны ил тод байдлын танхим.*<br><br>Давхар болон өрөөний дугаар: *Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Д.Төмөр, 114 тоот өрөө*<br><br>Аймаг, хот: *Хөвсгөл аймаг, Мөрөн хот*<br><br>Шуудангийн дугаар:<br><br>Улс: ***"Монгол Улс"***<br><br>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:<br><br>Огноо: **2020** ***оны 5 дугаар сарын 18-ны өдөр***<br><br>Цаг: ***11 цаг 40 минут*** |
| **ТӨОЗ 35.2 /г/** | Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:<br>(а) *тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоон дүнг засварлах;*<br><br>*(б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулах;*<br><br>*(в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.*<br><br>***32.2.*** *Захиалагч,"хамгийн сайн" үнэлэгдсэн тендерийн үнэндзалруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.* |
| **ТӨОЗ 40.1** | Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: ***[хувийг оруул]***<br><br>Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: ***[хувийг оруул]*** |
| **ТӨОЗ 40.2** | *Тендер шалгаруулалтын үр дүнгийн мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим систем-д нийтэлнэ. Гэрээ байгуулах эрх олгосон тухай болон тендерт шалгараагүй тухай мэдэгдлүүдийг www.umch.khs.gov.mn сайтад нийтэлж, тендерт оролцогчийн мэйл хаягаар илгээх тул тендерт оролцогч тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг энд заасан мэдээллийн хэрэгсэл, мэйл хаягаасаа үзэж мэдээлэл авах үүрэгтэй. Тендерт оролцогчийн мэйл хаяг нь алдаатай байсан болон мэйл хаягаа шалгаагүйгээс үүсэх эрсдлийг захиалагч хүлээхгүй. Мэдэгдлийн эх хувийг баталгаат шуудангаар илгээнэ.* |
| **ТӨОЗ 42.1** | (а) Гүйцэтгэлийн баталгаа «Шаардана" эсхүл "Шаардахгүй" сонголтыг авах;<br><br>(б) Гүйцэтгэлийн баталгаа шаардах тохиолдолд гэрээний маягтууд буюу VII бүлэг дэх тохирохмаягтын дагуу Гүйцэтгэлийн баталгааг гаргуулж гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх шаардлагатай. Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгө дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцүү байна. |
| **Анхааруулга** | Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд хууль хяналтын байгууллага болон тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагад тус тус хандан шийдвэрлүүлнэ. |

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

## ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэ хэсэг нь ТОӨЗ-ны хэсэг бөгөөд захиалагч ТШӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээг хийхдээ тендерийн маягтанд тусгасан үнийн саналаас гадна ТОӨЗ-ын 35.2 (г)-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан үзэж болох бөгөөд ингэхдээ дараах шалгуур болон аргачлалыг ашиглан мөнгөөр илэрхийлж, тендерийн маягтад дурдсан үнэд харгалзан тооцсоны үндсэн дээр тендерийн харьцуулах үнийг гаргана.Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

[Захиалагч тухайн тендер шалгаруулалтад аль тохиромжтой гэж үзсэн үнэлгээний шалгуур, аргачлалуудаас сонгож хэрэглэх нь зүйтэй]

(a) *Гэрээний болон арилжааны зөрүү:* ***"Ашиглахгүй"***
Гэрээний болон худалдааны нөхцөлөөс зөрүүтэйгээр санал болгосон болон орхигдуулсан зүйлбүрийн өртгийг тооцоолж үнэлгээнд харгалзана.(Гэхдээ дээрх зөрүү нь захиалагчийн хүлээн зөвшөөрөхүйц жижиг хэмжээний зөрүү, орхигдуулсан зүйл, тоо ширхэгтэй холбоотой байж болох бөгөөд захиалагч түүнийг томоохон зөрүү гэж үзсэн тохиолдолд уг тендерээс татгалзах эрхтэй. )

*(а) Бараа нийлүүлэлтийн хуваарь:* ***"Ашиглана"***

Тухайн тендер шалгаруулалтанд холбогдох гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь нийлүүлэлтийн хуваарь (Бүлэг 6)-т заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (барааны нийлүүлэлт хийх хамгийн эхний өдрөөс хойш нийлүүлэлт хийвэл зохих хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) нийлүүлэгдсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө нийлүүлэх санал бүхий тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

Захиалагч ТШӨХ-д тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд тендерийн үнийн ТШӨХ-д заасан ***хувь***[2]– иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

Барааг хуваарьт зааснаас ТШӨХ-д заасан ***[тоо]***[3] илүү сар хоцроож хүргэхийг санал болгосон тендерээс татгалзана.Харин ТШӨХ-д захиалагч тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон бараа нийлүүлэлтийн хуваариас хойш нийлүүлэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

*(б) Төлбөрийн хуваарийн зөрүү.* ***"ашиглана"***

***[ашиглах бол дараах шалгуурын аль тохирохыг сонгож үлдээ]***

(i) Тендерт оролцогч ГТН-д заасан төлбөрийн хуваарь (Төлбөрийн нөхцөл)-ийн дагуу үнийг ирүүлнэ. Тендерийг үнэлэхдээ энэхүү суурь үнэд үндэслэнэ.Тендерт оролцогч төлбөрийн хуваарийг өөр хувилбараар ирүүлж, энэ хуваарийн дагуу тендерийн хөнгөлөлттэй үнэ санал болгон ирүүлж болно.Захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлж шалгарсан оролцогчийн хувилбарт төлбөрийн хуваарийг авч үзэж болно.

**эсхүл**

---

2 Ихэвчлэн0.05 хувь.

3 Зөвшөөрөх хоцролтын хугацааг орлуулж бичнэ.Ихэвчлэн 3 сар байна.

(ii) Захиалагчийн санал болгож буй төлбөрийн хуваарь (Төлбөрийн нөхцөл)-ийг ГТН-д тодорхой заана. Хэрэв захиалагч тендерийн баримт бичигт төлбөрийн хуваарийг захиалагчийн санал болгосноос зөрүүтэй ирүүлэхийг зөвшөөрөхөөр заасан тохиолдолд ийм зөрүүтэй төлбөрийн хуваарь санал болгож буй тендерийг үнэлэхдээ ТШӨХ-д заасан жилийн хүүгийн жишгээр тооцож ийнхүү зөрүүтэй хуваарийн дагуу эрт төлбөр авснаар олж болох хүүгийн орлогыг харгалзана.

*(в) Тендерийн дагуу санал болгож байгаа бараа (тоног төхөөрөмж)-ны гол эд анги, зайлшгүй шаардлагатай сэлбэг хэрэгсэл болон үйлчилгээний зардал:**[Үнэлгээнд энэ шалгуурыг "ашиглана" эсхүл "ашиглахгүй" гэж оруул.]***

***[ашиглах бол дараах шалгуурын аль тохирохыг сонгож үлдээ]***

ТШӨХ-ийн 19.1(б) зүйлд заасан, ашиглалтын эхний хугацааныдотор шаардагдаж болох гол эд анги, бүрдэл хэсэг болон сэлбэг хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээний жагсаалтыг барааны жагсаалтанд оруулсан байна. Ингэхдээ гол эд анги бүрдэл хэсэг болон сэлбэг хэрэгслийн үнийг тендерийн үнээс тусад нь ирүүлэх ёстой. Тендер бүрийн үнийн саналд дурдсан нэгж үнэд тулгуурлан дээрх жагсаалтанд орсон эд зүйлсийн нийт үнийг тендерийн үнэдээр үнэлгээний зорилгоор хийсвэрээр нэмж тохируулга хийнэ.

**Эсхүл**

Захиалагч барааны өндөр хэрэглээний ба өндөр үнэ цэнэ бүхий эд анги болон сэлбэг хэрэгслийн жагсаалтыг Тендерийн баримт бичгийн 19.1(б) дахь хэсэгт заасан үйл ажиллагааны эхний үе шатанд хэрэглэгдэх тоо хэмжээний хамт бэлтгэнэ. Тендерийг үнэлэх зорилгоор эдгээр хэрэглэгдэхүүн болон тэдгээрийн тоо хэмжээнд харгалзах нийт үнийг тооцохдоо тендерт оролцогчийн ирүүлсэн сэлбэг хэрэгслийн нэгжийн үнийг тендерийн үнэдээр нэмнэ.

*(г) Тендертсанал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны борлуулалтын дараах үйлчилгээг захиалагчийн байгаа улсад үзүүлэх боломж:**[Үнэлгээнд энэ шалгуурыг "ашиглана" эсхүл "ашиглахгүй" гэж оруул.]***

ТШӨХ-ийн35.2 (г)-д тусгайлан заасан бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж тохируулга хийнэ.

*(д) Тендерийн дагуу санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны ашиглалтын болон хэвийн ажиллагааг хангахад шаардагдах зардал: [Үнэлгээнд энэ шалгуурыг "ашиглана" эсхүл "ашиглахгүй" гэж оруул.]*

ТШӨХ-ийн 35.2 (г)-дтусгайлан заасан бол тендерт санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны ашиглалтын болон хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зардлын дүнг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж тохируулга хийнэ. Үнэлгээний тохируулгыг дараах аргачлалын дагуу тооцно.

Тооцоонд ашиглах ашиглалтын зардлын хүчин зүйл нь:

1. эхний ашиглалтын хугацаа ***[тоо]***[4] жилээр;
2. жил тутамд гарах ашиглалтын зардал ***[хүчин зүйлс буюу гарах зардлын нэр төрлийг жагсаана]***[5];

4 Ердийн тохиолдолд эхний ашиглалтын хугацаа нь эхний их засвар хийгдэх хүртэлх хугацаа байхыг зөвлөж байна.Ихэнх тохиолдолд 5-10 жил байна.

5 Жишээлбэл, шатахуун, эсхүл бусад тэжээл, түүний нэгж үнэ, нэг жилийн болон нийт ашиглалтын хугацааны зарцуулалт.

3. 2-т заасан зардлын 1-т заасан хугацаанд гарах жил бүрийн ирээдүйн зардлын өнөөгийн үнэ цэнийг тооцоход хэрэглэсэн дискаунтчилах /хорогдуулж тооцох/ хувь.

(е) *Тендертсанал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны үр ашиг болон үйл ажиллагааны баталгаа:* ***"ашиглахгүй"***

***[дараах шалгуурын аль нэгийг сонго]***

ТШӨХ-ийн 35.2 (г)-дтусгайлан заасан бол тендерт санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны ашиглалтын нийт хугацаанд шаардагдах нэмэлт зардлын дүнг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж тохируулга хийнэ. Үнэлгээний тохируулгыг санал болгож буй барааны үйл ажиллагаа буюу үр ашгийн баталгааны доод түвшинд түшиглэн ТШӨХ-ийн **35.2** (г)-д заасан аргачлалын дагуу хийнэ.

1. Тендерт оролцогч санал болгож буй бараандаа техникийн тодорхойлолтод нийцсэн үйл ажиллагаа, үр ашиг болон ашиглалтын баталгаа гаргана. Санал болгосон бараа нь техникийн тодорхойлолтод заасан ашиглалт, үйл ажиллагааны баталгааны доод түвшинг (эсхүл зарим тохиолдолд дээд түвшинг) хангасан тохиолдолд шаардлагад нийцсэн гэж үзнэ. Энэ доод түвшинг (эсхүл зарим тохиолдолд дээд түвшинг) хангаагүй бараа санал болгосон тендерээс татгалзана.

2. Техникийн тодорхойлолтод заасан ашиглалт, үйл ажиллагааны баталгааны доод түвшингээс дутсан (эсхүл илүү гарсан) зөрүүг үнэлгээнд харгалзах зорилгоор дутагдал (эсхүл илүүдэл) бүрт тохируулах итгэлцүүр[6] тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

**Эсхүл**

ТШӨХ-ийн 35.2 (г)-дтусгайлан заасан бол тендерийн дагуу санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны үр ашгийн байдлыг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж тохируулга хийнэ.
Үнэлгээний тохируулгыг хийхдээ техникийн тодорхойлолтонд заасан хамгийн бага үнэ цэнийг харгалзан үзэж санал болгосон барааны бодит бүтээмжийн нэгжид оногдох үнэд түшиглэн, ТШӨХ-ийн 35.2(г)-д заасан аргачлалыг мөрдлөгө болгоно.

(ё) *Барааны дотоодын тээвэрлэлт, даатгал болон бусад зардал:* ***"ашиглана"***

Монгол Улсын гаднаас санал болгох барааны орох боомтоос захиалагчийн агуулах хүртэл, эсхүл Монгол Улсын дотроос санал болгох барааг үйлдвэрлэгчээс захиалагчийн агуулах хүртэл дотоодын тээвэрлэлт, даатгал болон бусад зардлыг үнэлгээний зорилгоор тендерийн EXW, CIF, CIP, эсхүл FOB үнэ дээр нэмнэ.

(ж) *Тусгайлсан* нэмэлт шалгуур
Хуулийн 28.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэхүү тендерийн үнэлгээнд ашиглах бусад нэмэлт шалгуур үзүүлэлт болон түүний аргачлалыг энэ хэсэгт оруулж болно.

**Олон багцтай тендерийг үнэлэх**

ТӨЗ-ны 35.6-д заасны дагуу захиалагч нэг ба түүнээс дээш багцаар гэрээ байгуулах эрхтэй бол олон багцыг үнэлж гэрээ байгуулах эрх олгоход дараах аргачлалыг мөрдөнө.

Захиалагч багцуудын хамгийн сайн үнэлэгдсэн буюу хамгийн үр ашигтай байх хувилбарыгдараах байдлаар сонгоно. Үүнд:

---

6 Энэ тайлбарыг тендерийн баримт бичигт үлдээнэ. Тендерийн үнэлгээнд ашиглах тохируулах итгэлцүүр нь техникийн тодорхойлолтын ***[холбогдох зүйлийн дугаарыг бичнэ үү]***-т заасан хэмжээнээс, эсхүл хамгийн сайн ашиглалт, үйл ажиллагааны баталгааны үзүүлэлтийг санал болгосон тендерийн уг хэмжээнээс 1 хувь дутах (илүү гарах) бүрт ***[дүн, тендерийн үнэлгээний валютаар]*** тооцно. Бүхэл хувь хүрэхгүй бол энэ дүнг мөн харьцаагаар бууруулна.

(а) ТОӨЗ-ны 15.8-д зааснаар багц тус бүрт байх барааны нэр төрөл болон нэр төрөл тус бүрийн тоо хэмжээ нь бүрэн бол тухайн багцад үнэлгээ хийнэ.

(б) Үнэлгээнд дараах журмыг баримтална:

(i) багц тус бүрт үнэлгээний шалгуурыг хангасан хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг тогтоох;

(ii) тендерт оролцогчийн тухайн хамгийн сайн үнэлэгдсэн тендерт санал болгосон үнийн хөнгөлөлтийг санал болгосон аргачлалын дагуу багц тус бүрт тооцох;

(iii) эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай байх хувилбараар гэрээ байгуулах эрх олгохоор сонгох. Ингэхдээ нэг тендерт оролцогч 2 ба түүнээс дээш багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн бол түүний гэрээг хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаж тогтооно. Хэрвээ тухайн оролцогч 2-оос дээш багцад гэрээ хэрэгжүүлэх чадвар нь хангалтгүй гэж үнэлэгдвэл түүний чадавхид тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## ТЕНДЕРШАЛГАРУУЛАЛТЫН МАЯГТ

**Тендер шалгаруулалтын маягтыгбөглөх санамж**

Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагын дагуу тендерийн маягт, үнийн хуваарийг бөглөж, энэ бүлэгт заасан маягтаар гаргасан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.

Арифметик алдаа, хүлээн зөвшөөрөгдөх зөрүү (төлбөрийн хуваарь, барааг хүргэх хуваарь гэх мэт), сэлбэг болон барааны тоо ширхэгийг тендерийн баримт бичгийн дагуу залруулж, өөрчилсний дараа гэрээний маягтад гарын үсэг зурна.

Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг энэ бүлэгт заасан маягтаар ирүүлэх үүрэгтэй. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэх шаардлагагүй бол урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтыг тендерийн баримт бичигт хавсаргахгүй.

**МАЯГТ №: ТШМ-1**

# ТЕНДЕРИЙН МАЯГТ

***[огноо]***

***(Захиалагч байгууллагын нэр)***-ын дарга ____________________танаа

1. Бид, ***[тендерт оролцогчийн нэрийг оруул],*** энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн ***[бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]***-г ***[тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул]*** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.

2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш ***[тоо]*** хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.

3. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт ***[үзүүлнэ эсхүл үзүүлэхгүй гэдгийн аль нэгийг оруулах] [Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул]*** үзүүлнэ.

4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс ***[тоо]*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.

6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**МАЯГТ №: ТШМ-2А**

**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН**
**БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

Огноо:_________________

(А ангилал)

НТШ-ын дугаар: ______________

Тендерийн урилгын дугаар: ___

Хувилбарт тендерийн дугаар: _________

Хуудасны ____ -ын _____ дугаар ___

ТӨӨЗ-ны 16-д заасан валютаар

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл | Барааны тодорхойлолт | Гарал үүслийн улс | Тоо ширхэг болон эд анги | EXW нэгж үнэ | Нэр төрөл бүрийн EXWбүгд үнэ (4x5) | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТӨӨЗ-ны 15.9.(а).(3)-д шаардсан бол) | Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баганад заасан үнэд эзлэххувь | ТӨӨЗ-ны 15.9(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9) |
| | | | | | | | | | |
| **Тендерийн нийт үнэ (10)** | | | | | | | | | |

Тендерт оролцогчийн нэр ___________________ Гарын үсэг ____________________ Огноо ____________________

**МАЯГТ №: ТШМ -2Б**

## МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ БАРААНЫҮНИЙНХУВААРЬ

Огноо: ______________________

НТШ-ын дугаар: ___________________

Тендерийн урилгын дугаар: ________

(Б ангилал) Хувилбарт тендерийн дугаар: ______

Хуудасны ________ –ын _______

ТӨОЗ-ны 16-д заасан валютаар

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл № | Бараан ы тодорх ойлолт | Гарал үүслийн улс | Тоо ширхэг | ТӨОЗ-ны 15.9 (б) (1)-д заасан СИФ эсхүл СИП нэгж үнэ | Нэр төрөл бүрийн СИФ эсхүл СИП нийт үнэ (4 x 5) | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТӨОЗ-ны 15.9(б).(3)-д шаардсан бол) | ТӨОЗ-ны 15.9(б).(2)-д зааснаар гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж | Нэр төрлийн нийт дүн (6 + 7+8) |
| | | | | | | | | |
| **Тендерийн нийт дүн (9)** | | | | | | | | |

Тендерт оролцогчийн нэр ___________________ Гарын үсэг ____________________ Огноо ___________________

**МАЯГТ №: ТШМ -2B**

## МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРУУЛЖ ИРСЭН БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

Огноо: ______________________

НТШ-ын дугаар: ___________________

Тендерийн урилгын дугаар: ________

(B ангилал)

Хувилбарт тендерийн дугаар: _______

Хуудасны ________ –ын _______

ТӨӨЗ-ны 16-д заасан валютаар

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл № | Барааны тодорхойлолт | Гарал үүслийн улс | Инкотермд тусгасны дагуу хүргэх огноо | Тоо ширхэг | ТӨӨЗ-ны 15.9 (в) (1)-д заасан урьд нь төлсөн болон төлөх гаалийн татвар хураамж болон импортын татварыг оруулсан нэгж үнэ | ТӨӨЗ-ны 15.9(в).(2)-д заасан нэр төрөл бүрт төлсөн гаалийн болон импортын татвар хураамж [нотлох бичиг баримтыг үндэслэнэ] | ТӨӨЗ-ны 15.9 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн татвар хураамж болон импортын татварыг хассан) (6 – 7) | ТӨӨЗ-ны 15.9 (в) (3) (9=8x5)-д заасны дагуу гаалийн болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн үнэ | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (ТӨӨЗ-ны 15.9(в) (5)-д шаардсан бол) | Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ (9+10+11) |
| | | | | | | | | | | | |
| **Тендерийн нийт үнэ (12)** | | | | | | | | | | | |

**Тендерт оролцогчийн нэр ___________________ Гарын үсэг ____________________Огноо ____________________**

**МАЯГТ №: ТШМ-3А**

## 3. ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТАЛГАА)

***[Захиалагч байгууллагын нэр]***

*[Тендерт оролцогчийн нэр]* (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь *[Тендер шалгаруулалтын нэр]* бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар *[Банкны нэр]* (цаашид “Банк” гэх) нь *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт *[мөнгөн дүн]*–ийн[7] төлбөр хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

(1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;

(2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:

(а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;

(б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;

(в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь ***[огноог оруул]***өдрийгдуустал хүчинтэй.Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

---

[7] Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана.Баталгааний мөнгөн дүн нь ТӨЗ-ны21.1-д заасантай ижил байна.

Огноог оруулахдаа ТӨЗ-ны 21.3-т заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байхаар тооцож оруулна.

**МАЯГТ №: ТШМ-3Б**

# ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
# (ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН БАТАЛГАА)

***[Захиалагч байгууллагын нэр]***

*[Тендерт оролцогчийн нэр]* (цаашид "Тендерт оролцогч" гэх) нь *[Тендер шалгаруулалтын нэр]* бараа нийлүүлэхээр тендер (цаашид "Тендер" гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар *[Хөрөнгийн бирж]* (цаашид "Бирж" гэх) нь *[захиалагчийн нэр]* (цаашид "захиалагч" гэх)-ийн өмнө нийт *[мөнгөн дүн]*–ийн[8] төлбөр хийх үүрэг хүлээж тендерт оролцогчийн засгийн газрын бондыг[9] үндэслэн батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

(2) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;

(3) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:

(а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;

(б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;

(в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй засгийн газрын бондыг үл маргалдах журмаар шилжүүлнэ.

Энэхүү баталгаа нь ***[огноог оруул]***[11]өдрийг дуусталхүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж биржидмэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банк/Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Биржийнтамга

Огноо:

Хаяг:

---

[8] Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Энэ дүн нь ТӨОЗ-ны 21.1-д заасантай ижил байна.

[9]Засгийн газрын бондын эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

[11]Огноог оруулахдаа ТӨОЗ-ны 21.3-т заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байхаар тооцож оруулна.

**МАЯГТ №: ТШМ-4**

**Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн итгэмжлэл**

*[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчаар энэ маягтыг бөглүүлсэн байна.Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн албан бланкан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна.ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]*

Огноо: *[тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]*
НТШ-ын дугаар: *[оруул:тендер шалгаруулалтын дугаар]*
Хувилбарын дугаар: *[оруул:энэнь хувилбарт тендер бол ялгах дугаар]*

*(Захиалагч байгууллагын нэр)*-ын дарга ______________________________танаа

Бид, ***[оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]***-д байршилтай ***[оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүрэн нэр]*** нь***[оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]***-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд үүгээр ***[оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр]*** компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан ***[оруул: барааны нэр ба товч тодорхойлолт]***, барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 14-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**5. Чадварын мэдээлэлирүүлэх маягтууд**

**МАЯГТ №: ТШМ-5А**

**Санал болгож буй туслан гүйцэтгэгч**

| | Зүйл | Туслан гүйцэтгэгчийн нэр | Бүртгэгдсэн газар болон чадавхи |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

**МАЯГТ №: ТШМ-5Б**

**Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага**

| Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр |
|---|

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

| | | |
|---|---|---|
| 1. | Гэрээний дугаар | |
| | Гэрээний нэр | |
| | Улсын нэр | |
| 2. | Захиалагчийн нэр | |
| 3. | Захиалагчийн хаяг | |
| 4. | ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлог | |
| 5. | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>Үндсэн нийлүүлэгч  Туслан гүйцэтгэгч  Түншлэлийн гишүүн | |
| 6. | Гэрээ/туслан гүйцэтгэх гэрээ/түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн/-ний үнийн дүн (гэрээ байгуулагдах эсхүл дуусгавар болсон үеийн мөнгөний нэгжээр илэрхийлсэн гэрээний дүн байна)<br>Мөнгөний нэгж Мөнгөний нэгж Мөнгөний нэгж | |
| 7. | Гэрээний дүн:_______; Туслан гүйцэтгэх гэрээ: _______; Түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн: _______; | |
| 8. | Гэрээ байгуулсан/дуусгавар болсон огноо | |
| 9. | Гэрээ нь хуваарьт хугацаанаас _____ сарын өмнө/дараа дууссан. (хэрэв хоцорч дууссан бол тайлбарлах) | |
| 10. | Гэрээ нь гэрээний үндсэн үнийн дүнгээс _________ дутуу/илүү дүнгээр дуусгавар болсон. (хэрэв илүү гарсан бол тайлбарлах) | |
| 11. | Техникийн тусгай шаардлагууд. | |
| 12. | Нийт гэрээний үнийн дүнд туслан гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэсэн дундаж хувийн жин, тухайн эх сурвалжийг тусгах. | |

**МАЯГТ №: ТШМ-5В**

**Нэгдсэн хүснэгт: Одоо хэрэгжиж буй гэрээ**

| Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр |
|---|

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр өөрсдийн хэрэгжүүлж буй буюу одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээг дуусгахаар төлөвлөсөн хугацаа | Дараагийн 6 сард нэхэмжлэх үнийн дүнгийн сарын дундаж |
|---|---|---|---|---|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

**МАЯГТ №: ТШМ-5Г**

## Санхүүгийн чадавхи

| Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр |
|---|

Тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүрийг оролцуулан ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзахТШӨХ-д заасан шаардлагыг хангаж буйгхаруулсан санхүүгийн мэдээллийг ирүүлнэ.Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр энэ маягтын дагуу өөрийн холбогдох мэдээллийг ирүүлнэ.Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө.Татварын албанд тушаасан (захиалагч шаардсан бол аудитаар баталгаажуулсан байх) санхүүгийн тайланг нотлох баримт болгон энд хавсаргана.

| Банк | Банкны нэр | |
|---|---|---|
| | Банкны хаяг | |
| | Утас | Холбоо барих ажилтны нэр, албан тушаал |
| | Факс | Телекс |

Сүүлийн (**ТШӨХ-д заасан тоо**)хүртэлхжилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр (хөрвүүлэх ханш нь тухайн жил бүрийн эцсийн байдлаар мөрдөгдөж байсан Монгол банкны зарласан ханш байна) илэрхийлнэ.

| Санхүүгийн мэдээлэл /сая/ | Сүүлийн (**ТШӨХ-д заасан тоо**) хүртэлх жилийн хугацаанд | | | | | Төлөвлөсөн: Дараагийн 2 жилийн хугацаанд | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | 4 | 3 | 2 | 1 | 1 | 2 |
| 1. Нийт хөрөнгө | | | | | | | |
| 2. Эргэлтийн хөрөнгө | | | | | | | |
| 3. Нийт өглөг | | | | | | | |
| 4. Эргэлтийн өглөг | | | | | | | |
| 5. Татварын өмнөх ашиг | | | | | | | |
| 6. Татварын дараах ашиг | | | | | | | |

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг хангаж гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан хөрвөх хөрөнгө, зээл авах боломж буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

| Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр | Дүн |
|---|---|
| 1. | |
| 2. | |
| 3. | |
| 4. | |

ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-дзаасан хугацааны (тендер оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр) аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, түүнд хийсэн тайлбарыг хавсаргана.

Хэрэв тендерт оролцогчийн улсын хуулиар аудитын баталгааг шаарддаггүй бол хувийн байгууллагын санхүүгийн тайланг эрх бүхий бүртгэгдсэн нягтлан бодогч болон татварын байгууллагын тодорхойлолтын хуулбарыг хавсаргана.

**МАЯГТ №: ТШМ-5Д**

**Ажиллах хүчний чадавхи**

| Тендерт оролцогчийн нэр |
|---|

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллахтай холбогдох ур чадвар, мэргэжлийн шаардлагыг хангасан, хамгийн багадаа 2 хүний нэрийг албан тушаал тус бүрт дэвшүүлнэ.Нэр дэвшигч бүрийн ажлын туршлагын талаарх мэдээллийгтус тусад нь гаргаж ирүүлнэ.

Тендерт оролцогч нь гэрээг удирдах, хэрэгжилтийн зохион байгуулах хувилбарт нэр дэвшигчийн ажлын туршлага, ур чадварын талаарх мэдээллийг мөн ирүүлнэ.

| | |
|---|---|
| 1. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |
| 2. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |
| 3. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |
| 4. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |

**МАЯГТ №: ТШМ-5Е**

## Шинэчилсэн үнийн хуваарь

Шинэчилсэн үнийн хуваарь нь гэрээний нэг хэсэг болох бөгөөд нийлүүлэгчийн ирүүлсэн тендер дэх үнийн хуваариас ялгаатай байвал түүнийг орлоно.Энэ шинэчилсэн үнийн хуваарь нь 33.1 дүгээр зүйлд заасны дагуу аливаа залруулга, тохируулгыг тусгана.

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

## ТАВДУГААР БҮЛЭГ
## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### АГУУЛГА

**Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлагыг бэлтгэх санамж**

Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага нь тендерийн баримт бичгийн бүрдэл хэсэг бөгөөд үүнд нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээний тодорхойлолт, нийлүүлэлтийн хуваарь зэргийг багтаасан байх ёстой.

Бараа нийлүүлтэд тавигдах шаардлагын зорилго нь тендерийг оновчтой, сайтар бэлтгэхэд тендерт оролцогчийг шаардагдах мэдээллээр хангах ялангуяа үнийн хуваарийг бэлтгэхэд туслах явдал юм.Үүний зэрэгцээ гэрээ байгуулах эрх олгох явцад барааны тоо хэмжээнд өөрчлөлт оруулах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарь болон үнийн хуваарьт тулгуурладаг.

Инкотермсийн(EXW, CIF, FOB болон FCA) нөхцөлд нийцүүлэн бараа нийлүүлэлтийн хуваарьт тодорхойлсон нийлүүлэлтийн хугацаанаас үүдэх үр дагаврууд, мөн нийлүүлэлттэй холбоотойгоор захиалагчийн хүлээх үүрэг(гэрээ байгуулах эрх олгох, гэрээнд гарын үсэг зурах, аккердитив нээх, баталгаажуулах гм.)-ийн хугацаа зэргийг харгалзан бараа нийлүүлэх огноо буюу хугацааг оновчтой тодорхойлбол зохино.

## 1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

*[Захиалагч энэхүү хүснэгтийн1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө ].*

| **Нэр** | **Барааны тодорхойлолт** | **Тоо ширхэг** | **Хэмжих нэгж** | **ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)** | **Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа** | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа** | **Бараа нийлүүлэх эцсийн хугацаа** | **Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа *(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө*)** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |

**2.**

*[Энэхүү хүснэгтийг захиалагч бөглөнө. Үйлчилгээг гүйцэтгэх дуусах хугацааг аль болох бодитой байхаар тооцон, бараа нийлүүлэх хугацаатай уялдуулан тогтооно].*

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл | Үйлчилгээний талаархи тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай | Үйлчилгээг гүйцэтгэж дуусгах огноо |
| | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

## 3. Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай байгаа бараа болон холбогдох үйлчилгээний техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлоход оршдог.

Ойлгомжтой бөгөөд сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана.Эдгээрийг хангасан нөхцөлд л худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийг үнэлэх үнэлгээ зөв явагдана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, орчин үеийн загварын, мөн зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардвал зохино.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана.Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй.Бүх төрлийн барааны стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой.Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй.Бараа, материалын, техникийн тодорхойлолтодаль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

### Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал, тэдгээрийг турших стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ.Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө.

Барааны тэмдэг, каталогийн дугаарыг заасан шаардлагыг аль болох тавихгүй байна.Зайлшгүй шаардлагын улмаас эдгээрийг хэрэглэх бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэж нэмж заана.

Шаардлагатай тохиолдолд захиалагч зураг болон ажлын талбайн төлөвлөгөөг тендерийн баримт бичгийн хамт тендерт оролцогчдод өгнө.Үүнд мөн тендерт оролцогч зураг болон загварыг тендертэй хамт, эсхүл гэрээний хэрэгжилтийн явцад захиалагчид урьдчилан хянуулах зорилгоор ирүүлэхээр зааж болно.

Хэрвээ захиалагч техникийн тодорхойлолтын хураангуйг гаргуулахаар бол дараах хүснэгтийг ашиглан шаардлагатай мэдээллийг тусгаж өгнө.Тендерт оролцогч санал болгож буй бараа, үйлчилгээ нь уг шаардлагад нийцэж байгаа эсэхийг ижил хүснэгтээр харуулна.

**Техникийн тодорхойлолтын хураангуй.**Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

| ***Нэр төрлийн дугаар*** | ***Бараа болон холбогдох үйлчилгээний нэр*** | ***Техникийн тодорхойлолт болон стандарт*** |
|---|---|---|
| *1* | | |
| *2* | | |
| *3* | | |

## 4. Зураг, төсөл

Тендерийн баримт бичигт зураг, төсөл ирүүлэх шаардлагатай бол дараах хүснэгтийг ашиглана.

| Зураг төслийн жагсаалт | | |
|---|---|---|
| **Зураг, төслийн дугаар.** | **Зураг төслийн нэр** | **Зориулалт** |
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |

## 5. Шалгалт, туршилт

Захиалагч шаардлагатай бол нийлүүлэгдэх барааны хувьд хийгдсэн байх ёстой үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардаж болно.

## ГУРАВДУГААР ХЭСЭГ

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

**Гэрээний ерөнхий нөхцөлийн санамж**

Гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцөл, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх үүргийг тодорхойлох баримт бичиг болно.

Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулах шаардлагатай бол үүнийг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## ГАРЧИГ

1. Нэр томъёо
2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
3. Захиалгыг өөрчлөх
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах
6. Барааны гарал үүслийн улс
7. Шалгалт, туршилт
8. Баглаа боодол
9. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт
10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх
11. Гүйцэтгэлийн баталгаа
12. Даатгал
13. Чанарын баталгаа, баталгаат засвар
14. Төлбөр
15. Үнэ
16. Хуваарийг сунгах
17. Алданги оногдуулах
18. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
21. Маргааныг шийдвэрлэх
22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
23. Гэрээний үүргийг шилжүүлэх
24. Гэрээнд ашиглах хэл
25. Татвар, хураамж
26. Гарчиг
27. Үүргийн гүйцэтгэл

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

**1. Нэр томъёо**

1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

(а) “гэрээ”гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.

(б) “гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.

(в) “бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.

(г) “бусадүйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.

(д) “захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.

(е) “нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.

(ж) “ажлын талбай” гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.

(з) “хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.

**2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах**

2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй.Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.

2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.

2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.

2.4. Захиалагчнийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.

**3. Захиалгыг өөрчлөх**

3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:

(а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;

(б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;

(в) барааг хүргэх газар.

3.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид “өөрчлөлт” гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.

3.3. Захиалагч 3.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.

3.4. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзол үйлчилнэ.

**4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**

4.1. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй.Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.

**5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах**

5.1. Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдол нийлүүлэгч гэрээ болон түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.

5.2. Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.

**6. Барааны гарал үүслийн улс**

6.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.

6.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ.Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

**7. Шалгалт болон туршилт**

7.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй.Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

7.2. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.

7.3. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.

7.4. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.

7.5. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.

**8. Баглаа боодол**

8.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.

8.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичигийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.

**9. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**

9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ.Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна.Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ.Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.

9.2. Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.

**10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**

10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.

**11. Гүйцэтгэлийн баталгаа**

11.1. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.

11.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана.Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.

11.3. Гүйцэтгэлийн баталгаа нь ТӨӨЗ-ны 16 дугаар зүйлд заасан валютаар гаргасан банкны баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр гаргасан баталгаа байна.

11.4. Нийлүүлэгч гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.

**12. Даатгал**

12.1. ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг ГТН-д заасан хэлбэрээр инкотермсийн нөхцөлийн дагуу даатгуулна.

**13. Чанарын баталгаа, баталгаат засвар**

13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.

13.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.

13.3. Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.

13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.

13.5. Захиалагч нь 13.2 заасныг үл харгалзан, 13.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.

13.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй.Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.

**14. Төлбөр**

14.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.

14.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болонГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.

14.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээнавснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.

14.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.

**15. Үнэ**

15.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана.ГТН-ийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.

**16. Хуваарийг сунгах**

16.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

16.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:

(а) захиалагч ГЕН-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;

(б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);

(в) ГЕН-ийн 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл;

(г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.

Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.

16.3. Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.

**17. Алданги оногдуулах**

17.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй.Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч ГЕН-ийн 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.

**18. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах**

18.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:

(а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;

(б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;

(в) нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;

(г) нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.

18.2. 18.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд захиалагч нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна.Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

**19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах**

19.1. Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй.Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй.Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрхийг, хөндөхгүй.

**20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах**

20.1. Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй.[10]Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.

20.2. Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна.Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ. Үүнд:

(а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах,болон/эсхүл

[10]Захиалагч гэрээг цуцлах шийдвэрийг холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрөлтэйгээр зөвхөн зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргана.

(б) үлдэх бараag цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.

**21. Маргааныг шийдвэрлэх**

21.1. Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.

21.2. Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.

**22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал**

22.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

22.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ.Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

**23. Гэрээний үүргийг шилжүүлэх**

23.1. Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

**24. Гэрээнд ашиглах хэл**

24.1. Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.

24.2. 24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.

**25. Татвар болон хураамж**

25.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.

**26. Гарчиг**

26.1. Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.

**27. Үүргийн гүйцэтгэл**

27.1. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.

# ДОЛООДУГААР БҮЛЭГ

# ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

**Гэрээний тусгай нөхцөлийг бэлтгэх санамж**

Гэрээний ерөнхий нөхцөлд дурдсан захиалагч, бараа зэрэг нэр томьёо тухайн гэрээнд юуг илэрхийлэхийг гэрээний тусгай нөхцөлд заадаг. Гэрээний тусгай нөхцөлийг бэлтгэхдээ дараах зүйлсийг шалгана. Үүнд:

1. Гэрээний ерөнхий нөхцөлийн аль нэг зүйлд гэрээний тусгай нөхцөлийг ишилсэн бол холбогдох нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд заавал оруулна.

2. Тухайн гэрээний шаардлагаар гэрээний ерөнхий нөхцөлийг засварлах, илүү дэлгэрүүлэх тохиолдолд эдгээрийг гэрээний ерөнхий нөхцөлд бус тусгай нөхцөлд тусгана.

3. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН) болон гэрээний тусгай нөхцөл (ГТН) хоорондоо зөрчилдсөн тохиолдолд гэрээний тусгай нөхцөлийг баримтлана. Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйлийн дугаарыг хаалтад хийж ишлэв.

4. ГТН-ийг хэрхэн бэлтгэх тухай зааврыг [ ] дөрвөлжин хаалтанд бичив. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч боловсруулна.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | | |
|---|---|---|
| **1. Тодорхойлолт (ГЕН - 1)** | 1.1.(д)<br>1.1 (ж) | Жишээ нь: Захиалагч нь ***Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ......... дугаар сургууль***<br>Жишжээ нь: Ажлын талбай нь ***Хөвсгөл аймаг, Мөрөн сум, ...... дугаар сургуулийн*** хичээлийн байр. |
| **2. Шалгалт туршилт (ГЕН - 7)** | 7.0<br>/ | • Бараа, бүтээгдхүүн, материалыг захиалагчид нийлүүлэхээс 7 хоногийн өмнө багц бүрийн бараа, бүтээгдхүүн, материал бүрт Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт,итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг зэргийг захиалагчид хүргүүлнэ.<br>• Холбогдох байгууллагын дүгнэлт, шинжилгээ байхгүй тохиолдолд захиалагч барааг хүлээн авахгүй.<br>• Барааг /мах, сүү зэрэгт хамаарна/ шошгожуулж, бүх төрлийн хүнсний материал, бүтээгдхүүний гарал үүслийн гэрчилгээг захиалагчид ирүүлсэн байна.<br>• Барааг захиалагчийн агуулахад шалгаж авна. |
| **3. Баглаа боодол (ГЕН – 8)** | 8.0 | Гүйцэтгэгч барааг тээвэрлэж гэрээнд заасан газар хүргэнэ. Нийлүүлж буй барааны баглаа боодол, шошго бүрэн бүтэн байна. |
| **4. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН – 9)** | 9.0<br>9.3 | ГЕН-ийн 9 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:[11]<br>1. Барааг захиалагчийн агуулахад хүргэж, захиалагчийн томилсон ажлын хэсэгт хүлээлгэн өгч акт үйлдэнэ.<br>2. нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан зарлагын падан нэхэмжлэхийн хувь;<br>3. барааны багц бүрийн баглаа боодлын жагсаалт;<br>4. даатгалын гэрчилгээ;<br>5. үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн чанарын баталгааны гэрчилгээ;<br>6. үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ;<br>7. барааны гарал үүслийн гэрчилгээ. Уг гэрчилгээ нь мэргэжлийн хяналтын газрын кодтой байна. |

[11]Эдгээр заалтуудыг зөвхөн жишээ болгож дурдсан / ба олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын мөрддөг жишиг/ тухайн бараа нийлүүлэлтийн онцлогт тохируулан өөрчилж болно.

8. Нийлүүлэхээр санал болгосон хүнсний бараа, бүтээгдхүүн нэг бүрт гаргасан Улсын мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт
9. Гэрээт борлуулагч байх тохиолдолд тухай бүтээгдхүүнийг нийлүүлэх талаар үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ

Энд жагсаасан бичиг баримтыг барааг хүргэх газар ирэхээс 5 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

| | | |
|---|---|---|
| **5. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН – 11)** | 11.1 | Захиалагч нь гэрээнд заасан хэмжээ бүхий барааны тодорхой хэсгийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд гэрээний төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг захиалагчид төлнө. Нийлүүлэгч нь гэрээнд заасан хэмжээ бүхий барааны тодорхой хэсгийг нийлүүлэхээс татгалзсан тохиолдолд гэрээний төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг захиалагчид төлнө. |
| **6. Даатгал (ГЕН – 12)** | 12.0 | Даатгалын тусгай шаардлага<br><br>[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрөл, валют, даатгалыг хэн төлөх тухай заалтыг энд дурдана] |
| **7. Баталгаат засвар (ГЕН-13)** | 13.0 | Чанарын баталгааны тусгай шаардлага: Гүйцэтгэгч бараа бүрт чанарын баталгаа гаргана. Чанаргүй бараа нийлүүлсэн тохиолдолд түүнийг шинэ бараагаар солих, тухайн хүнсний барааг хэрэглэх явцад хордлого, эрсдэл үүссэн тохиолдолд хохирол, хариуцлагыг нийлүүлэгч хариуцах ба барааны хадгалалтын горим зөрчснөөс үүсэн чанаргүй бараатай холбоотой үүссэн хордлого, эрсдлийг захиалагч хариуцана. |
| **8. Төлбөр (ГЕН – 14)** | | ГЕН-ийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:[12] |
| | 14.4 | “Захиалагч Монгол Улсын гаднаас болон дотоодоос санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуу төлнө:<br>-Тухайн сард нийлүүлэх барааг бүрэн нийлүүлсэн тохиолдолд бараа хүлээн авсан акт, нэхэмжлэл болон тухайн сарын нийлүүлэлтийн гүйцэтгэлийг захиалагч хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт төлбөрийг нийлүүлэгчид 100 хувь олгоно. Тухайн сард нийлүүлэх барааг бүрэн нийлүүлэгүй тохиолдолд нийлүүүлэгчид төлөх гэрээний төлбөрийг нийлүүлсэн бараанд ноогдох хэмжээгээр төлж болно. |
| **9. Үнэ (ГЕН - 15)** | 15.1 | [ТОӨЗ-ны 15.11-д үнэ тохируулах нөхцөлийг хэрэглэхийг зөвшөөрсөн тохиолдолд дараах заалтыг оруулна:]<br>Төсвийн тухай хуулийн 29.7-д зааснаар үйлдвэрлэлийн түүхий эд, бараа материалын үнэ 2 дахин өсснөөс Төсвийн тухай хуулийн 34.1.3-д |

12 Энд дурдсан заалтууд болон хувиудыг зөвхөн жишээ болгож дурдсан бөгөөд /олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын мөрддөг жишиг/ тухайн бараа нийлүүлэлтийн онцлогт тохируулан өөрчилж болно.

| | | |
|---|---|---|
| | | заасннаар улсын төсөвт тодотгол хийсэн тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэх тохируулга хийж болно<br><br>2.Зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч гэрээнд заасан нэр төрлийн бараа, материал, бүтээгдхүүний нэгж үнэ ***15-аас дээш*** хувиар хямдарсан тохиолдолд гэрээний үнийг захиалагч, нийлүүлэгч харилцан тохиролцсны үндсэн дээр бууруулах тохируулга хийнэ.<br><br>3.Гэрээг сунгах албан бичигт онцгойлон өөрөөр заагаагүй бол барааг нийлүүлэх анхны хуваариас хоцорч нийлүүлсэн хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Нийлүүлэгчээс шалтгаалан хоцорсон хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Гэхдээ гэрээний үнэ буурах үнийн тохируулгыг захиалагч эдгээр хугацаанд хийж болно.<br><br>3. Дээр зааснаас бусад тохиолдолд гэрээний үнэ, барааны тоо хэмжээ тогтмол байна. |
| **10. Алданги оногдуулах (ГЕН - 17)**[13] | 17.1 | Захиалагч нь гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарьт заасан өдрөөс хойш хугацаа хоцроосон хоног тутамд гэрээний үнийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг гэрээний төлбөрийн хамт нийлүүлэгчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний төлбөрийн 10 хувиас хэтрэхгүй.<br>Нийлүүлэгч бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан өдрөөс хойш хугацаа хүцроон нийлүүлсэн хоног тутамд гэрээний төлбөрийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлөх ба захиалагч гэрээний төлбөрийг алдангийн хэмжээгээр бууруулан нийлүүлэгчид олгоно. Алдангийн нийт хэмжээ гэрээний төлбөрийн 10 хувиаас хэтрэхгүй. |
| **11.Гэрээний гүйцэтгэл** | 18.1 | 1.Захиалагч, нийлүүлэгч талууд хамтран гэрээгээз дүгнэж акт үйлдэнэ. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн талтай холбоотой гомдлыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, сангийн яамны хууль худалдан авах ажиллагааны газар болон хяналт шалгалтын бусад байгууллагад гаргана. Гэрээний үүргээ "хангалттай сайн" үнэлгээтэй биелүүлсэн нийлүүлэгчийг аймгийн болон төрийн шагналд тодорхойлох эсхүл гэрээний үүргээ "хангалттай сайн" биелүүлсэн бол чансаатай өндөртэй гүйцэтгэгчээр үнэлж "ногоон", гэрээний үүргээ дундач үнэлгээтэй биелүүлсэн гүйцэтгэчийг анхаарал татхуйц гүйцэтгэгчээр үнэлж "шар", гэрээний үүргээ "хангалтгүй" үнэлгээтэй биелүүлсэн бол "муу гүйцэтгэчээр үнэлж "хар" жагсаалтад бүртгүүлэхээр орон нутгийн өмчийн газарт холбогдох мэдээллийг нь ирүүлнэ.<br>2.Гэрээг сунгах албан бичигт онцгойлон өөрөөр заагаагүй бол барааг нийлүүлэх анхны хуваариас хоцорч нийлүүлсэн хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Нийлүүлэгчээс шалтгаалан хоцорсон хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Гэхдээ гэрээний үнэ бууруулах үнийн тохируулгыг захиалагч гэрээний аль ч хугацаанд хийж болно. |
| **Нийлүүлэлтийн хуваарийг сунгах ГЕН-16** | 16.1 | |

3.Гэрээний үүргийн биелэлтийн болон гэрээтэй холбоотой асуудал гарвал талууд бичгээр харилцахаас гадна гэрээтэй холбоотой маргаан зөрчлийг хамтран хэлэлцэж шийдвэрлэх ба эс шийдвэрлэхэд хүрвэл шүүхээр шийдүүлнэ.

1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

Захиалагч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай шийдвэр гаргаж болно.

**Алданги ноогдуулах ГЕН-17**

17.1

а.)захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);

б.) гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл;

в.) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.

**Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах ГЕН-18**

18.1

Захиалагч нь гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарьт заасан өдрөөс хойш хугацаа хоцроосон хоног тутамд гэрээний үнийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг гэрээний төлбөрийн хамт нийлүүлэгчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний төлбөрийн 10 хувиас хэтрэхгүй.

Нийлүүлэгч бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан өдрөөс хойш хугацаа хүцроон нийлүүлсэн хоног тутамд гэрээний төлбөрийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлөх ба захиалагч гэрээний төлбөрийг алдангийн хэмжээгээр бууруулан нийлүүлэгчид олгоно. Алдангийн нийт хэмжээ гэрээний төлбөрийн 10 хувиаас хэтрэхгүй.

Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:

А)нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл захиалагчийн гэрээ сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;

Б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;

В) нийлүүлэгч 18.1.(А), 18.1.(Б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;

18.2

(Г) нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.

гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд захиалагч нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

| | | | |
|---|---|---|---|
| 11. | **Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21)** | 21.0 | Гэрээтэй холбоотой маргааныг талууд зөвшилцлийн аргаар шийдвэрлэх ба эс шийдвэрлэхэд хүрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ. |
| 12. | **Гэрээний үүргийг шилжүүлэх ГЕН-23** | 23.1 | Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. |
| 13. | **Татвар болон хураамж** | | Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна болон дотоодод оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна. |

---

Гүйцэтгэгч, захиалагч гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан үүрэг, хариуцлагыг хүлээхээс гадна дараах нөхцлийг хангана. Үүнд:

**Нэг. Захиалагчийн эрх, үүрэг**

1.1. Захиалагч нь тухайн бараа, үйлчилгээг хүлээн авах төслийн менежерийг томилж, нийлүүлэгчийн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, гэрээ дүгнэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
1.2. Төслийн менежер зөрчил гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа бараа, үйлчилгээнд зөрчил, гологдол хайх, уг бараанд шалгалт, туршилт явуулах талаарх зааварчилгааг гүйцэтгэгчид өгч, зөрчил гологдол илэрсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн өөрийн зардлаар арилгуулах, захиалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд бараа, үйлчилгээ нийлүүлэх ажиллагааг нийтэд буюу хэсэгчилэн зогсоох эрхтэй.
1.3. Гүйцэтгэгч нь барааны техникийн тодорхойлолтод заасан шаардлага, стандарт хангаагүй бараа нийлүүлсэн болон гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд, уг зөрчил гологдлыг арилгаж дуусах хүртэл хугацаагаар чанарын баталгааны хугацааг сунгана.
1.4. Гүйцэтгэгч зөрчил гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил гологдол арилгахад шаардлагатай зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулах, эсвэл чанарын баталгааны барьцаа хөрөнгөөс татан авч, зөрчил, гологдлыг арилгуулахаар өөр этгээдийг сонгон ажиллуулах эрх эдэлнэ.
1.5. Гүйцэтгэгч нь бараа нийлүүлэлтийн тодотгосон хуваарийг гэрээ байгуулж, баталгаажуулах өдрөөс өмнө төслийн менежерт ирүүлж, төслийн менежерийн санлыг тусган сайжруулах үүрэг хүлээнэ.
1.6. Чанарын баталгааны барьцаа хөрөнгийг тухайн бараа, үйлчилгээний чанарын баталгааны хугацааны туршид захиалагчийн тогтоосон дансанд байршуулна. Гүйцэтгэгч бараа үйлчилгээний гологдол, эвдрэлийг арилгасан нөхцөлд төслийн менежерийн мэдэгдлийг үндэслэн чанарын баталгааг чөлөөлнө.
1.7. Барааны чанар стандартыг тогтоох туршилт, шалгалт, тохируулга хийсэн тухай акт, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт зэрэг баримт бичгийг гэрээний тусгай нөхцлийн хавсралтанд заасан хугацаанд ирүүлээгүй, бол гүйцэтгэгчид олгох гэрээний нийт төлбөрийн 5 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг захиалагчийн дансанд суутган үлдээнэ.
1.8. Гэрээ дүгнэсэн тухай акт, бараа, үйлчилгээг хүлээн авсныг нотлох баримт бичиг, захиалагчтай байгуулсан гэрээний талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд оруулсан холбогдох байгууллагын тодорхойлолт, гүйцэтгэл тооцсон баримт бичиг зэрэг захиалагчаас шаардсан баримт материалыг гүйцэтгэгчээс захиалагчид ирүүлээгүй нөхцөлд санхүүжилт олгохоос татгалзах бөгөөд баримт бичиг иж бүрдэл хангаагүйн улмаас үүсэх хариуцлагыг захилагч хариуцахгүй

**Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

2.1. Гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолт, холбогдох стандартыг хангасан бараа, үйлчилгээг баталсан хуваарийн дагуу захиалагчид хүргэж, төслийн менежерт хүлээлгэн өгнө.

2.2. Барааг туршиж, шалгах ажиллагааг захиалагчтай хамтран хэрэгжүүлэх ба чанар стандартын шаардлага хангахааргүй гологдол бараа нийлүүлэгдсэн тохиолдолд түүнийг шинэ бараагаар сольж өгнө.

2.3. Барааг нийлүүлсний дараа гэрээ дүгнэсэн акт, төлбөрийн нэхэмжлэл,бусад шаардлагатай баримт, бичгийг захиалагчид хүргүүлж, гэрээний төлбөрийг авна.

2.4. Хэрэв чанарын буюу баталгаат засварын хугацаанд тухайн бараа ажил, үйлчилгээнд эвдрэл, гологдол гарвал нийлүүлэгч өөрийн зардлаар гологдлыг арилгах, захиалагчид учирсан хохиролыг барагдуулах үүрэг хүлээнэ.

2.5. Барааны чанар стандартыг тогтоох туршилт, шалгалт, тохируулга хийсэн тухай акт, гүйцэтгэх эрх авсан гэрээний мэдээллийг “Шилэн дансны нэгдсэн мэдээллийн сан”-д хуулинд заасан хугацаанд оруулсан тухай тодорхойлолт болон ашиглалт, засвар үйлчилгээний заавар захиалагчаас шаардсан бусад баримт бичиг зэргийг 201.. оны ...дугаар сарын ...-ны өдөр[3] захиалагчид хүлээлгэн өгнө.

2.6. Бараа, үйлчилгээний чанарын баталгааны барьцаа хөрөнгийг төрийн сан банкны холбогдох дансанд уг хугацааг дуустал байршуулна. Барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан өдрөөс эхлэн чанарын баталгааны хугацааг тооцно.

2.7. Гүйцэтгэгч нь гүйцэтгэх эрх авсан гэрээний мэдээллийг “Шилэн дансны нэгдсэн мэдээллийн сан”-д хуулинд заасан хугацаанд оруулах үүрэгтэй.

## [ДООРХИ НӨХЦӨЛҮҮДИЙГ ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛД ЗААЖ ОРУУЛНА]

| | |
|---|---|
| **Урамшуулал** | [Гэрээгээр нийлүүлэгдэх барааг хуваариас өмнө хүргэх нь захиалагчид ашигтай бол барааг хуваариас өмнө хүргэсэн тохиолдолд нийлүүлэгчид мөнгөн урамшуулал өгөх тухай нөхцөлийг оруулж болно.] |
| **Хохирлыг барагдуулах** | [Тухайн барааны шинж чанарын улмаас ямар нэг алдагдлыг (жишээлбэл бүтээгдэхүүний хариуцлагатай холбогдсон) нөхөх, эсхүл үүрэг хүлээх шаардлага үүсч болзошгүй тохиолдолд энэ тухай заалтыг ГТН-д заана.] |
| **Сэлбэг** | [Энд боломжтой бол захиалагчид шаардлагатай сэлбэг, хэрэгслийн жагсаалтыг, эсхүл захиалагчийг шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангах зорилгоор тэдгээрийг үйлдвэрлэх, нийлүүлэхийг гүйцэтгэгч зөвшөөрөх тухай заалтыг оруулна. Сэлбэгээр хангах үүргийн үргэлжлэх хугацаа, сэлбэг авах тухай захиалагчийн хүсэлтийг нийлүүлэгч хүлээн аваад ямар хугацаанд нийлүүлэх тухай заана.] |
| **Лиценз болон зөвшөөрөл** | [Барааг импортлох болон ашиглахад ямар нэг лиценз, зөвшөөрөл шаардагдах бол тус лиценз, зөвшөөрлийг гаргуулах болон холбогдох зардлыг аль тал хариуцах тухай заалтыг оруулна.] |
| **Албан бичиг солилцох** | [Захиалагч гэрээний маягтын 4 дүгээр зүйлд заасан мэдэгдлээс бусад албан бичгийг өөр хаягаар хүлээн авах, илгээх хүсэлтэй бол үүнийгээ ГТН-д заана.] |

## НАЙМДУГААР БҮЛЭГ

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

**БАТЛАВ.**

| **ЗАХИАЛАГЧ** | **НИЙЛҮҮЛЭГЧ** |
| --- | --- |
| | *“АААААААААААААА”ХХК-ИЙ ЗАХИРАЛ Н.ББББББББББББББ* |
| ______________________ (Гарын үсэг) | ______________________ (Гарын үсэг) |
| ______________________ (Албан тушаал) | ______________________ (Албан тушаал) |

***Ахмадын асрамж, үйлчилгээний төвд хүнсний материал нийлүүлэх* гэрээ. Багц-01**

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

.............................. хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэр]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ***[нийлүүлэгчийн нэр]*** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ......... оны .......... сарын ........ -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь ***[гэрээний нэр, дугаар]***-г (цаашид “бараа” гэх) ***[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]*** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг ....................................төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, ....................................... төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, .................................... төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь .................................................... нэр төрлийн барааг ............ оны ............... дугаар сарын ............ -нээс ................оны ................. дугаар сарын ................. -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

   Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   Бусад шаардлагатай баримт бичиг[14];
   Тендер ба үнийн хуваарь;
   Гэрээний ерөнхий нөхцөл;

[14] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

| **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
| --- | --- |
| *[Албан тушаал, нэр]*<br>*[Гарын үсэг]*________________________ | *[Албан тушаал, нэр]*<br>*[Гарын үсэг]*________________________ |
| ТАМГА | ТАМГА |
| *[Захиалагчийн хаяг]*<br>*[Утас/факсын дугаар]*<br>*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]* | *[Захиалагчийн хаяг]*<br>*[Утас/факсын дугаар]*<br>*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]* |

# ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
# (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

***[Захиалагч байгууллагын нэр]***

***[Гүйцэтгэгчийн нэр]*** нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь ***[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]*** (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

***[Банкны нэр]*** (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс ***[баталгааны дүн тоогоор, төгрөг][дүн үсгээр, төгрөг]***[15] –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг ***[захиалагчийн нэр]***(цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан ***[баталгааны дүн тоогоор, төгрөг][дүн үсгээр, төгрөг]***-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноог оруулах/ хугацаанд хүчинтэйбайна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга

Огноо:

Хаяг:

---

[15] Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ.Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

**УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ**
**(БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)**

***[Захиалагч байгууллагын нэр]***

***[Гүйцэтгэгчийн нэр]*** (цаашид "гүйцэтгэгч" гэх) ..… оны … дугаар сарын …-ний өдрийн … тоот ***[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]*** гэрээ (цаашид "гэрээ" гэх)-ний ерөнхий нөхцөлийн 48 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж ***[Захиалагчийн нэр]***-ийн өмнө хариуцлага хүлээж ***[Баталгааны мөнгөн дүн][үсгээр]***[16]-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

***[Банк нэр]*** (цаашид "Банк" гэх) нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс ***[баталгааны дүн тоогоор, валют][дүн үсгээр, валют]***[17]–ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу гүйцэтгэх ажил, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдөх өдөр /огноог оруулах/ хүртэлхүчин төгөлдөр байна.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

[16] Энэ дүнг банк, эсхүл санхүүгийн байгууллага бөглөх бөгөөд урьдчилгаа төлбөрийн үнийн хувийг илэрхийлнэ.Энэ нь урьдчилгаа төлбөрийн валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

[17] Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ.Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

## ХАВСРАЛТ

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендерийн урилгыг бэлтгэхсанамж**

Тендерийн урилгыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, “Босго үнэ батлах тухай” Засгийн газрын 2006 оны 22 дугаар тогтоол, Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-д заасны дагуу бэлтгэж, зарлан мэдээлнэ.

Тендерийн урилгын зорилго нь эрх бүхий тендерт оролцогчид тендер шалгаруулалтад оролцох боломж олгож энэ тухай шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

Урьдчилсан сонголт явуулсан нөхцөлд урилга болон тендерийн баримт бичгийг зөвхөн урьдчилсан сонголтод шалгарсан оролцогчдод илгээж, тендер шалгаруулалтад оролцуулна.

**ТЕНДЕРИЙН УРИЛГА**

Огноо : 2020.04.20

Тендер шалгаруулалтын нэр: Ундны усны худаг (Хөвсгөл, Мөрөн сум 10,11,12,13,14 дүгээр баг) гүйцэтгэлтэй ажлын гүйцэтгэгч сонгох.

Тендер шалгаруулалтын дугаар: БХБЯ/202001065/1.2.15

***Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газарт*** эрх бүхий тендерт оролцогчдоос Ундны усны худаг (Хөвсгөл, Мөрөн сум 10,11,12,13,14 дүгээр баг) ажил-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн (www.tender.gov.mn цахим системээр) тендер ирүүлэхийг урьж байна. Багцтай .

Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, олны өтөгт гүний худаг

Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг*)* цахим хэлбэрээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь ***50,000*** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн ***30*** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь захиалагчийн санал болгож буй төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **30 хувь байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ/, мөн онуудын санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх,**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын дундаж өртөг: **Сүүлийн 2 жил (2018, 2019 онууд)-ийн хугацаанд доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй авто замын барилга угсралтын ажилтай ижил төстэй ажлыг нийлүүлэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх ба уг гэрээ (ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа нийлүүлсэн тэр гэрээ)-ний үнэ нь энэ тендерт санал болгож буй ажлын төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагатай. Үүнд**

Тендерийн хамт

Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, олны өтөгт гүний худаг – 1,400,000 төгрөг

Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох - 600,000 төгрөг дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

***Тендерийн баталгааны хугацаа 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хүчинтэй.***

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаархи мэдээллийг шалгана.

Тендерийг ***2020 оны 5 дугаар сарын 18 -ны өдрийн 11 цаг 20 минут****–*аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг ***2020 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн, 11 цаг 40 минут****-д* нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх**: Эрхгүй**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Төлбөрийн хийх хэлбэр: **цахим хэлбэрээр.**

Банкны нэр: **Төрийн сан**

**Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар, аймгийн ЗДТГ-ын А байр, 114 тоот өрөө,**

**утас: 70388849, 70388848, 70388821, 95490203, факс: 70388849**

## АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

*БАТЛАВ: ЗАСАГ ДАРГА* *Л.ГАНБОЛД*

*ХЯНАСАН: ОНӨГ-ЫН ДАРГА* *Б.БОЛД*

# УНДНЫ УСНЫ ХУДАГ (ХӨВСГӨЛ, МӨРӨН СУМ 10,11,12,13,14 ДҮГЭЭР БАГ) АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

| | |
|---|---|
| Тендер шалгаруулалт гэрээний нэр, | Ундны усны худаг (Хөвсгөл, Мөрөн сум 10,11,12 13,14 баг) ажлын гүйцэтгэгч сонгох |
| Дугаар: | БХБЯ/202001065/1.2.15 |

**Мөрөн сум**

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

**Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг бөглөх санамж**

Тендерт оролцогчид Захиалагчийн шаардлагад нийцсэн тендер бэлтгэхэд шаардлагатай мэдээлэл, түүнчлэн тендер хүлээн авах, нээх, үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг энэ бүлэгт тусгана. Захиалагч тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа ТОӨЗ-г чанд мөрдөнө.

Гүйцэтгэгчийн гэрээний үүрэг, гэрээний төлбөр, талуудын эрх, үүрэг, хүлээх эрсдэлтэй холбогдсон нөхцөлийг энэ бүлэгт бус 5 дугаарбүлэгт буюу гэрээний ерөнхий нөхцөл болон6 дугаар бүлэгт буюу гэрээний тусгай нөхцөлд тус тус заана.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа нь гэрээний хэсэг болохгүй.

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

## ГАРЧИГ

**А. Ерөнхий зүйл**
1. Тендерийн цар хүрээ
2. Санхүүжилтийн эх үүсвэр
3. Залилан мэхлэх болон авилгын үйлдэл
4. Эрх бүхий тендерт оролцогч
5. Тендерт оролцогчийн чадвар
6. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх
7. Тендер шалгаруулалтад оролцох зардал
8. Ажлын талбайтай танилцах

**Б. Тендерийн баримт бичиг**
9. Тендерийн баримт бичгийнагуулга
10. Тендерийн баримт бичгийнтодруулах
11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт
12. Тендерийн баримт бичигтнэмэлт өөрчлөлт оруулах

**В. Тендер бэлтгэх**
13. Тендерийн хэл
14. Тендерийн иж бүрдэл
15. Тендерийн маягт болон ажлын хуваарь
16. Хувилбарт тендер
17. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт
18. Тендерийн болон төлбөрийн валют
19. Техникийн саналын бүрдэл баримт бичиг
20. Тендер хүчинтэй байх хугацаа
21. Тендерийн баталгаа
22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

**Г. Тендер ирүүлэх**
23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа
25. Хугацаа хоцорсон тендер
26. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах

**Д. Тендерийг нээх, үнэлэх**
27. Тендерийг нээх
28. Нууцлал
29. Тендерийн тодруулга
30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцэх эсэхийг тогтоох
31. Алдааг залруулах
32. Нэг валютэд хөрвүүлэх
33. Дотоодын тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцох.
34. Тендерийг үнэлэх, харьцуулах

**Е. Гэрээ байгуулах эрх олгох**
35. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур
36. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
37. Гэрээнд гарын үсэг зурах
38. Гүйцэтгэлийн баталгаа

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

### А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

| | |
|---|---|
| **1. Тендерийн цар хүрээ** | 1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид “ТШӨХ” гэх)-д тодорхойлсонзахиалагч (цаашид “захиалагч” гэх) нь ТШӨХ, техникийн тодорхойлолт болон 6 дугаар бүлэг буюу гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх)-ддурдсанажлыггүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна. Ирүүлсэн тендерүүдээс хамгийн сайн тендерийг ТББ-ийн дагуу үнэлж, шалгаруулах бауг тендерийг ирүүлсэн оролцогчтой ГТН болон ТШӨХ-д дурдсан нэр, дугаар бүхий гэрээг байгуулахаар зохион байгуулж байна.<br><br>1.2. Шалгарсан тендерт оролцогч ньгэрээгээр гүйцэтгэх ажлыг ТШӨХ болон ГТН-д заасан ажил дуусгах хугацаанд багтаан дуусгана.<br><br>1.3. Ажил нь ТШӨХ-д тусгайлан заасналаас бусад тохиолдолд нэг багцтай байна. |
| **2. Санхүүжилт-ийн эх үүсвэр** | 2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээрсанхүүжүүлнэ. |
| **3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл** | 3.1. Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагч болон тендерт оролцогч, гүйцэтгэгч буюу гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцож, гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.<br><br>3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй. |
| **4. Эрх бүхийтендерт оролцогч** | 4.1. Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрт нээлттэй. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасналаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харьяалалтай байж болно.<br><br>4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:<br><br>4.2.1 Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;<br><br>4.2.2 Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;<br><br>4.2.3 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;<br><br>4.2.4 Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, |

эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;

4.2.5 Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий хуульд заасан эрх бүхий байгууллагатогтоосон;

4.2.6 Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;

4.2.7 Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг төслийн зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол;

4.2.8 Тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;

4.2.9 Тендерийн баримт бичгийн ТОӨЗ-ны 16дугаар зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)

4.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

4.4. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:

(а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар, эсвэл үүсгэн байгуулагдсан улсын түүнтэй адилтгах бусад баримт бичиг;

(б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурахэтгээдийн итгэмжлэл;

(в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл;

(г) Шүүх, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэр. Тендерт оролцогчийн хувьд ТОӨЗ-ны 4.2.2, 4.2.4, 4.2.5 болон 4.2.6 –д дурдсан нөхцөл байдал үүсч байсан бол энэ тухайг захиалагчид мэдэгдэж холбогдох шүүх, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийг тендерийн хамт ирүүлэх үүрэгтэй.

**5. Тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадвар**

5.1. Бүх тендерт оролцогч нь 3 дугаарбүлэгт заасан “Тендерийн маягт, чадварын мэдээлэл, зөвшөөрлийн бичиг”–ын дагуу мэдээлэл ирүүлэх, ажил гүйцэтгэхээр санал болгож буй аргачлал болон хуваарь, шаардлагатай бол зураг, ажлын графикийн хамт ирүүлэх ёстой.

5.2. Хэрэв захиалагч урьдчилсан сонголт явуулаагүй бөгөөд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол бүх тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварыг тогтоохтой холбогдуулан захиалагчийн шаардсан дараах мэдээллийг нотлох баримт болгон тендерийн хамт ирүүлнэ. Үүнд:

(а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн дагуу хийгдэх ажлын тухайд уг ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар, тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл;

(б) санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан жилийн санхүүгийн тайлан. Хэрэв ТШӨХ-д тусгайлан заасан бол санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байна;

(в) гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;

(г) ТШӨХ-д заасан хугацаанд хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт;

(д) тухайн тендерт оролцогч ТШӨХ-д заасан хугацаанд төрөл болон хэмжээгээр ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг жил жилээр харуулсан мэдээлэл, одоо хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээр гэрээний талаар лавлах мэдээлэл авч болох үйлчлүүлэгч, захиалагчийн хаяг;

(е) гэрээг гүйцэтгэхэд ашиглагдах санал болгож буй үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл (зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизмын жагсаах);

(ё) гэрээг гүйцэтгэхэд эргэлтийн хөрөнгө хүрэлцээтэй эсэхийг нотлохбаримт бичиг (үүнд зээл авах баталгаажсан эрх болон боломжтой санхүүгийн бусад эх үүсвэр);

(ж) захиалагч харилцагч банкнаас нь тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл;

(з) одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;

(и) ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 10-аас дээш хувьтай тэнцэх ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүнийг түншлэл гэж үзэж, түншлэгч компаний талаарх мэдээллийг мөн ирүүлнэ. Туслан гүйцэтгүүлэх ажлын талаарх мэдээллийг тендерийн саналд тусгаж ирүүлнэ. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох ажлын нийт өртөгийн дээд хязгаарыг ТШӨХ-д тодорхойлно.

5.3. Тендерт оролцогч ТОӨЗ-ны 1.1-д заасан ажлыггүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна: Үүнд:

(а) ТШӨХ-д заасан хугацааныналь нэг жилд гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан мөнгөн дүнгээс багагүй байх;
(б) ТШӨХ-д заасан жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг удаагийн ажил гүйцэтгэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага (энэ шаардлагыг хангахын тулд нэрлэсэн ажлын доод тал нь 70 хувийг нь гүйцэтгэсэн байх шаардлагатай);

(в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь олж (өөрийн, түрээслэх/гэрээ шаардах/, авах г.м.) бэлэн байлгах санал;

(г) гэрээнд заасан ажилтай төрөл, дүнгээрээ дүйцэх ажил дээр ТШӨХ-д зааснаас доошгүй хугацаандпь гэрээг хариуцаж ажилласан туршлага бүхий ерөнхий инженертэй байх;

(д) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.

(е) сүүлийн ТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

5.4. Тендерт оролцогч түншлэлийн хувьд 5.3 (а) ба (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 5.3 (а), (б)болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байх ёстой.

Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана.

Түншлэл 5.3(б), (в), (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохдоотүншлэлийн гишүүн тус бүрийн нөөц бололцоог хамтад нь харгалзан үзнэ.

Түншлэлийн гишүүн тус бүр 5.3(е)-г хангасан байх ёстой.

5.5. Тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, санхүүгийн нөөц бололцоог харгалзаж үзэхгүй. Харин туслан гүйцэтгэгчээргүйцэтгүүлэх ажилд тусгай зөвшөөрөл шаардагдах бол туслан гүйцэтгэгч уг шаардлагыг хангасан байвал зохино.

5.6. Тендерт оролцогч тендерийн үнэлгээнд 7.5 хувийн давуу эрх эдлэх хүсэлтэй бол тендерт оролцогч нь хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг хангаж байгаагэдгийг нотлон ирүүлэх шаардлагатай.

**6. Тендерт оролцогч түншлэл**

6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь "түншлэл" гэх, тус бүрийг нь "түншлэлийн гишүүн" гэх/ болж

тендер шалгаруулалтад оролцох тохиолдолд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна:

(а) түншлэлийн гишүүн бүр энэхүү ТОӨЗ-ны 5.2-т заасан бүх мэдээллийг тус бүрдээ гаргаж, тендерийн хамт ирүүлнэ.

(б) түншлэлийн гэрээ нь Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байна;

(в) ТОӨЗ-ны 1.1-д заасан хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг хамтран ажиллах гэрээнд тодорхойлсон байх;

(г) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;

(д) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;

(е) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.

6.2. Дээрх шаардлагыг түншлэлийн гэрээнд тусгаагүй тохиолдолд түншлэлийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

**7. Тендер шалгаруулал-тад оролцох зардал**

7.1. Тендерт оролцогч тендерийг бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.

**8. Ажлын талбайтай танилцах**

8.1. Ажлын талбай, түүний байршил, орчны нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж судлан тендер бэлтгэх, гэрээ байгуулахад шаардлагатай байж болох бүх мэдээллийг тендерт оролцогч авч ашиглаж болно. Ажлын талбайтай газар дээр нь очиж танилцах зардлыг тендерт оролцогч өөрөө хариуцна.

## Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

**9. Тендерийнбаримт бичгийн агуулга**

9.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичигболон ТОӨЗ-ны 12 дугаар зүйлийн дагуу оруулсаннэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ:

I ХЭСЭГ
Бүлэг 1. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
Бүлэг 3. Тендер шалгаруулалтад ашиглах жишиг маягт

- Тендерийн маягт
- Чадварын мэдээллийн маягт
- Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл
- Гэрээний маягт

II ХЭСЭГ
Бүлэг 4. Ажлын шаардлага, техникийн тодорхойлолт

III ХЭСЭГ
Бүлэг 5. Гэрээний ерөнхий нөхцөл
Бүлэг 6. Гэрээний тусгай нөхцөл
Бүлэг 7. Гэрээний маягт

- Гэрээний маягт
- Гүйцэтгэлийн баталгааны маягт
- Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт

Хавсралт: Тендерийн урилга

9.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

9.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх зааварчилгаа, нөхцөл, шаардлагатай маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно.

**10. Тендерийн баримтбичгий гтодруулах**

10.1. Тендерт оролцохыг сонирхогч аливаа этгээд нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо (“утсан холбоо”-нд зөвхөн факсыг хамруулна)-гоор ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ирүүлнэ.

Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчдод бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

10.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэхүү ТӨӨЗ-ны 12 дугаар зүйл, 20.2 дахь хэсэгт заасныг баримтална.

**11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

11.1. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах талаар ТШӨХ-д заасан бол тендерт оролцохыг сонирхогч этгээдтүүний томилсон төлөөлөгч нарыг урьж оролцуулна. Уг уулзалт нь тендер бэлтгэх явцад үүсч болох аливаа асуудлыг тодруулах, энэ талаар тендерт оролцогчдоос тавьж буй асуултанд хариу өгөх зорилготой байна.

11.2. Тендерт оролцохыг сонирхогч өөрийн асуултыг дээрх уулзалтыг зохион байгуулахаас өмнө бичгээр ирүүлж болно.

11.3. Эдгээр асуултын агуулга, түүний талаарх хариуг тусгасан уулзалтын тэмдэглэл болон уулзалтын дараагаар бэлтгэгдсэн бусад хариу зэргийг асуулт тавьсан эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

11.4. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзвэл энэхүү ТӨӨЗ-ны 12, 24.2-т заасныг баримтална.

11.5. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтад оролцоогүй шалтгаанаар тендерт оролцохийг сонирхогч этгээдийн тендерт оролцох эрхийг хязгаарлаж болохгүй.

**12. Тендерийн баримт бичигт нэмэлт**

12.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

12.2. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг тендерийн баримт бичиг

**өөрчлөлт оруулах**

худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.

12.3. Шаардлагатай бол тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийг тендер бэлтгэхдээ авч үзэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчдод олгох үүднээс захиалагч ТӨЗ-ны 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

---

## В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

---

**13. Тендерийн хэл**

13.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотой асуудлаар захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидалууд болон бусад баримт материалуудыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн барим бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална

13.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТШӨХ-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг үндэслэн тендерийн үнэлгээнд харгалзах болно.

13.3. Тендерт оролцогч тендерээ Монгол хэл болон ТШӨХ-д заасан гадаад хэлний аль нэг дээр бэлтгэж ирүүлэх бөгөөд нэгээс дээш хэл дээр тендерээ бэлтгэж ирүүлэхийг хориглоно. Шалгарсан тендерт оролцогчтой байгуулах гэрээг түүний тендер ирүүлсэн хэл дээр байгуулна.

**14. Тендерийн иж бүрдэл**

14.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

(а) ТӨЗ-ны 15дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болонүе шатны ажлын хуваарь

(б) ТӨЗ-ны 15, 17 дугаар зүйлийн дагуу бэлтгэж ирүүлэх үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;

(в) Захиалагч ТӨЗ-ны 21 дүгээр зүйлд ирүүлэхийг шаардсан тендерийн баталгаа;

(г) тендерт оролцогчийг төлөөлж ТӨЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийгбаталгаажуулж бичгээр гаргасан байх, түүний итгэмжлэл;

(д) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан нотлох баримтууд;

(е) тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТӨЗ-ны 5 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;

(ё) ТӨОЗ-ны 19дүгээрзүйлд заасны дагуу бэлтгэж ирүүлэх техникийн санал;

(ё) ТӨОЗ-ны 16дугаар зүйлд захиалагч тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд ирүүлэх хувилбарт тендер;

(ж) ТӨОЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад буюу ТШӨХ-д шаардсан материал.

**15. Тендерийн маягт болон үе шатны ажлын хуваарь**

15.1. Тендерт оролцогч нь 3 дугаарбүлэг буюу тендерийн жишиг маягтуудаасзохих маягтыг ашиглан тендерийн санал ба үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг бэлтгэж ирүүлнэ. Эдгээр маягтын үг, өгүүлбэрт утга агуулгыг нь өөрчилсөн буюу орхигдуулсан аливаа өөрчлөлт хийхийг зөвшөөрөхгүй. Маягт дахь бүх хоосон зайд шаардсан мэдээллийг нөхөж бичнэ.

**16. Хувилбарттендер**

16.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.

**17. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт**

17.1. Тендерийн маягт болон үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарьт тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон үнийн хөнгөлөлт нь дараах шаардлагад нийцсэн байна.

17.2. Тендерийн үнэ нь ТӨОЗ-ны 1.1-д тодорхойлсон гэрээт ажлын нийт өртөгийг хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт[1] үндэслэнэ.

17.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн[2] бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ өгнө. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

17.4. Тендерийн маягтадтусгасан үнэ нь санал болгож буй аливаа үнийн хөнгөлөлт тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.

17.5. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусгасан байна.

17.6. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.

17.7. Тухайн тендерийн дагуу гүйцэтгэх ажлыг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТӨОЗ-1.3 дахь хэсгээс лавлана уу. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.

17.8. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТӨОЗ-ны 30 дугаар зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж

[1] Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарьт” гэснийг “ажлын тоо хэмжээнд” гэж солино.
[2] Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн” гэснийг “ажлын тоо хэмжээнд тодорхойлогдсон” гэж солино.

үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч үнэ тохируулахаар заасан тохиолдолд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

17.9. Гэрээний хэрэгжилтийн явцад үнэ тохируулах нөхцөлтэй байхаар заасан бол ажлын гүйцэтгэлийн явцад үе шатны ажлын хуваарьт заасан үнэд[3] гэрээний ерөнхий нөхцөлийн 44 дүгээр зүйлд заасан нөхцөл, аргачлалын дагуу үнийн тохируулга хийнэ. Тендерт оролцогч гэрээний тусгай нөхцөл болон гэрээний ерөнхий нөхцөлийн 44 дүгээр зүйлд заасны дагуу шаардагдах бүх мэдээллийг тендерийн хамт ирүүлнэ.

**18. Тендерийн болон төлбөрийн валют**

18.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.

**19. Техникийн саналийн бүрдэл баримт бичиг**

19.1. Тендерт оролцогч нь ажлын гүйцэтгэл болон хугацааны талаар захиалагчийн шаардлагад нийцэж буйг нарийвчлан харуулсан график, ажлыг гүйцэтгэх арга барил, тоног төхөөрөмж, ажиллах хүчин, ажлын хуваарийн талаарх мэдэгдэл зэргийг агуулсан Техникийн саналыг тендерийн баримт бичгийн3 дугаарбүлэгт заасан маягтаарбусад мэдээллийн хамтаар бэлтгэж тендерт ирүүлнэ.

**20. Тендер хүчинтэй байх хугацаа**

20.1. Тендер нь захиалагч ТОӨЗ-ны 27.1-тзаасны дагуу тогтоосон тендер нээх он, сар, өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендерт оролцогчоос тендерийн маягтад санал болгож ирүүлсэн тендер хүчинтэй байх хугацаа нь захиалагчийн тогтоосон дээрх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүний тендерийг үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж, уг тендерээс татгалзана.

20.2. Онцгой нөхцөл байдал үүсч тендер хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч бүх тендерт оролцогчид хандаж өөрсдийн тендер хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлт тавина. Энэхүү хүсэлт гаргах болон түүний хариуг ирүүлэхдээ бичгээр, эсхүл утсан холбоогоор харилцана. Тендерт оролцогч тендерийн баталгааг улсын орлого болгохгүйгээр уг хүсэлтээс татгалзах эрхтэй. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогчоос тендерийнх нь агуулгыг өөрчлөхийг санал болгох, эсхүл өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхийг хориглоно. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогч тендерийн баталгааны хүчинтэй хугацааг 21 дүгээр зүйлд нийцүүлэн мөн хугацаагаар сунгана.

**21. Тендерийн баталгаа**

21.1. Тендерт оролцогч нь мөн ТШӨХ-д заасан дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

21.2. Тендер шалгаруулалт олон багцтай бол нэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.

21.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.

21.4. Тендерийн баталгаа нь Монгол улсын, эсхүл гадаадын банкны гаргасан баталгаа байна. Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэгт заасан маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагчийн урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх эцсийн хугацаанаас хойш 28 хоногбайна.

[3] Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарьт заасан үнэд” гэснийг “ажлын тоо хэмжээнд заасан нэгж үнэ болон нийт үнэд” гэж солино.

21.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.

21.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

21.7. ТОӨЗ-ны 21.1-д шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерийг захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

21.8. Тендер нь шалгараагүй оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн дотор захиалагч хүчингүй болгоно.

21.9. Шалгарсан тендерт оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 39дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТОӨЗ-ны 40дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлэхэд хүчингүй болгоно.

21.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно:

(а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;

(б) тендерт оролцогч ТОӨЗ-ны 31.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ТОӨЗ-ын 37.2-т заасан нөхцөл үүссэн бол;

(в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:

1) ТОӨЗ-ны 39 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй бол;

2) ТОӨЗ-ны 40 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол.

**22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах**

22.1. Тендерт оролцогч 14дүгээрзүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.

22.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.

22.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

## Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

**23. Тендерийг битүүмжлэх,**

23.1. Тендерт оролцогчид өөрийн тендерийг шуудангаар, эсвэл өөрөө буюу өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.

**бичиглэл хийх**

23.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжлэнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТӨӨЗ-ны 23.3, 23.4–т заасныг баримтлана.

23.3. Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байх. Үүнд:

(а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх;

(б) ТШӨХ-д заасан хаягаар ТӨӨЗ-ны 1.1-дзаасан захиалагчийн нэр дээр хаяглах;

(в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТӨӨЗ-ны 1.1 болон **ТШӨХ-д**тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаар тодорхой бичсэн байх;

(г) ТӨӨЗ-ны 27.1-т заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх.

23.4. Хэрэв бүх дугтуйг 23.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолдзахиалагч хариуцлага хүлээхгүй.

23.5. ТӨӨЗ-ны 23.1-д зааснаас өөр хэлбэрээр (электрон шуудангаар, эсвэл факсаар г.м) ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хуулийн 25 дугаар зүйлийн25.2-т заасныг үндэслэн хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.

**24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

24.1. Захиалагч тендерийг ТШӨХ-д заасан хаягаар, нээх огноо, цагаас өмнө хүлээн авна.

24.2. Захиалагч ТӨӨЗ-ны 12 дугаар зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.

**25. Хугацаа хоцорсон тендер**

25.1. Захиалагч ТӨӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.

**26. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах**

26.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.

26.2. Тендерт нэмэлт, өөрчлөлт оруулах, солих эсхүл тендерийг буцааж авах мэдэгдлийг ТӨӨЗ-ны 23дугаар зүйлийн дагуу бэлтгэн битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторх ба гаднах дугтуй дээр “НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн нэмэлт бичиглэл хийж ТӨӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасны дагуу захиалагчид ирүүлнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.

26.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендерт аливаа нэмэлт өөрчлөлт хийхийг хориглоно.

26.4. ТӨЗ-ны 26.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүй буцаан олгоно.

26.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаастендер хүчинтэй байх хугацааны хоорондтендерийгбуцааж авах нь ТӨЗ-ны 21д зүйлийн дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.

## Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

**27. Тендерийг нээх**

27.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.

27.2. Захиалагч эхлээд "ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ" гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана. Хэрэв "ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ" гэсэн хүсэлтэд гарын үсэг зурсан этгээд нь тендерт оролцогчийг төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд болохыг баталсан гарын үсгийн баталгаа, итгэмжлэл дагалдаж ирээгүй бол түүний үндсэн тендерийг буцаахыг зөвшөөрөхгүй бөгөөд түүнийг нээж нийтэд зарлана. Дараа нь "ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ" бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн оролцогчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно. "ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХТУХАЙ" дугтуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана. Хэрэв тендер солих, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулаххүсэлтийг уг тендерийг ирүүлсэн оролцогчийг бүрэн төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан болохыг баталгаажуулж, хүсэлтийн хамт ирүүлээгүй бол тендерийг солих, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй бөгөөд урьд ирүүлсэн тендерийг дангаар нь нийтийн өмнө нээж зарлана.

27.3. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, хэрэв захиалагч шаардсан бол тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт, өөрчлөлт оруулсанбол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

27.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна.

(а) тендерторолцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ солисон эсэх;
(б) тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт(зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ), шаардлагатай бол эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;
(в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

27.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлснээс бусад тендерээс тендерийн нээлтийн үед татгалзахыг хориглоно.

**28. Нууцлал**

28.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон

тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.

28.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болж болно.

28.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

**29. Тендерийг тодруулах**

29.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний ирүүлсэн тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тодруулга авахдаа зөвхөн албан бичгээр харилцана. Гэхдээ ТОӨЗ-ны 30 дугаарзүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

**30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох**

30.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө дараах шаардлагыг хангаж буй эсэхийг нягтлана. Үүнд:

(а) ТОӨЗ-ны 4дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасанэсэх;

(б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж баталгаажуулсанэсэх;

(в) шаардагдах баталгааг зөвшөөрөгдсөн маягтаар ирүүлсэнэсэх;

(г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэнэсэх;

(д) тендерт оролцогч ТОӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасанэсэх;

(е) ажил гүйцэтгэхэд тавигдах бусад шаардлагыг хангасан эсэх.

30.2. ТОӨЗ-ны 30.1 дэх хэсгийн (а)-(е) дэх заалтыг хангаж буй тохиолдолд тухайн тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

30.3. Шаардлагад нийцсэн тендер нь тендерийн баримт бичигт тавигдсан нөхцөл шаардлага, ялангуяа тендерт оролцогчийн үйлдвэрлэлийнболон гэрээ хэрэгжүүлэх чадвар, техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг материаллаг зөрүүгүйгээрхангасантендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ:

(а) техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;

(б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;

(в) тендерийн баримт бичигтшаардсанаас зөрүүтэйгээр санал болгосон тендерийн саналыг хүлээн зөвшөөрөх, түүнийг

засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

30.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

**31. Алдааг залруулах**

31.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

(б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

(в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

31.2. Захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендерийн үнэд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

**32. Нэг валютад хөрвүүлэх**

32.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТӨЗ-ны 18 дугаар зүйлд зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг тендер зарласан өдрийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

**33. Дотоодын давуу эрх**

33.1. Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт давуу эрхийн зөрүү тооцохгүй.

**34. Тендерийг үнэлэх, харьцуулах**

34.1. Захиалагч зөвхөн ТӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хянан үзээд шаардлагад нийцсэн гэж тогтоосон тендерүүдийг үнэлж, харьцуулна.

34.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ ТӨЗ-ны 25 дугаар зүйлийн дагуу зарлагдсан тендерийн үнэд дараах байдлаар залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:

(а) ТӨЗ-ны 31.1 –дзаасны дагуу алдааг залруулах;

(б) үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь дахь магадлашгүй ажлын зардлын дүнг хасах. Харин захиалагчийн шаардсаны дагуу тендерт оролцогчийн санал болгосон ажил-өдрийн зардлыг хасахгүй;

(в) ТӨЗ-ны 27.4-д заасны дагуу зарлагдсан тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тооцож, тусгах;

(г) Дээрх буюу энэ зүйлийн (а), (б) болон (в) заалтын дагуу хийсэн залруулга, нэмэлт өөрчлөлт, үнийн хөнгөлөлтийг

тооцсон тендерийн нийт үнийг ТОӨЗ-ны 18дугаар зүйлд заасан үндсэн валют руу 32 дугаар зүйлд заасны дагуу хөрвүүлэх;

(д) Захиалагч материаллаг бус зөрүүтэй буюу бага хэмжээний зөрүүтэй гэж үзсэн тохиолдолд орхигдуулсан зүйлийн тоо хэмжээний дутагдал, эсвэл илүүдлийн зөрүүг мөнгөөр илэрхийлэн тооцоолж, тендерийн үнэд тусгах;

(е) Захиалагч зөвхөн 34.4-т тодорхойлсон үнэлгээнд харгалзах хүчин зүйлүүдийг тэдгээрт холбогдох аргачлалын дагуу тооцож тендерийн үнэд тусгах;

(ё) ТОӨЗ-ны 33.1-д тусгайлан заасан бол дотоодын давуу эрхийн зөрүү тооцох.

34.3. Захиалагч нь аливаа өөрчлөлт, зөрүү болон хувилбарт тендерийг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах эрхтэй. Тендерийн баримтбичгийн шаардлагыг давуулж биелүүлэх, эсхүл бусад замаар тендерийн баримтбичгийн шаардлагад заагаагүй ашиг тусыг захиалагчид санал болгосон өөрчлөлт, зөрүү, хувилбарт тендер болон бусад хүчин зүйлийг захиалагч тендерийг үнэлэхэд харгалзахгүй.

34.4. ТШӨХ-д тусгайлан заагаагүй бол захиалагч үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзахгүй:

(а) *Гэрээний болон арилжааны зөрүү:*
Гэрээний болон худалдааны нөхцөлөөс зөрүүтэйгээр санал болгосон болон орхигдуулсан зүйл бүрийн өртгийг тооцоолж үнэлгээнд харгалзана.

(б) *Ажлын гүйцэтгэлийн хугацаа:*
Энэ тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэх ажлыг техникийн тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэлийн хуваарийн дагууболон түүнд багтааж дуусгах шаардлагатай. Тендерт оролцогчийн үнэ тус хуваарьт үндэслэсэн байх шаардлагатай. Тус хуваарьт зааснаас өмнө дуусгавар болгохыг санал болгосон тендерт урамшуулал олгохгүй. Тус хуваарьт зааснаас хоцорч ажлыг гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд тендерийн үнийн ТШӨХ-д заасан хувийг[4] тендерийн үнэ дээр нэмнэ. Ажлын гүйцэтгэлийн хуваарьт зааснаас ТШӨХ-д заасныаас[5] илүү сар хоцроож дуусгахыг санал болгосон тендерээс татгалзана.

(в) *Төлбөрийн хуваарийн зөрүү:*
Гэрээний тусгай нөхцөлд дурдсан төлбөрийн хуваариас өөр хуваарь санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор төлбөрийн хуваарьт зааснаас өмнөтөлөгдөх дүнд сарын ТШӨХ-д заасан хувь[6]-тай тэнцэххүү тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

34.5. Хэрэв тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэх ажил нь ТОӨЗ-ын 1.3-ийн дагуу хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг дараах байдлаар хийнэ. Үүнд:

---

[4] Ихэвчлэн0.05 хувь.
[5] Зөвшөөрөх хоцролтын хугацааг орлуулж бичнэ.
[6] Энэ хүү нь тендер зарлах үеийн тендерийн валютын арилжааны зээлийн зонхилох хүү байна.

(а) багц тус бүрт ТОӨЗ-ны 34.1-34.3-т заасны дагуу тендерийн үнэлгээг хийж, харьцуулах хамгийн бага үнэтэй тендерийг тодорхойлох;

(б) хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд нөхцөлт үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерт уг нөхцөлт үнийн хөнгөлөлтийг тооцох;

(в) дээрх үнэлгээг хийсний дараа захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсвэл бүх бацгад олгох хувилбаруудыг тооцож, тэдгээрээс хамгийн үр ашигтай хувилбарыг сонгох;

(г) нэг тендерт оролцогчид хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд тухайн этгээд гэрээг хэрэгжүүлэх чадварын шаардлагыг хангаж буй эсэхийг дахин магадлах. Хэрэв чадварын шаардлага хангахгүй бол тухайн этгээдэд гэрээ хэрэгжүүлэх чадварт нь тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.

34.6. Шаардлагад нийцсэн тендерүүдийг ТОӨЗ-ны 34.2, 34.3 болон 34.5-дзаасны дагуу үнэлж, харьцуулах үнийг тогтоосний үндсэн дээр хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна. Хамгийн сайн үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

**35. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**

35.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.

35.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТОӨЗ-ны 5.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТОӨЗ-ны 29 дүгээр зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТОӨЗ-ны 5.3–т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч ТОӨЗ-ны 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.

35.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

**36. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах**

36.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

---

## Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

---

**37. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**

37.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 34.6-д заасны дагуу хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

37.2. Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТӨЗ-ны 31 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй эсвэл бичгээр хариу ирүүлээгүй бол захиалагч түүний тендерээс татгалзах бөгөөд 21.8.(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгож, хуулийн 29.3 дахь хэсэгт заасныг үндэслэн удаахь хамгийн сайн үнэлэгдсэн тендер шрүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**38. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

38.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдлийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө шалгарсан тендерт оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

38.2. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг мэдэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор гэрээг баталгаажуулж гарын үсэг зурахыг хориглоно. Энэ заалтыг зөрчиж байгуулсан гэрээ нь хуулийн 42.1.2-т зааснаар хүчин төгөлдөр бус гэрээ гэж тооцох үндэслэл болно.

38.3. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах үндэслэл болно. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл гаргаснаар тендерт оролцогч 40 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, 39дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурах хүртэл захиалагч гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч нарын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзнэ.

38.4. Захиалагч нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.tender.gov.mn вэб сайтад тендерийн нэр болон багцийн дугаарыг дараах мэдээллийн хамтаар нийтэлнэ:

1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;

2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;

3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;

4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;

5) Тендерт шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон үнэ, түүнчлэн батлагдсан гэрээний дүн.

38.5. Гэрээ байгуулсан тухай мэдээлсний дараагаар, шалгараагүй тендерт оролцогч тендерийг нь татгалзсан үндэслэл, шалтгааны талаар тайлбар ирүүлэх хүсэлтийг бичгээр гаргаж болно. Ийм хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.

38.6. Шалгарсан тендерт оролцогч ТӨЗ-ын 40дүгээрзүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, гэрээнд гарын үсэг зурсны дараагаар захиалагч ТӨЗ-ын 21.8-д заасан хугацаанд тендерийн баталгааг цуцлах талаар бусадтендерт оролцогч нарт мэдэгдэнэ.

**39. Гэрээнд гарын үсэг зурах**

39.1. Захиалагч нь гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлүүдийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

39.2. Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

39.3. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн даруй гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

**40. Гүйцэтгэлийн баталгаа**

40.1. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас гэрээний тусгай нөхцөлд заасан дүнгээр, ТШӨХ-д заасан маягтаар болон гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид ирүүлнэ.

40.2. Гүйцэтгэлийн баталгааг:

(а) тендерт оролцогчийн сонголтоор Монгол улсад байрладаг банкаар буюу гадаадын банкны Монгол улсад байрладаг харилцагч банкаар,

эсхүл

(б) захиалагчийн хүлээн зөвшөөрсөн гадаадын банкаар гаргуулна.

40.3. Шалгарсан тендерт оролцогч ТОӨЗ-ны 40.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох, тендерийн баталгааг гүйцэтгүүлэх хангалттай үндэслэл болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТӨОЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨОЗ-ны зүйл заалттай зөрчилдвөл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

| **ТӨОЗ-ны холбогдох заалт** | **А. Ерөнхий зүйл** |
|---|---|
| **ТӨОЗ 1.1** | Захиалагч нь: ***Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар, Мөрөн сумын 8 дугаар баг, Аймгийн нутгийн удирдлагын удирдлагын ордон*** |
| **ТӨОЗ 1.1** | Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: ***Унды усны худаг (Хөвсгөл, Мөрөн сум 10,11,12,13,14 багт) ажлын гүйцэтгэгч сонгох.***<br>***Тендер шалгаруулалтын дугаар***БХБЯ/202001065/1.2.15 |
| **ТӨОЗ 1.2** | Ажилгүйцэтгэждуусаххугацаань: ***2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр*** |
| **ТӨОЗ 1.3** | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ***багцтай***<br>Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, Олны өтөгт гүний худаг<br>Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох |
| **ТӨОЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***Улсын төсвийн хөрөнгө оруулалт***<br>***Нийт батлагдсан төсөв: 100,000,000 (Нэг зуун сая) төгрөг.***<br>Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, олны өтөгт гүний худаг - 70,000,000 төгрөг<br>Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох - 30,000,000 төгрөг<br>*Үүнээс:*<br>*2020 онд санхүүжих дүн- 100,000,000 (Нэг зуун сая) төгрөг* |
| **ТӨОЗ 4.4.(в)** | Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: ***тийм***<br>**Худаг гаргах, засварлах, ажилд тавигдах нөхцөл шаардлага**<br>**Тусгай зөвшөөрөл нь гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй байна. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь худаг гаргах ,засварлах ажлыг дуусгах өдөр буюу 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс хойших хугацаатай байвал зохино. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь дээр дурьдсан хугацаag хангаагүй буюу хүчингүй болсон тусгай зөвшөөрөл бүхий тендерээс татгалзана. Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.** |
| | Бүх тендерт оролцогч нь 3 дугаар бүлэгт заасан “Тендерийн маягт, чадварын мэдээлэл, зөвшөөрлийн бичиг”–ын дагуу **МАЯГТ№ ТШМ-1, МАЯГТ № ТШМ-2, МАЯГТ №: ТШМ-3А эсхүл МАЯГТ №: ТШМ-3Б** мэдээлэл ирүүлэх, ажил гүйцэтгэхээр санал болгож буй аргачлал болон хуваарь, шаардлагатай бол зураг, ажлын графикийн хамт ирүүлэх ёстой. Барилгын ажилд шаардлагатай барилгын материалын техникийн тодорхойлолт, ажлын үе шатны хувиарийг тендерийн баримт бичгийн 5 дугаар бүлэгт заасан зааварын дагуу бэлтгэж ирүүлсэн байна. |

| | |
|---|---|
| **ТОӨЗ 5.2 (а)** | Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагчид дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх: *Үүнд:*<br>*(1) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээ;*<br>*(2) тусгай зөвшөөрлийн дагуу хийгдэх ажлын тухайд уг ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар;*<br>*(3) тендерт оролцогчийг төлөөлж тендерийн баримт бичиг, гэрээ, бусад холбогдох баримт бичигт гарын үсэг зурах, гэрээний хэрэгжилтийг удирдах этгээдийн итгэмжлэл, компанийн гүйцэтгэх захиралд итгэмжлэл олгох тохиолдолд компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс захиралд олгосон итгэмжлэл байж болно;*<br>*(4) Тендер оролцогч аж ахуйн нэгж, түүний эрх бүхий албан тушаалтан нь хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай болон сүүлийн 3 жилд аливаа шүүхийн зарга маргаанд хариуцагчаар оролцож ял шийтгэл, өр төлбөртэй нь тогтоогдож байгаагүй тухай Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт; Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтууд нь гаргасан өдрөөс хойш нэг сарын хугацаанд хүчинтэй байх бөгөөд тендер нээх өдрийн байлаар хүчин төгөлдөр байна.*<br>*(5) Тендер оролцогч аж ахуйн нэгж, түүний эрх бүхий албан тушаалтан тендер нээх өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлгүй талаар Монгол банкны зээлийн нэгдсэн мэдээллийн сангаас гаргасан тодорхойлолт, хэрэв чанаргүй зээлтэй бол Монгол банкны мэдээллийн сангаас гаргасан зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарийг тус тус;*<br>*(6) байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийг тендерийн баримт баримт бичгийн 2 дугаар бүлэгт заасан маягтаар боловсруулж тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны тамга гарын үсгээр баталгаажуулсан байна..*<br>*(7) Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд тендерт ирүүлсэн гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын зураг, төсөл, тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд авто замын барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж ирүүлнэ.*<br>*(8) Татвар, Нийгмийн даатгалын байгууллагад тендер нээх өдрийн байдлаар өр төлбөргүй тухай лавлагааг тус байгууллагуудын цахим мэдээллийн сангаас авч тендерт хавсарган ирүүлнэ.* |
| **ТОӨЗ 5.2.(б)** | Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: *Сүүлийн 2 жил /\ 2018, 2019 он/*<br>*Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: "тийм",*<br>*2018, 2019 онуудын санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх.*<br>*2018, 2019 оны санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайланг e-balance цахим бүртгэлд шивээгүй, баталгаажуулаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.* |

<table>
<tr><td>ТӨӨЗ 5.2.(в)</td><td>
Тухайн төсөл дээр ажиллуулахаар санал болгож буй инженер техникийн ажилтнууд нь дараах хүснэгтэд заасан мэргэжил ур чадвар, шалгуур, шаардлагад нийцсэн байхаар ирүүлнэ. Үүнд: Хүснэгт №ТШМ-2-1.5

<table>
<tr><th>Санал болгож мэргэжилт-ний овог, нэр</th><th>Хүний Тоо</th><th>Албан тушаал</th><th>Мэргэжил</th><th>Ажлын Туршлага</th></tr>
<tr><td></td><td>1</td><td>Ерөнхий инженер</td><td>Усны байгууламжийн инженер</td><td>5 жилээс дээш</td></tr>
<tr><td></td><td>2</td><td>Машин механизмын операторч</td><td>Машин механизмын операторч</td><td>3 жилээс дээш</td></tr>
<tr><td></td><td>2</td><td>Жолооч</td><td>Жолооч</td><td>1 жилээс дээш</td></tr>
<tr><td></td><td>3</td><td>Мэргэжилтэй ажилчид</td><td>мэргэжлийн</td><td>1 жилээс дээш</td></tr>
</table>

ТӨӨЗ 5.2-ын (в)-ын 1. Маягт № ТШМ-2-1.5 хүснэгтээр санал болгосон инженер, техникийн ажилтан, ажилчдын 50 –иас доошгүй хувийн нэр дээр нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 оны (1, 2, 3, 4 дугаар сарууудад) оролцогч аж ахуйн нэгж өөрөө төлсөн болохыг Нийгмийн даатгалын байгууллагаас баталгаажуулсан НД№7, НД№8 маягтаар гаргасан тайланг тендерт оролцогч баталгаажуулж ирүүлнэ.

ТӨӨЗ 5.2-ын (в)-ын 2. № ТШМ-2-1.5 хүснэгтэд байгаа инженер, техникийн ажилтнууд, ажиллуулахаар санал болгож бусад мэргэжлийн ажилчдын иргэний үнэмлэх, диплом, мэргэжлийн үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар, ИТА-ны туршлагын талаархи мэдээллийг PDF хэлбэрт шилжүүлж тус тус ирүүлнэ. /Уг төсөлд санал болгож буй бүх ИТА, ажилчдад хамаарна/

Дараах тохиолдолд тендерээс татгалзана. Үүнд:

№ ТШМ-2-1.5 хүснэгтэд заасан үндсэн шаардлага, мөн ТӨӨЗ 5.2-ын (в)-ын 1, ТӨӨЗ 5.2-ын (в)-ын 2-д заасан өгөгдөл, шаардлагуудын аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.
</td></tr>
<tr><td>ТӨӨЗ 5.2 (г)</td><td>
Хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: Сүүлийн 3 жил (2017, 2018, 2019 онууд)-ийн хугацаанд бэлчээрийн худаг гаргах, барих ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан, хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалтыг дараах хүснэгтээр он тус бүрээр гаргаж ирүүлнэ.

<table>
<tr><th>№</th><th>Гэрээний Нэр</th><th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс</th><th>Төсөвт өртөг</th><th>Дууссан, эсхүл дуусах хугацаа</th></tr>
<tr><td>1</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td>Дүн</td><td></td><td></td><td></td></tr>
</table>
</td></tr>
</table>

| | |
|---|---|
| **ТӨӨЗ 5.2 (д)** | Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **ТӨӨЗ 5.2-ын (д)-ын 1.** Сүүлийн 3 жил ( 2017, 2018, 2019 онууд)-ийн хугацаанд доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй бэлчээрийн худаг гаргах, барих ажилтай ижил төстэй ажлыг нийлүүлэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх ба энэхүү туршлагад тооцуулах нэг гэрээ (ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа нийлүүлсэн тэр гэрээ)-ний үнэ нь энэ тендерт санал болгож буй ажлын төсөвт өртгийн 40 хувиас багагүй байна.<br><br>ТӨӨЗ 5.2-ын (д)-ын 2. Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудад гэрээгээр гүйцэтгэсэн барилга угсралт, засварын ажлыг бэлчээрийн худаг гаргах, барих ажилд тооцуулах ажлын жагсаалт, **уг жагсаалтад заасан** ажил тус бүрийн гэрээний эх хувиас татсан хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээ бүрийн гүйцэтгэл бүрэн, чанартай байсан талаар өмнөх захиалагчийн тодорхойлолт, ажлыг ашиглалтад оруулах Улсын комиссын акт зэрэг баримт бичгийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж, PDF хэлбэрт шилжүүлэн ирүүлнэ. Ижил төстэй ажил тооцуулахаар санал болгосон барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах комиссын актад гарын үсэг зурсан комиссын бүрэлдэхүүн нь Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолд заасан шалгуур, шаардлагыг хангасан байна. Ижил төстэй ажил тооцуулахаар санал болгосон гэрээт ажил бүрийн гүйцэтгэл бүрэн, чанартай байсан талаарх өмнөх захиалагчийн тодорхойлолтыг дараах этгээдээс гаргуулсан байна. Үүнд: Улсын төсвөөс орон нутагт эрх шилжүүлсэн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэсэн тодорхойлолтыг захиалагчаар ажилласан аймаг, сумын Засаг даргын тамгын газраас олгосон тодорхойлолт, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэсэн тохиолдолд захиалагчаар ажилласан яамны тодорхойлолтыг, бусад хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн гэрээний тодорхойлолтыг үндсэн захиалагчаас тус тус авч ирүүлнэ.<br><br>ТӨӨЗ 5.2-ын (д)-ын 3. Ижил төстэй ажилд бэлчээрийн худаг гаргах, барих ажлыг тооцох ба энд зааснаас өөр ангилалд хамаарах барилга байгууламжийн ажлыг ижил төстэй ажилд тооцохгүй.<br><br>ТШӨХ-ийн ТӨӨЗ 5.2-ын (д)-ын 1, ТӨӨЗ 5.2-ын (д)-ын 2, ТӨӨЗ 5.2-ын (д)-ын 3-д заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.*]* |
| **ТӨӨЗ 5.2 (к)** | Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүн: *Тендерт туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн* ***10 хүртэл хувь,*** *тендерт түншлэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн* ***40 хүртэл хувийг*** *тус тус хангасан этгээдтэй туслан болон түншлэн ажиллах гэрээг байгуулж тендерийн хамт ирүүлэх ба туслан гүйцэтгэгч, түншлэгч нь ТӨӨЗ болон ТШӨХ-д дурдсан бусад шалгуур, шаардлагуудыг өөрт ноогдох хувиар хангасан болохыг холбогдох баримт бичиг, нотлох баримтаар тендерт ирүүлсэн байх шаардлагатай. Тендерт оролцогч туслан гүйцэтгэгч авах бол тендерт санал болгох бөгөөд туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний эх хувь, тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж хавсаргаж ирүүлнэ.* |
| **ТӨӨЗ 5.3 (а)** | Борлуулалтын хэмжээ: *Сүүлийн 2 жил (2018, 2019 онууд)-ийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь захиалагчийн санал болгож буй төсөл арга хэмжээ (багц)-ний төсөвт өртгийн 40 хувиас багагүй байна.* |
| **ТӨӨЗ 5.3 (б)** | Ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: ***сүүлийн 3 жил*** |

<table>
<tr><td>ТӨЗ 5.3 (в)</td><td>Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: Тендерт оролцогч нь доорх хүснэгтэд заасан шалгуур, шаардлагыг хангасан машин, тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг ирүүлнэ. Үүнд: /Маягт № ТШМ-2-1.4 хүснэгт, ТӨЗ 5.3 (в)-1/<br><br>
<table>
<tr><td>Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр, зориулалт</td><td>Тоо, хэмжээ</td><td>Улсын бүртгэлийн гэрчилгээ, техникийн паспортын дугаар</td><td>Эзэмшдэг байгууллага иргэний нэр</td><td>Чанар байдал, ашиглалтад орсон огноо</td></tr>
<tr><td>Өрмийн машин</td><td>1</td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Ачааны автомашин 5 тонн</td><td>1</td><td></td><td></td><td></td></tr>
</table>
<br>
ТӨЗ 5.3 (в)-2: Маягт № ТШМ-2-1.4 хүснэгт заасан машин механизмын 50-аас багагүй, тоног төхөөрөмжийн 50-иас багагүй хувь нь тус тус тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийнх, үлдсэн нь түрээсийн байж болно. Түрээсийн машин тоног төхөөрөмжийг ашиглах тохиолдолд түрээслүүлэгчтэй машин тоног төхөөрөмж ашиглах түрээсийн гэрээг Иргэний хуулийн холбогдох зүйлд нийцүүлэн 2020 онд байгуулсан байна. Тээврийн хэрэгсэл, механизмийн техникийн улсын бүртгэл тооллогод орсон хугацаа нь тендер нээх өдрөөс хойш хүчинтэй байна. Машин, тоног төхөөрөмж нь тендерт оролцогчийн эсхүл түрээсийн болохыг дараах баримт баримт бичгээр нотлоно. Үүнд:<br>
1. Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж бүрийн техникийн болон тээврийн хэрэгслийн гэрчилгээний наториатоор батлуулсан хуулбар<br>
2. Авто тээврийн үндэсний төвөөс олгосон лавлагаа,<br>
3. Тендерт оролцогчийн үндсэн хөрөнгөд бүртгэснийг нотлох бусад баримт бичиг<br>
4. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан түрээсийн гэрээ<br>
ТӨЗ 5.3 (в)-3: Хэмжих, хянах багаж хэрэгсэл бүр нь холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажилтын гэрчилгээтэй болохыг нотолж гэрчилгээний нотариатоор батлуулсан хуулбарыг PDF хэлбэрт шилжүүлэн ирүүлнэ. Уг гэрчилгээний хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрөөс хойш хүчинтэй байх шаардлагыг хангасан байна.<br>
ТӨЗ 5.3 (в)-4: Хэрвээ уг ажилд Авто кран шаардлагатай гэж тодорхойлсон бол тухайн авто кран нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тухай мэргэжлийн хяналтын байгууллага, баталгаажуулах эрх бүхий бусад байгууллагаас олгосон хүчин төгөлдөр техникийн дүгнэлттэй байна.<br>
ТӨЗ 5.3 (в)-1, ТӨЗ 5.3 (в)-2, ТӨЗ 5.3 (в)-3, ТӨЗ 5.3 (в)-4-д заасан шаардлага нөхцлийн аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</td></tr>
<tr><td>ТӨЗ 5.3 (г)</td><td>Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: Төслийг удирдуулахаар санал болгож буй ерөнхий инженер нь автозамын барилгын салбарт 3-аас доошгүй жил ажилласан байхын зэрэгцээ тендерт санал болгож буй ажлын төсөвт өртгөгийн 30 хувиас доошгүй төсөвт өртөг бүхий ижил төстэй ажлын гэрээг ядаж нэг удаа хариуцан ажилласан туршлагатай байна. Ерөнхий инженер нь дээр дурьдсан туршлагатай болохыг өмнөх захиалагчийн тодорхойлолт, дүгнэлтэд заасан түүний нэр эсхүл захиалагчтай байгуулсан гэрээг удирдахаар ижил төстэй ажлын гэрээнд захиалагчийг төлөөлж зурсан түүний гарын үсэг, барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгсөн Улсын комиссын актанд түүний зурсан гарын гарын үсэг зэрэг баримтуудын аль нэгээр нотолж болно..</td></tr>
</table>

| | |
|---|---|
| **ТОӨЗ 5.3 (д)** | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн[7] нийт дүн: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: *Захиалагчаас санал болгож буй төсөл арга хэмжээ (багц)-ний төсөвт өртгийн* **30%-иас** *багагүй байх*<br><br>**ТОӨЗ 5.3 (д)-ын 1.***Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн заавар"-ын 3.2.2-ийн "е"-д " Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө =Мөнгө Түүнтэй Адилтгах Хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтээр дүгнэнэ" гэж заасны дагуу буюу дараах хөрөнгийн эх үүсвэрүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:*<br><br>*1.1. Байгууллагын харилцагч банкин дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа (Үүгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө тооцуулах саналтай тохиолдолд дансны хуулгыг харилцагч банкаар баталгаажуулж дансны үлдэгдлийг баталгааны хамт ирүүлсэн байна)*<br><br>*1.2. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн мэдэгдлийг үнэлгээнд харгалзахгүй/*<br><br>*1.3 Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд.*<br><br>*1.4 Дансны авлага, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө,*<br><br>***Дараах тохиолдолд тендерээс татгалзана. Үүнд Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах зээл нь ТШӨХ-ийн ТОӨЗ 5.3 (д)-д заасан хэмжээ, өгөгдөл, шаардлагыг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.*** |
| **ТОӨЗ 5.3 (е)** | *Тендерт оролцогч нь сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудад ашигтай ажилласан байна.* |
| **ТОӨЗ 6.1** | Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:<br><br>*Түншлэлийн гишүүд захиалагчийн тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур, шаардлага нөхцлийн 40 хувийг хангасан байна.* |
| **Б. Тендерийн баримт бичиг** | |
| **ТОӨЗ 10.1** | Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: **Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар, АЗДТГ-ын А корпус 114 тоот. Утас: 70388848, 70388821, 70384908, 95490203**<br><br>*Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчаас авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Ирүүлсэн тодруулгын хариуг Төрийн худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн тодруулга хэсэгт бичгээр нийтлэх тул тодруулга, нэмэлт мэдээлэл хүссэн этгээд, тендерт оролцох хүсэлтэй бусад этгээд тендер нээх өдрийг хүртэл Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд сайтад хандаж байхыг анхаарна уу*<br><br>*Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хүртэл хоногт тендерийн баримт бичгийн талаар тодруулга авахаар ирүүлсэн оролцогчийн хүсэлтийг захиалагч хүлээн авахаас татгалзаж, тодруулга өгөхгүй.* |
| **ТОӨЗ 11.1** | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах эсэх: ***"үгүй"*** |
| **В. Тендер бэлтгэх** | |
| **ТОӨЗ 13.1** | Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь Монгол хэлээс гадна дараах хэл дээр байна. Үүнд: Монгол хэлээс өөр хэл хэрэглэхгүй.<br>***Тендерт оролцогчид дээр тодорхойлсон Монгол хэлийг сонгож тендерээ уг сонгосон хэл дээр бэлтгэж ирүүлнэ.*** |
| **ТОӨЗ 14.1 (ж)** | Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ. Үүнд: |

[7] Авах боломжтой зээл гэдэгт зээлжих баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.

| | |
|---|---|
| | *1. Зураг, ажлын тоо хэмжээтэй уялдуулан тооцсон төсвийг эрх бүхий төсөвчнөөр хүлээн зөвшөөрөгдсөн барилгын төсвийн программаар, зураг төслийн норм ба дүрмийн дагуу хийлгэж баталгаажуулсан байна.*<br><br>*2. Ажлын зураг төсөл, инжененр хайгуулын зардлын үнэ- **1,500,000 (Нэг сая таван зуун мянган)** төгрөгийг ажлын гүйцэтгэлийн төсөвт тооцож ирүүлнэ.*<br><br>*3. Ажлын гүйцэтгэх хугацааны нарийвчилсан график гарган эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж ирүүлнэ.*<br><br>*4. Тендерийн баримт бичгийн ТӨЗ-ын 4.2.1-4.2.9-д заасан нөхцөл байдал үүсээгүй талаарх мэдэгдэл ирүүлнэ.*<br><br>*5. Тендерийн баримт бичиг, 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний Ерөнхий болон тусгай нөхцөл, захиалагчийн санал зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.*<br><br>*6. Олон багц ажлын тендерт эсхүл энэ тендерээр эрх авах төсөл арга хэмжээтэй давхцан хэрэгжих гэрээнд ажиллах хүн хүч, машин механизмын мэдээллийг тус тус ирүүлнэ. Энэ тендерт санал болгосон ажиллах хүчин, машин механизм нь олон багц болон энэ гэрээтэй давхцсан хэрэгжих гэрээнүүдэд ажиллах хүн хүч, машин механизмтай давхцсан тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.*<br><br>*7. Тендерт оролцогчийн ирүүлсэн тендер шалгарсан тохиодолд уг тендерийн баримт бичгийг олон нийтэд ил болгоход татгалзахгүй талаарх тендерт оролцогчийн мэдүүлэгийг эрх бүхий албан тушаалтны тамга, гарын үсгээр баталгаажуулж ирүүлнэ.*<br>*8. Захиалагчийн санаачлагаар Шүүх, харилцагч банк, Эрүүл мэнд нийгмийн даатгалын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар, татварын хэлтэс, өмнө үйлчлүүлсэн захиалагчаас болон бусад холбогдох байгууллагаас тендерийн бичиг баримттай холбоотой асуудлаар тодорхойлолт, лавлагаа авахад татгалзах зүйлгүй гэсэн агуулга бүхий мэдэгдлийг тендерт оролцогч баталгаажуулан өөрийн тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ.*<br>*9. Бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, үе шатны болон санхүүжилтийн хуваарийг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу захиалагчийн санал болгосон ажлын тоо хэмжээний дагуу тооцсон хөдөлмөрийн зардал, ажлын тоо хэмжээнд ноогдох материал, тээвэр, машин механизмын зардал, татвар, шимтгэл, төлбөр хураамжийн хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлсэн тоогоор хүснэгтийн холбогдох мөр, баганыг нөхөж тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны тамга, гарын үсгээр баталгаажуулж ирүүлэх.*<br>*10түүний үндэслэл, шалтгааныг дурьдсан мэдэгдлийг шаардлагатай нотлох баримтын хамт баталгаажуулан ирүүлнэ. Үнийн хөнгөлөлт үзүүлж буй бараа нь тендерт оролцогчийн санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн байна. Үндэслэлгүй тооцсон үнийн хөнгөлөлт бүхий тендерээс татгалзана.*<br><br>*11. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн*<br><br>*электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх*<br><br>*ба ирүүлсэн бүх материалын бичвэр дэх үсэн тоо, тэмдэгтүүдуншигдахуйц тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй тод биш баримт бичиг бүхий тендерийг ирүүлээгүйд тооцож татгалзана.*<br><br>***12.** Захиалагчийн хяналтын зардал, зураг төсвийн үнэ, зохиогчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардал, нормчлолын сангийн шимтгэл зэргийг тендерт оролцогч өөрийн төсөвт холбогдох норм дүрмийн дагуу тооцож тусгасан байна.*<br><br>***-Захиалагчийн хяналтын зардал:***<br><br>*зураг, төсвийн норм дүрмийн дагуу тооцож, санал болгож буй өртгийн төсөвт тусгаж ирүүлнэ.*<br><br>***-Инженер хайгуул, зураг, төсвийн үнэ: 1,500,000 (Нэг сая таван зуун мянган) төгрөг***<br><br>***Зохиогчийн хяналтын зардал: .............. төгрөг***<br><br>*Уг зардлыг зураг, төсвийн норм дүрмийн дагуу тооцож, санал болгож буй өртгийн төсөвт тооцож ирүүлнэ.*<br><br>***-Магадлашгүй ажлын зардал:*** |

*Уг зардлыг зураг, төсвийн норм дүрмийн дагуу тооцож санал болгож буй өртгийн төсөвт тооцож ирүүлнэ.*

***-Норм, нормативын сан: ................... төгрөг***

*Тендерт оролцогч нь дээр заасан захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, норм нормативын сан, магадлашгүй ажлын зардал зэргийг зураг төсвийн норм, дүрэмд заасан хэмжээнээс бага хувь хэмжээгээр эсхүл тооцож ирүүлээгүй тохиолдлуудад түүний тендерээс захалагч татгалзах үндэслэл болно.*

*13. Барилгын ажилд ашиглахаар санал болгож буй материал нь Монгол улсад болон олон улсад мөрдөгдөж байгаа стандарт, захиалагчийн техникийн тодорхойлолтыг хангасан болохыг нотлох техникийн тодорхойлолт, тохиролын гэрчилгээ, холбогдох тайлбар үндэслэлийг тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны тамга, гарын үсгээр баталгаажуулж тендерт ирүүлнэ.*
*14. Барилгын материалын техникийн тодорхойлолт, чанарын сертификат, тохиролын гэрчилгээ, ашиглалт, засвар үйлчилгээний заавар зэрэг баримт бичиг нь гадаад хэл дээр байгаа бол баталгаат орчуулгаар Монгол хэл дээр хөрвүүлсэн байх бөгөөд дээрх баримт бичгийг PDF форматаар бэлтгэж ирүүлсэн байна.*

*15. Тендерт оролцогч нь Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолд тусгагдсан дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад тусгагдсан барилгын материал, барааг ажилд заавал ашиглах бөгөөд тухайн барилгын материал, барааны нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртөг, барааны техникийн тодорхойлолт, гарал үүслийн талаарх мэдээлэлийг, импортын бараанаас тусад гаргаж, доорх хүснэгтэд зааснаар ирүүлнэ.*
*Үүнд:*

| *№* | *Барилгын материалын нэр, марк* | *Барилгын материалын техникийн тодорхойлолт, холбогдох стандарт* | *Хэмжих нэгж* | *Тоо* | *Нэгж үнэ /төгрөг/* | *Бүгд үнэ /төгрөг/* |
|---|---|---|---|---|---|---|
| *1* | *2* | *3* | *4* | *5* | *6* | *7* |
| | | | | | | |
| *Нийт үнэ /төгрөг/* | | | | | | |

*16. Магадлашгүй ажлын зардлыг зарцуулах шийдвэрийг захиалагчаас томилсон төслийн баг гаргаж, магадлашгүй ажлын зардлаар гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, зураг төсөл боловсруулах үйл ажиллагааг тухайн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулсан зөвлөх эсхүл мэргэжлийн зөвлөхөөр барилгын зураг төслийн норм, дүрмийн дагуу тодорхойлуулж төслийн менежер батлана.*
*17. Тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолгүй тухай мэдэгдэл ирүүлнэ.*

Жич: Тендерт оролцогчийн санал болгосон үнэ, төсвийг барилгын төсвийн зөвшөөрөгдсөн программаар шалгахад ажлын тоо хэмжээг орхигдуулсан, норм дүрмийг буруу хэрэглэсэн, төсөв буруу, алдаатай аргачлалаар бодогдсон, зөрсөн эсвэл үнийн хөнгөлөлт нь үндэслэлгүй, эсхүл тендерт оролцогчийн ирүүлсэн баримт бичиг, нотлох баримтууд нь ТШӨХ-ийн ТӨОЗ 14.1(ж)-ын 1-ээс 17-д өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй нь тогтоогдвол уг тендерээс татгалзана.

| | |
|---|---|
| **ТӨОЗ 16.1** | Хувилбарт тендер ирүүлэхийг ***“зөвшөөрөхгүй”*** |
| **ТӨОЗ 17.8** | Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад ***“тохируулахгүй тогтмол байна.”*** [8] |
| **ТӨОЗ 18.1** | Тендерийн валют: ***Төгрөг байна.*** |

[8] Захиалагч 2 жилээс дээш хугацаагаар хэрэгжих, эсхүл суурь үнэ огцом өөрчлөгдсөн нөхцөлд гэрээний үнэд тохируулга хийж болохоор хуулийн 40.4 дэх хэсэгт зохицуулсан.

| | |
|---|---|
| **ТӨЗ 20.1** | Тендер нээснээс хойш ***30*** хоногийн туршид хүчинтэй байна. |
| **ТӨЗ 21** | Тендерийн баталгааны үнийн дүн:<br>***Төсөвт өртгийн 2 хувиар баталгааны хэмжээг тогтоож үнийн дүнг оруулна.***<br>Тендерийн хамт Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, олны өтөгт гүний худаг – 1,400,000 төгрөг, Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох - 600,000 төгрөг дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.<br><br>***Тендерийн баталгааны хугацаа 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хүчинтэй.***<br>*Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.*<br>***Дараах тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно. Үүнд:*** *Тендерийн баталгааны үнийн дүн:*<br>*1. Тендерт оролцогч тендерийг нээсний дараа тендерийн хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс татгалзсан. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.1 дэх заалт.*<br>*2. “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.2 дэх заалт.*<br>*3. Тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалт*<br>*Тендерийн баталгааны дүнг тендерийн баримт бичигт заасан мөнгөн дүнгээс бага эсхүл илүү тооцсон, тендерийн баталгааны хүчинтэй хугацааг дутуу тооцсон тохиолдолд уг тендерийн баталгааг “хуулд”-д нийцээгүй тендерийн баталгаа гэж үзэж татгалзана.* |
| **ТӨЗ 22.1** | Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: Тендерийн баримт бичгийг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн цахим гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Тендерийг цахимаар зохион байгуулах тул хуулбар хувь шаардлагагүй. |
| | **Г. Тендер ирүүлэх** |
| **ТӨЗ 23.3 (б)** | Тендерт оролцогч тендер ирүүлэх нь: *Тендерийн баримт бичгийг электрон файл хэлбэрээр хэсэг тус бүр нь 15 Mb-с хэтрэхгүй байхаар 100 Mb хүртэл хэмжээтэй PDF форматаар бэлдэж http:www.tender.gov.mn хаягаар илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.*<br>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: *Тендер хүлээн авах этгээд: Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Д.Төмөр*<br>*Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын “А” байр, худалдан авах ажиллагааны ил тод байдлын танхим.*<br>*Давхар болон өрөөний дугаар: Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын , өрөөний дугаар 114 тоот.*<br>*Аймаг, хот: Хөвсгөл аймаг Мөрөн хот*<br>*Улс: “Монгол Улс”*<br>Аймаг, хот: ***Хөвсгөл аймаг, Мөрөн сум***<br>Шуудангийн дугаар:<br>Улс: ***“Монгол Улс”*** |

| | |
|---|---|
| **ТӨЗ 24.1** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: *Огноо:* ***2020 оны 5 дугаар сарын 18-ны өдөр***<br>*Цаг:* ***11 цаг 20 минут***<br>*Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](www.tender.gov.mn) )-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.* |
| **Д. Тендерийг нээх, үнэлэх** | |
| **ТӨЗ 27.1** | Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:<br>*Байшин, гудамжны нэр Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын "А" байр, худалдан авах ажиллагааны ил тод байдлын танхим.*<br>*Давхар болон өрөөний дугаар: Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Д.Төмөр, 114 тоот өрөө*<br>*Аймаг, хот: Хөвсгөл аймаг, Мөрөн хот*<br>*Улс:"Монгол Улс"*<br>*Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:*<br>*Огноо:* ***2020 оны 5 дугаар сарын 18-ны өдөр***<br>***Цаг: 11 цаг 40 минут*** |
| **ТӨЗ 33.1** | Дотоодын давуу эрхийн зөрүү: ***"тооцно"***<br>*Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол дараах баримт бичгийг тендерт ирүүлнэ. Үүнд:*<br>*1. Дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт,*<br>*2. ТӨЗ 33.1-ийн 1. ТШӨХ-ийн ТӨЗ-ны 5.2 (в)-ын Маягт №ТШМ-2-1.5-д нэр нь бичигдсэн инженер, техникийн ажилтан, ажилчдын 30 доошгүй хувь нь Хөвсгөл аймгийн харъяат иргэд байх ба тэдний НДШ-ийг тендерт оролцогч өөрөө 2019 оны сүүлийн хагас (6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар сарууд)-т тасралтгүй төлснийг нотолж нийгмийн даатгалын байгууллагын НД-7, НД-8 маягтаар баталгаажуулсан тайланг ирүүлэх.*<br>*3. ТӨЗ 33.1-ийн 2. Дотоодын давуу эрх тооцуулахаар санал болгож буй иргэдийн иргэний үнэмлэхний хуулбар, мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар, оршин суугаа багийн Засаг даргын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээ, ажилд томилсон тушаал зэрэг бичиг баримтыг тендерт ирүүлэх.*<br>*4. ТӨЗ 33.1-ийн 3. Ажилд ашиглах дотоодын бараа (барилгын материал)-нд дотоодын давуу эрх тооцуулах тухай албан хүсэлт, материал нь Монгол Улс, эсхүл орон нутагт үйлдвэрлэсэн бараа болохыг нотлох зорилгоор тухайн материал бүрийн тохиролын гэрчилгээ, чанарын сертификат, барилгын материалыг тухайн барилгад шаардлагатай хэмжээгээр нийлүүлэх боломжтой талаар үйлдвэрлэгчийн зөвшөөрөл (үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ), дотоодоос худалдан авах бараа, материалын нийт өртөг, үнийн мэдээллийг захиалагчаас тогтоосон хүснэгтээр тус тус PDF форматаар бэлтгэж ирүүлнэ*<br>*ТӨЗ 33.1-ийн 4. Дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авах барилгын материалын тоо хэмжээ, нэгж үнэ нийт үнэ, техникийн тодорхойлолтыг дараах хүснэгтээр тооцож ирүүлнэ. Үүнд:* |

| *№* | *Барилгын материалын нэр, марк* | *Барилгын материалын техникийн тодорхойлолт, холбогдох стандарт, гарал үүсэл* | *Хэмжих нэгж* | *тоо* | *Нэгж үнэ /төгрөг/* | *Бүгд үнэ /төгрөг/* |
|---|---|---|---|---|---|---|
| *1* | *2* | *3* | *4* | *5* | *6* | *7* |

<table>
<tr>
<td></td>
<td>
<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="2">Нийт үнэ /төгрөг/</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2015 оны 18 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 58 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ын дагуу тооцно.
Дараах тохиолдолд тендерээс татгалзана. Үүнд:
ТШӨХ-ийн ТОӨЗ 33.1-ийн ТОӨЗ 33.1-ийн 1, ТОӨЗ 33.1-ын 2, ТОӨЗ 33.1-ын 3, ТОӨЗ 33.1-ын 4-д заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй бол тухайн тендерээс татгалзана.
</td>
</tr>
<tr>
<td>ТОӨЗ 34.4</td>
<td>
Тендерийн үнэлгээнд үнээс гадна дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:
(а) Гэрээний болон арилжааны зөрүү: “Ашиглахгүй”
(б) Ажлын гүйцэтгэлийн хугацааг зөрүүтэй тогтоох: “Ашиглана”
1. хугацаа хоцорсон хоног тутамд тооцох хүүгийн хувь хэмжээ: 0,1 хувь
2. Захиалагчийн санал болгосон гүйцэтгэлээс хоцорч болох хугацааны хязгаар: 0,3
(в) Төлбөрийн хуваарийн зөрүү: “Ашиглахгүй”
</td>
</tr>
<tr>
<td>ТОӨЗ 40.1</td>
<td>
(а) Гүйцэтгэлийн баталгаа Шаардана
(б) Гүйцэтгэлийн баталгаа шаардах тохиолдолд гэрээний маягтууд буюу VII бүлэг дэх тохирохмаягтын дагуу Гүйцэтгэлийн баталгааг гаргуулж гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх шаардлагатай. Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгө дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцүү байна.
</td>
</tr>
<tr>
<td>Анхааруулга</td>
<td>Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд хууль хяналтын байгууллага болон тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагад тус тус хандан шийдвэрлүүлнэ.</td>
</tr>
</table>

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН МАЯГТ

**Тендерийн маягт, Чадварын мэдээлэл ирүүлэх маягт,**
**Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл,**

**Тендершалгаруулалтын маягтыг бөглөх санамж**

Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагын дагуу тендерийн маягт, энэ бүлэгт заасан маягтаар гаргасан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.

Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг энэ бүлэгт заасан маягтаар ирүүлэх үүрэгтэй. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэх шаардлагагүй бол урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтыг тендерийн баримт бичигт хавсаргахгүй.

**МАЯГТ№ ТШМ-1**

## ТЕНДЕРИЙН МАЯГТ

***[огноо]***

***(Захиалагч байгууллагын нэр)***-ын дарга ___________________танаа

1. Бид, ***[тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]***-ыг ***[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.

   Гэрээний төлбөрийг дараах валютаар авна. Үүнд:

| № | Валютын нэр | Тус валютаар төлөх хувь | Гадаад валютын ханш /гадаад валютын нэгж хэдэн төгрөгтэй тэнцэх/ | Шаардагдах гадаад валютын дүн |
|---|---|---|---|---|
| (а) | | | | |
| (б) | | | | |

   Шаардагдах урьдчилгаа төлбөр:

| | Валютын нэр | Валютын дүн |
|---|---|---|
| (а) | | |
| (б) | | |

2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс ***[тоо]*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр: ____________________________________________________

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:______________________________

Албан тушаал, нэр: __________________________________________________________

Хаяг:__________________________________________________________________

**МАЯГТ № ТШМ-2**

## ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ

**Чадварын мэдээллийг бөглөх санамж**

Гэрээг хэрэгжүүлэх чадвартайгаа нотлох, эсхүл урьдчилсан сонголтод ирүүлсэн мэдээлэлд орсон өөрчлөлтийг тодотгох зорилгоор ТӨЗ-ны 5дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогч дараах мэдээллийг бөглөж ирүүлнэ. Эдгээр мэдээлэл гэрээний хэсэг болохгүй. Шаардлагатай бол нэмэлт хуудас хэрэглэнэ. Хавсаргасан бичиг баримт нь тендерийг бэлдсэн хэлнээс өөр хэл дээр бол түүнийг орчуулсан байх шаардлагатай. Тендерт оролцогч урьдчилсан сонголтод оролцсон бол зөвхөн өөрчлөгдсөн мэдээллээ бөглөж ирүүлнэ.

**1. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр**

1.1. Тендерт оролцогч хуулийн этгээд болох талаар баталгаа болон тусгай зөвшөөрөл:
***[хуулбарыг хавсаргах]***

Бүртгүүлсэн газар: ***[бөглөх]***

Бизнесийн үйл ажиллагааны үндсэн хаяг: ***[бөглөх]***

Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл: ***[хавсаргах]***

1.2. Сүүлийн ***[тоо]*** жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил, жилээр жагсаах: ***[бөглөх]***

1.3. Ерөнхий гүйцэтгэгчээр сүүлийн ***[тоо]*** жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн төрөл болон хэмжээгээр ижил төстэй ажил ба гэрээний үнийн дүнг дээрх 1.2-т заасан валютаар илэрхийлж доорх хүснэгтэд бичнэ. Түүнчлэн хийхээр төлөвлөсөн болон одоо хийж буй ажил, тэдгээрийг дуусгахаар төлөвлөж буй хугацааг жагсаах.

| Төслийн нэрба улс | Захиалагч, үйлчлүүлэгчийннэр, холбоо барих ажилтан | Гүйцэтгэсэн ажлын төрөл, дууссан он | Гэрээний үнэ |
|---|---|---|---|
| (а) | | | |
| (б) | | | |

1.4. Гэрээг гүйцэтгэхэд санал болгож буй барилгын үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрлийн талаарх мэдээллийг доорх хүснэгтээр ирүүлнэ. Мөн ТӨЗ-ны 5.2(е)-г анхаар.

| Тоногтөхөөрөмжийн нэр төрөл | Тодорхойлолт,хаана үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа (жилээр) | Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), ба тоо ширхэг | Өөрийн, түрээслэх,эсхүл худалдаж авах (хаанаас?) |
|---|---|---|---|
| (а) | | | |
| (б) | | | |

1.5. Гэрээнд санал болгож буй удирдах болон техникийн голлох мэргэжилтний чадвар, туршлага. Намтрыг хавсаргана. Мөн ТӨЗ-ны 5.3(г) болон гэрээний ерөнхий нөхцөлийн 9.1-ийг анхаар.

| Албан тушаал | Нэр | Ажилласан жил (нийт) | Санал болгож буй албан тушаалтай ижил албан тушаалд ажилласан жил |
|---|---|---|---|
| (а) | | | |
| (б) | | | |

1.6. Санал болгож буй туслан гүйцэтгэгч. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг анхаар.

| Ямар ажилгүйцэтгэх | Туслан гүйцэтгэхгэрээний үнэ | Туслан гүйцэтгэгч (нэр, хаяг) | Ижил төстэй ажлын туршлага | Шийдэгдсэнбайдал |
|---|---|---|---|---|
| (а) | | | | |
| (б) | | | | |

1.7. Санхүүгийн чадавхийг харуулах аудитаар баталгаажуулсан сүүлийн ***[тоо]*** жилийн санхүүгийн тайлан, ашиг орлого, алдагдлын болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн тайлан, дүгнэлтийн хамт. Дор жагсааж хувийг хавсаргана.

1.8. Чадварын шаардлагыг хангахад шаардагдаж болох санхүүгийн эх үүсвэрийн нотолгоо: бэлэн мөнгө, зээл гэх мэт. Дор жагсааж үндсэн бичиг баримтын хувийг хавсаргана.

1.9. Тендерт оролцогчийн харилцагч банкны нэр, хаяг болон утас, факсын дугаар.

1.10. Тендерт оролцогчийн одоогийн ба сүүлийн [тоо] жилийн хугацаанд оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талууд ба нэхэмжлэлийн мөнгөн дүн, шийдэгдсэн байдал.

| Нөгөө тал(ууд) | Маргааны шалтгаан | Нэхэмжлэлийн мөнгөн дүн | Шийдэгдсэн байдал |
|---|---|---|---|
| (а) | | | |
| (б) | | | |

1.11. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 4.2-т хамрагдахгүй бөгөөд эрх бүхий тухай мэдэгдэл.

1.12. Санал болгож буй ажлын хөтөлбөр (ажлын арга барил ба хуваарь). Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангахуйц тодорхойлолт, зураг болон бүдүүвч шаардлагатай бол.

**2. Түншлэл**

2.1. Чадварын мэдээллийн 1.1-1.11-д дурдсан бүх мэдээллийгтүншлэлийн гишүүн тус бүрээр гаргаж ирүүлнэ.

2.2. Чадварын мэдээллийн 1.12-т дурдсан мэдээллийг түншлэлийн хувьд гаргаж ирүүлнэ.

2.3. Түншлэлийн нэрийн өмнөөс тендерт гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн итгэмжлэлийг хавсаргана.

2.4. Дор дурдсан шаардлагыг хангасан түншлэлийн бүх гишүүдийн хооронд байгуулсан гэрээг хавсаргана. Үүнд:

2.5.

(а) гэрээний нөхцөлийн дагуу гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүд хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхой заасан байх;

(б) түншлэлийн аль нэг болон бүх гишүүдийн нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилсон байх;

(в) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцох.

**МАЯГТ №: ТШМ-3А**

## ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
## (БАНКНЫ БАТАЛГАА)

***[Захиалагч байгууллагын нэр]***

*[Тендерт оролцогчийн нэр]* (цаашид "Тендерт оролцогч" гэх) нь *[Тендер шалгаруулалтын нэр]* бараа нийлүүлэхээр тендер (цаашид "Тендер" гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар *[Банкны нэр]* (цаашид "Банк" гэх) нь *[захиалагчийн нэр]* (цаашид "захиалагч" гэх)-ийн өмнө нийт *[мөнгөн дүн]*–ийн төлбөр хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

(1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;

(2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:

(а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;

(б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;

(в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь ***[огноог оруул]*** өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

**МАЯГТ №: ТШМ-3Б**

# ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
# (ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН БАТАЛГАА)

***[Захиалагч байгууллагын нэр]***

*[Тендерт оролцогчийн нэр]* (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь *[Тендер шалгаруулалтын нэр]* бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар *[Хөрөнгийн бирж]* (цаашид “Бирж” гэх) нь *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт *[мөнгөн дүн]*–ийн төлбөр хийх үүрэг хүлээж тендерт оролцогчийн засгийн газрын бондыгүндэслэн батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

(1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;

(2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:

   (а) тендерт оролцогчид өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;

   (б) тендерт оролцогчид өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;

   (в) тендерт оролцогчид өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй засгийн газрын бондыг үл маргалдах журмаар шилжүүлнэ.

Энэхүү баталгаа нь ***[огноог оруул]*** өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж биржид мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банк/Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банк /Биржийн тамга

Огноо:

Хаяг:

**МАЯГТ № ТШМ-4**

## ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

(Захиалагчийн албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ)

| ***Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлийг бичих санамж*** |
|---|
| *Тендерт оролцогчдод єгєх зааварчилгааны дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь хэлцэл хийгдсэн гэж үзэх үндэслэл болно. Захиалагч энэхүү гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг зєвхєн шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.* |

*[огноо]*

*[Гүйцэтгэгчийн нэр]*-ийн дарга___________________________ Танаа,

Гэрээ байгуулах эрх олгох тухай

***[Гэрээний тусгай нөхцөлд заасан тендер шалгаруулалт/ гэрээний нэр ба дугаар]***-ыг ***[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]*** гүйцэтгэхээр ***[огноо]***-ндирүүлсэн танай тендерийг тендерт оролцогчдод өгөх зааварчилгаанд тусгасны дагуу залруулга, тохируулгахийсэн байдлаар манай байгууллага хүлээн зөвшөөрснийг мэдэгдье.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш ***[тоо]*** хоногийн дотор гэрээний маягтад гарын үсэг зурж ирүүлнэ үү.

Шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг энэхүү мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

Гэрээний маягт, нөхцөлүүдийг хавсаргав.

Захиалагч байгууллагын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

# ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Техникийн тодорхойлолтыг бэлтгэх санамж**

Товч бөгөөд тодорхой бэлтгэгдсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана.

Эдгээрийг хангасан нөхцөлд л худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийг үнэлэх үнэлгээ зөв явагдана. Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн, эсхүл орчин үеийн загварын, зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн шаардлагыгтусгасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардах ёстой.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн бараа, ажлын стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Авто зам, усан зогсоол, төмөр зам, орон сууц, усжуулалт, усан хангамж гэх зэрэг дэд бүтцийн салбаруудад тухайн бүс нутгийн ижил төстэй нөхцөлд давтагдаж хийгдэх ажлуудад стандарт ерөнхий техникийн тодорхойлолтыг хэрэглэх нь ихээхэн давуу талтай. Хэдийгээр тухайлсан ажлын гэрээнд заавал хэрэглэх шаардлагагүй хэдий ч барилгын ажилдхамаарах онцлог шинж чанар, материал, тоног төхөөрөмжийн бүх ангиллыг ерөнхий техникийн тодорхойлолтод тусгах шаардлагатай. Тухайн ажлын техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ ерөнхий техникийн тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт хийх буюу шаардлагагүй зүйлийг түүнээс хасна.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материал, шинж чанарын талаарх техникийн тодорхойлолтын стандартад аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартыг хангах буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй. Дараах заалтыг гэрээний тусгай нөхцөлд, эсхүл техникийн тодорхойлолтод тусгаж болно.

**Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал**

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал болон хийгдэх, эсхүл турших ажлын стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй жишихүйц, эсхүл түүнээс илүү чанартай бусад стандарт, кодыг төслийн менежер хянаж, бичгээр зөвшөөрөл олгосон бол хүлээн зөвшөөрнө. Заасан стандарт болон санал болгосон хувилбарт стандартын хоорондын ялгааг нийлүүлэгч бичгээр тодорхойлон гаргах бөгөөд зөвшөөрлийг авахыг хүсч байгаа өдрөөс 28-аас доошгүй хоногийн өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер эдгээр зөрүүг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд нийлүүлэгч бичиг баримтад заасан стандартыг хангах үүрэгтэй.

*Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд зориулсан эдгээр санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримтбичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно.*
*Эдгээрийг эцсийн бичиг баримтад оруулах шаардлагагүй.*

## ЗУРАГ

**Зургийн санамж**

*Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.*

## ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ[9]

**Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж**

**Зорилт**

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх боломжоог хангах;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

**Ажил-өдрийн хуваарь**

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нэгж, эсхүл нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

**Магадлашгүй зардал**

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх боломжоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн), хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримтбичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн бичиг баримтад оруулахгүй.*

[9] 60 дугаар хуудасны "Гэрээний жишиг маягтын санамж"-ийг үз.

**ТАВДУГААР БҮЛЭГ.**

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

**Гэрээний ерөнхий нөхцөлийн санамж**

Гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцөл, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх үүргийг тодорхойлох баримт бичиг болно.

Энэ гэрээний ерөнхий нөхцөлийг нийт үнийн гэрээнд шууд хэрэглэж болно. Нэгж үнийн гэрээнд хуудасны зүүлтийг баримтлан өөрчлөлт хийн хэрэглэж болно.

Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулах шаардлагатай бол үүнийг гэрээний тусгай нөхцөлд тусгаж өгнө.

## ГАРЧИГ

**А. Ерөнхий заалт**

1. Нэр томъёо
2. Тайлбарлах
3. Гэрээний хэл ба хууль
4. Төслийн менежерийн шийдвэр
5. Үүрэг, хариуцлагыг шилжүүлэх
6. Харилцаа
7. Ажил туслан гүйцэтгүүлэх
8. Бусад гүйцэтгэгчид
9. Ажиллах хүчин
10. Захиалагч, гүйцэтгэгчийн хүлээх эрсдэл
11. Захиалагчийн хүлээх эрсдэл
12. Гүйцэтгэгчийн хүлээх эрсдэл
13. Даатгал
14. Ажлын талбайн судалгааны тайлан
15. Гэрээний тусгай нөхцөлийн тухай асуулга
16. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх
17. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх
18. Төслийн менежер баталгаа гаргах
19. Аюулгүй байдал
20. Олдвор
21. Ажлын талбайг ашиглуулах
22. Ажлын талбайд нэвтрэн орох
23. Зааварчилгаа
24. Маргааныг шийдвэрлэх

**Б. Хугацааны хяналт**

25. Ажлын хөтөлбөр
26. Ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгах
27. Төслийн менежерийн шийдвэрээр хугацааг хойшлуулах
28. Ажлын уулзалт
29. Урьдчилан анхааруулах журам

**В. Чанарын хяналт**

30. Зөрчил, гологдол илрүүлэх
31. Туршилт
32. Зөрчил, гологдол арилгах
33. Зөрчил, гологдол арилгахгүй байх

**Г. Зардлын хяналт**

34. Үе шатны ажлын хуваарь
35. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх
36. Өөрчлөлт
37. Өөрчлөлтийн улмаас хийх төлбөр
38. Бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоо
39. Төлбөрийн мэдэгдэл
40. Төлбөр
41. Нөхөн төлбөр хийх нөхцөл
42. Татвар
43. Валют
44. Үнийн тохируулга
45. Барьцаа хөрөнгө
46. Алданги
47. Урамшуулал
48. Урьдчилгаа төлбөр
49. Баталгаа
50. Ажил-өдөр
51. Засварын зардал

**Д. Гэрээг дуусгах**

52. Ажил дуусгах
53. Хүлээж авах

54. Эцсийн тооцоо
55. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага
56. Гэрээг цуцлах
57. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр
58. Өмч
59. Гүйцэтгэлээс чөлөөлөх

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### A. ЕРӨНХИЙ ЗААЛТ

**1. Нэр томъёо**

1.1. Тодорхойлсон нэр томъёог тод үсгээр бичив.

**Үе шатны ажлын хуваарь /ажлын тоо хэмжээ/** гэж гүйцэтгэгчээс үе шатны ажил/ажлын тоо хэмжээ/-ын үнийг тусгаж тендерийн хамт ирүүлсэн хуваарийг хэлнэ.

**Нөхөн төлбөр хийх нөхцөл** гэж энэхүү ГЕН-ийн 41 дүгээр зүйлд тодорхойлсон нөхцөлүүдийг хэлнэ.

**Ажил дууссан өдөр** гэж ГЕН-ийн 52.1-д заасны дагуу ажил дууссаныг төслийн менежер гэрчилсэн өдрийг хэлнэ.

**Гэрээ** гэж захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх, дуусгах, засвар үйлчилгээ явуулах гэрээг хэлнэ. Гэрээ нь гэрээний маягтын 5 дугаар зүйлд дурдсан баримт бичгээс бүрдэнэ.

**Гүйцэтгэгч** гэж захиалагчийн хүлээн зөвшөөрсөн тендерийг ирүүлсэн этгээдийг хэлнэ.

**Тендер** гэж захиалагчийн тавьсан нөхцөл, болзлын дагуу гүйцэтгэгчийн бэлтгэж ирүүлсэн иж бүрдэл баримт бичгийг хэлнэ.

**Гэрээний үнэ** гэж гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд дурдсан, гэрээний заалтын дагуу цаашид тохируулж болох үнийг хэлнэ.

**Хоног** гэж хуанлийн хоногийг, **сар** гэж хуанлийн сарыг тус тус хэлнэ.

**Ажил-өдөр** гэж ажлын төлбөр нь гүйцэтгэгчийн ажиллах хүч болон тоног төхөөрөмжийн ажилласан хугацаанд (хүн-цаг болон машин-цаг) үндэслэн хийгдэх зардлыг хэлнэ.

**Зөрчил, гологдол** гэж зураг төсөл, техникийн тодорхойлолтыг зөрчсөн, чанарын гологдол гаргасан буюу ажлын гэрээнд заасны дагуу хийгдээгүй ажлыг хэлнэ.

**Зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл** гэж гүйцэтгэгч зөрчил, гологдлыг арилгасныг үндэслэн төслийн менежерийн гаргасан баталгааг хэлнэ.

**Чанарын баталгаат хугацаа** гэж гэрээний тусгай нөхцөлд заасан, ажил дууссан өдрөөс эхлэн тоологдох хугацааг хэлнэ. Энэ хугацаанд илэрсэн зөрчил, гологдлыг гүйцэтгэгч арилгах үүрэгтэй.

**Зураг** гэж батлагдсан зураг төсөл болон түүнтэй холбоотойгоор төслийн менежерийн гаргасан, баталсан тооцоо, бусад мэдээллийг хэлнэ.

**Захиалагч** гэж ажил хийлгэхээр гүйцэтгэгчийг хөлслөн ажиллуулж буй этгээдийг хэлнэ.

**Тоног төхөөрөмж** гэж ажил гүйцэтгэх зорилгоор ажлын талбайд түр хугацаагаар авчирсан гүйцэтгэгчийн машин механизм, тээврийн хэрэгслийг хэлнэ.

**Гэрээний анхны үнэ** гэж гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд захиалагчийн дурдсан гэрээний үнийг хэлнэ.

**Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр** гэж гэрээнд гүйцэтгэгч ажлыг дуусгахаар заасан өдрийг хэлнэ. Зөвхөн төслийн менежер хугацаа сунгах,

эсхүл хурдасгах захиалга өгснөөр ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг өөрчилж болно.

**Материал** гэж ажлын зорилгоор гүйцэтгэгчийн ашиглах бүх төрлийн барилгын материал, түүхий эд, хийц, бүтээгдэхүүн, эд анги болон бусад зүйлсийг хэлнэ.

**Байгууламж** гэж ажлын механик, цахилгаан, хими, эсхүл биологийн үйл ажиллагаа бүхий (функцтэй) бүрдэл хэсгийг хэлнэ.

**Төслийн менежер** гэж ажлын гүйцэтгэлд хяналт тавьж гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий гэрээний тусгай нөхцөлд дурдсан этгээд (эсхүл төслийн менежерийн оронд ажиллуулахаар захиалагчийн томилж, гүйцэтгэгчид мэдэгдсэн этгээд)-ийг хэлнэ.

**Ажлын талбай** гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.

**Ажлын талбайн судалгааны тайлан** гэж ажлын талбайн гадаргуу, хөрс, цаг уурын нөхцөл, байгаль орчны үнэлгээ зэргийн талаар бодит байдлыг дурдаж тайлбарлаж тендерийн баримт бичигт хавсаргасан тайланг хэлнэ.

**Техникийн тодорхойлолт** гэж гэрээнд заасан ажлын техникийн тодорхойлолт бөгөөд түүнд төслийн менежерийн оруулсан болон баталсан нэмэлт өөрчлөлтүүд мөн хамаарна.

**Ажил эхлэх өдөр** гэж гүйцэтгэгчийн ажил эхлүүлэх өдрийг хэлнэ. Энэ өдрийг гэрээний тусгай нөхцөлд заах бөгөөд ажлын талбайг эзэмших өдөртэй давхцаагүй байж болно.

**Туслан гүйцэтгэгч** гэжгэрээнд тусгагдсан ажлын тодорхой хэсгийг хийхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан этгээдийг хэлнэ.

**Туслах ажил** гэж гүйцэтгэгч ажлыг барьж байгуулах, суурилуулахад шаардлагатайн улмаас төлөвлөж, барьж, суурилуулж, зайлуулсан ажлыг хэлнэ.

**Өөрчлөлт** гэж ажилд өөрчлөлт оруулах талаар төслийн менежерийн өгсөн зааварчилгааг хэлнэ.

**Ажил** гэж гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгөх гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон ажлыг хэлнэ.

**2. Тайлбар**

2.1. Энэхүү гэрээний ерөнхий нөхцөлд ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно. Гарчигт гол ач холбогдол өгөхгүй. Онцгойлон заагаагүй бол гэрээний үгийг шууд утгаар нь хэрэглэнэ. Гэрээний нөхцөлийн талаарх тодруулга, тайлбарыг төслийн менежер гаргана.

2.2. Хэрэв гэрээний тусгай нөхцөлд ажлыг үе шатаар буюу хэсэгчлэн дуусгахаар заасан бол гэрээний ерөнхий нөхцөл дэх ажил, ажил дууссан өдөр, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр гэсэн нэр томъёонууд (бүх ажилд хамааралтай ажил дуусгах өдөр болон ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр гэсэн нэр томъёоноос бусад) нь ажлын хэсэг бүрт хамаарна.

**3. Гэрээний хэл ба хууль**

3.1. Гэрээний хэл ба гэрээнд хэрэглэх хуулийг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

**4. Төслийн менежерийн шийдвэр**

4.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.

**5. Үүрэг, хариуцлагыг шилжүүлэх**

5.1. Төслийн менежер нь гүйцэтгэгчид мэдэгдсэнээр хариуцсан үүргээ бусад этгээдэд шилжүүлж болох ба үүнийг хүчингүй болгохдоо мөн гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

**6. Харилцаа**

6.1. Талуудын гэрээний ерөнхий нөхцөлд холбогдох харилцаа нь зөвхөн бичгээр харилцсан тохиолдолд хүчинтэй байна. Бичгээр гаргасан мэдэгдэл нь нөгөө тал хүлээн авснаар хүчинтэй болно.

**7. Ажил туслан гүйцэтгүүлэх**

7.1. Гүйцэтгэгч төслийн менежерийн зөвшөөрснөөр ажлыг туслан гүйцэтгүүлж болох боловч захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээнд заасан ажил, үүргийг бусдад шилжүүлж болохгүй. Ажлыг туслан гүйцэтгүүлэх нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

**8. Бусад гүйцэтгэгчид**

8.1. Гүйцэтгэгч нь бусад гүйцэтгэгч, засаг захиргааны байгууллага, нийтийн үйлчилгээний газар болон гэрээний тусгай нөхцөлийн дагуу бусад гүйцэтгэгчдийн хуваарьт заасан хугацаанд ажлын талбайг хамтран ашиглаж ажиллах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь тэдгээр этгээдийг уг хуваарьт заасны дагуу ажлын хэрэгсэл, үйлчилгээгээр хангана. Захиалагч нь бусад гүйцэтгэгчдийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд энэ тухайгаа гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

**9. Ажиллах хүчин**

9.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчнийг, эсхүл төслийн менежерийн зөвшөөрсөн бусад ажиллах хүчнийг ажиллуулна. Голлох мэргэжилтнийг өөрчлөх тухай гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг зөвхөн санал болгож буй орлох мэргэжилтний чадвар нь дээрх хуваарьт заасан шаардлагын түвшинд, эсхүл түүнээс өндөр түвшинд байх нөхцөлд төслийн менежер зөвшөөрч батлана.

9.2. Хэрэв төслийн менежер гүйцэтгэгчийн аль нэг ажилтныг цаашид ажиллуулахгүй байх талаар үндэслэл бүхий саналыг гүйцэтгэгчид тавьсан бол гүйцэтгэгч тухайн ажилтанг 7 хоногийн дотор ажлаас чөлөөлж, түүнийг цаашид гэрээний дагуу гүйцэтгэх ажилд оролцуулахгүй.

**10. Захиалагч, гүйцэтгэгчийн хүлээх эрсдэл**

10.1. Захиалагч, гүйцэтгэгч нь захиалагчийн хүлээх эрсдэл, гүйцэтгэгчийн хүлээх эрсдэл гэж гэрээнд тодорхойлогдсон эрсдлийг тус тус хүлээнэ.

**11. Захиалагчийн хүлээхэрсдэл**

11.1. Ажил эхлэх өдрөөс зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гарах өдөр хүртэл хугацаанд захиалагч дор дурдсан эрсдлийг хүлээнэ:

(а) Дараах зүйлээс шалтгаалан хүн бэртэх, нас барах, эсхүл эд хөрөнгө алдагдах, эвдэрч гэмтсэнээс үүсэх (ажил, байгууламж, материал, тоног төхөөрөмж үл хамаарна) эрсдэл:

1) ажлын талбайг гэрээний дагуу ашиглах, эсхүл эзэмших явцад урьдчилан сэргийлэх боломжгүй;

2)

3)

4) захиалагч, эсхүл түүний хөлслөн ажиллуулж буй гүйцэтгэгчээс бусад этгээдийн хариуцлагагүй, хууль ёсны үүргээ зөрчсөн, эсхүл түүнд олгогдсон эрхийг буруу эдэлсний улмаас үүдэн гарсан.

(б) Захиалагчийн гэм буруугаас, эсхүл захиалагчийн зураг төслийн алдаанаас, эсхүл гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас ажил, байгууламж, материал болон тоног төхөөрөмж гэмтэх эрсдэл.

11.2. Ажил дууссан өдрөөс зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гарсан өдөр хүртэл хугацаанд ажил, байгууламж, материал алдагдах, эвдэрч гэмтэх эрсдэл нь дор дурдсанаас бусад тохиолдолд захиалагчийн хүлээх эрсдэл болно:

(а) ажил дууссан өдөр илэрсэн зөрчил, гологдол;

(б) захиалагчийн хүлээх эрсдэлд хамаарахгүй бөгөөд ажил дууссан өдрөөс өмнө бий болсон зөрчил, гологдол;

(в) ажил дууссан өдрөөс хойш ажлын талбай дээр гүйцэтгэгчийн явуулсан үйл ажиллагаанаас үүдсэн зөрчил, гологдол.

**12. Гүйцэтгэгчийн хүлээх эрсдэл**

12.1. Ажил эхлэх өдрөөс зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргасан өдөр хүртэлх хугацаанд хүн бэртэх, нас барах, түүнчлэн эд хөрөнгө (ажил, байгууламж, материалыг оролцуулах бөгөөд эдгээрээр хязгаарлахгүй) алдагдах, эвдэрч гэмтэхээс үүдэн гарсан бөгөөд захиалагчийн хүлээх эрсдлээс бусад эрсдлийг гүйцэтгэгч хүлээнэ.

**13. Даатгал**

13.1. Гүйцэтгэгчийн хүлээх эрсдэлд хамаарах дор дурдсан тохиолдлын даатгалыг гүйцэтгэгч нь ажил эхлэх өдрөөс чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл хугацаанд гүйцэтгэгч, захиалагчийн хамтарсан нэрээр, гэрээний тусгай нөхцөлд заасан дүнгээр хийлгэнэ:

(а) ажил, байгууламж болон материал алдагдах, эвдэрч гэмтэх;

(б) тоног төхөөрөмж алдагдах, эвдэрч гэмтэх;

(в) гэрээний хэрэгжилттэй холбогдож эд хөрөнгө (ажил, байгууламж, материал, тоног төхөөрөмжөөс бусад) алдагдах, эвдэрч гэмтэх;

(г) хүн бэртэх, эсхүл нас барах.

13.2. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээг ажил эхлэх өдрөөс өмнө төслийн менежерт хүргүүлж батлуулна. Даатгалыг 13.1-д заасан тохиолдлоос үүдэн гарсан хохирлыг арилгахад зориулж гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хийлгэнэ.

13.3. Хэрэв гүйцэтгэгч шаардлагатай даатгалын гэрээ, гэрчилгээг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын төлбөрийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авна. Хэрэв захиалагчаас гүйцэтгэгчид төлөх төлбөр байхгүй бол даатгалын төлбөр нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх өр болно.

13.4. Даатгалын нөхцөлийг төслийн менежерийн зөвшөөрөлгүйгээр өөрчилж болохгүй.

13.5. Хоёр тал даатгалын гэрээний бүх нөхцөлийг биелүүлнэ.

**14. Ажлын талбайн судалгааны тайлан**

14.1. Гүйцэтгэгч тендер бэлтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд дурдсан ажлын талбайн судалгааны тайлан болон тендерт оролцогчидзориулсан бусад нэмэлт мэдээллийг ашигласан байна.

**15. Гэрээний тусгай нөхцөлийн тухай асуулга**

15.1. Гэрээний тусгай нөхцөлийн талаар гарсан асуудлыг төслийн менежер тодруулж, тайлбар гаргана.

| | |
|---|---|
| **16. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** | 16.1. Гүйцэтгэгч ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| **17. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** | 17.1. Гүйцэтгэгч ажлыг товлосон өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| **18. Төслийн менежер баталгаа гаргах** | 18.1. Гүйцэтгэгч санал болгож буй магадлашгүй ажил, туслах ажлын техникийн тодорхойлолт, зургийг гарган холбогдох байгууллагаар хянан баталгаа хийлгэж, төслийн менежерт хүргүүлэх ба эдгээр нь ажлын техникийн тодорхойлолт, зурагт нийцсэн тохиолдолд төслийн менежер түүнийг батална. |
| | 18.2. Гүйцэтгэгч нь туслах ажлын зураг төслийг хариуцна. |
| | 18.3. Төслийн менежер магадлашгүй ажил, туслах ажлын зураг төслийг батлах нь туслах ажлын зураг төсөлтэй холбоотой гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй |
| | 18.4. Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч туслах ажлын зураг төсөлд холбогдох байгууллагын зөвшөөрөл авна. |
| | 18.5. Гүйцэтгэгчийн бэлтгэсэн түр болон үндсэн ажилд ашиглах бүх зургийг ажил эхлэхээс өмнө төслийн менежер батална. |
| **19. Аюулгүй байдал** | 19.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна. |
| | 19.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| **20. Олдвор** | 20.1. Ажлын талбайд санамсаргүй олж илрүүлсэн түүх дурсгалын болон бусад үнэт эд зүйлс нь Монгол Улсын өмч болно[10]. Гүйцэтгэгч нь олдворыг төслийн менежерт мэдэгдэж, энэ талаар түүний зааварчилгаар биелүүлнэ. |
| **21. Ажлын талбайг ашиглуулах** | 21.1. Захиалагч барилга барих эдэлбэр газрын болон барилгын талбайд орсон бүх төрлийн барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, авто болон төмөр замыг буулгах, зөөх, шилжүүлэх, хөдөлгөөнийг зогсоох зөвшөөрөл, уг барилгын цахилгаан, дулаан, цэвэр, бохир усан хангамж, уур, телефон, радио холбооны инженерийн шугам сүлжээнд холбох эх үүсвэрийг тодорхойлсон техникийн нөхцөл, зураг төсөл, барилгын ажил эхлэх зөвшөөрөл, улаан шугам тавьсан акт, бусад холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгч ажлын талбайн бүх хэсгийг гүйцэтгэгчид ашиглуулна. |
| | 21.2. Хэрэв аль нэг хэсгийг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ашиглуулж эхлээгүй бол захиалагчийн зүгээс холбогдох ажлыг эхлэхэд саад болсонд тооцож, энэ нь нөхөн төлбөр хийх нөхцөл болно. |
| **22. Ажлын талбайд нэвтрэн орох** | 22.1. Гүйцэтгэгч нь төслийн менежер болон түүний эрх олгосон аливаа этгээдийг ажлын талбайд болон гэрээний ажилтай холбоотой ажил явагдаж буй, эсхүл хийхээр төлөвлөж буй аливаа газарт нэвтрүүлэх үүрэгтэй. |

[10] Төслийн менежер нь олж илрүүлсэн түүх дурсгалын болон бусад үнэт эд зүйлсийг зохих журмын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ.

**23. Зааварчилгаа**

23.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.

**24. Маргааныг шийдвэрлэх**

24.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Б. ХУГАЦААНЫ ХЯНАЛТ

**25. Ажлын хөтөлбөр**

25.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

25.2. Ажлын хөтөлбөрийг тодотгохдоо үйл ажиллагаа бүрийн явц, үр дүн, тэдгээрийн үлдэж буй ажлыг гүйцэтгэх хугацаанд үзүүлэх нөлөө болон үйл ажиллагааны дараалалд оруулсан аливаа өөрчлөлтийг тусгана.

25.3. Гүйцэтгэгч нь тодотгосон ажлын хөтөлбөрийг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт батлуулахаар хүргүүлнэ. Хэрэв гүйцэтгэгч тодотгосон ажлын хөтөлбөрийг энэ хугацаанд хүргүүлээгүй бол төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан дүнг дараагийн гүйцэтгэлийн төлбөрөөс хасч гүйцэтгэгч ажлын хөтөлбөр ирүүлсний дараа хийгдэх төлбөр хүртэл саатуулж болно.

25.4. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлт болон нөхөн төлбөр хийх нөхцөлийн нөлөөг тусгана.

**26. Ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгах**

26.1. Хэрэв нөхөн төлбөр хийх нөхцөл үүссэн, эсхүл өөрчлөлтийн улмаас гүйцэтгэгч нэмэлт зардал гаргалгүйгээр ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр түүнийг дуусгах боломжгүй бол төслийн менежер ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгана.

26.2. Гүйцэтгэгч үүссэн нөхөн төлбөр хийх нөхцөл, эсхүл өөрчлөлтийн үр дагаврын талаар зохих шийдвэр гаргахыг хүсч, холбогдох мэдээллийг ирүүлснээс хойш 21 хоногийн дотор төслийн менежер нь ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгах эсэх, сунгах бол ямар хугацаагаар сунгах тухай шийдвэр гаргана. Хэрэв гүйцэтгэгч хугацаа хоцорсныг урьдчилан анхааруулаагүй, эсхүл хугацаа хоцролтыг арилгах асуудлаар хамтран ажиллаж чадаагүй бол үүнийг ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг шинээр тогтооход харгалзан үзэхгүй.

**27. Төслийн менежерийн шийдвэрээр хугацааг хойшлуулах**

27.1. Төслийн менежер ажлын аль нэг үйл ажиллагааны эхлэл, эсхүл явцыг хойшлуулах зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

**28. Ажлын уулзалт**

28.1. Төслийн менежер болон гүйцэтгэгчийн аль аль нь ажлын уулзалтад оролцохыг нөгөө талаасаа шаардах эрхтэй. Ажлын уулзалтад үлдэж буй ажлын төлөвлөгөөг хянан үзэж, урьдчилан анхааруулах журмын дагуу гарсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

28.2. Төслийн менежер ажлын уулзалтын тэмдэглэлийг үйлдэж, уг тэмдэглэлийн хувийг уулзалтад оролцсон хүмүүст болон захиалагчид хүргүүлнэ. Хийгдэх арга хэмжээнд талуудын хүлээх үүрэг хариуцлагыг төслийн менежер уг ажлын уулзалтан дээр, эсхүл түүний дараа шийдвэрлэж, энэ тухай ажлын уулзалтад оролцсон бүх этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

**29. Урьдчилан анхааруулах журам**

29.1. Гүйцэтгэгч ажлын чанарт сөргөөр нөлөөлөх, гэрээний үнийг өсгөх, эсхүл хугацаа хоцроож болзошгүй нөхцөл байдлын талаар төслийн менежерт аль болох урьдаас урьдчилан анхааруулах үүрэгтэй. Төслийн менежер үүсчболзошгүй нөхцөл байдал нь гэрээний үнэ болон ажил дуусгахаар төлөвлөсөн хугацаанд хэрхэн нөлөөлж болох талаарх мэдээллийг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй. Гүйцэтгэгч уг мэдээллийг аль болох богино хугацаанд ирүүлнэ.

29.2. Гүйцэтгэгч эдгээр нөхцөл байдлын үр дагаврыг арилгах, эсхүл багасгах санал гаргаж төслийн менежерийн гаргасан зааварчилгаар хэрэгжүүлэхдээ түүнтэй хамтран ажиллана.

## В. ЧАНАРЫН ХЯНАЛТ

**30. Зөрчил, гологдол илрүүлэх**

30.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

**31. Туршилт**

31.1. Хэрэв төслийн менежер аливаа ажил зөрчил, гологдолтой эсэхийг шалгах зорилгоор техникийн тодорхойлолтод заагаагүй шалгалт туршилт явуулах зааварчилгаар гүйцэтгэгчид өгч, түүгээр зөрчил, гологдол илэрсэн бол гүйцэтгэгч шалгалт туршилт явуулсан зардлыг төлнө. Хэрэв зөрчил, гологдол илрээгүй бол шалгалт туршилт нь нөхөн төлбөр хийх нөхцөлд тооцогдоно.

**32. Зөрчил, гологдол арилгах**

32.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа[11]дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

32.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

**33. Зөрчил, гологдол арилгахгүй байх**

33.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## Г. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

**34. Үе шатны ажлын хуваарь[12]**

34.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны

[11] Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

[12] Нэгж үнийн гэрээнд ”үе шатныажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж сольж, 34.1 ба 34.2-ыг дараахбайдлаар өөрчилнө:

ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

34.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хувaариас тусад нь гаргаж ирүүлнэ.

**35. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх[13]**

35.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт, өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

**36. Өөрчлөлт**

36.1. Бүх өөрчлөлтийг гүйцэтгэгчийн боловсруулсан тодотгосон ажлын хөтөлбөр болон үе шатны ажлын хуваарьт[14] тусгасан байна.

**37. Өөрчлөлтийн улмаас хийх төлбөр**

37.1. Төслийн менежер шаардсан бол гүйцэтгэгч өөрчлөлтөөр хийгдэх ажлын үнийн саналыг түүнд гаргаж өгнө. Төслийн менежер шаардсанаас хойш 7 хоногийн дотор, эсхүл төслийн менежерийн тогтоосон үүнээс урт хугацаанд үнийн саналыг ирүүлнэ. Төслийн менежер үнийн саналыг хянаж үзсэний дараа өөрчлөлт хийх зөвшөөрөл өгнө.

37.2. [15]Хэрэв төслийн менежер нь гүйцэтгэгчийн гаргасан үнийн саналыг үндэслэлгүй гэж үзвэл гүйцэтгэгчийн зардалд уг өөрчлөлт хэрхэн нөлөөлөх талаарх өөрийн тооцоонд үндэслэн гэрээний үнийг өөрчлөн, уг өөрчлөлтийг баталж болно.

37.3. Хэрэв төслийн менежер ажилд яаралтай өөрчлөлт оруулах, ажлыг хугацаа хоцроолгүй гүйцэтгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гүйцэтгэгчээс үнийн санал авахгүй. Энэ өөрчлөлтийг нөхөн төлбөр хийх нөхцөл гэж үзнэ.

37.4. Гүйцэтгэгч урьдчилан анхааруулснаар гаргахгүй байх боломжтой байсан зардалд нэмэлт төлбөр нэхэмжлэх эрхгүй.

**38. Бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоо**

38.1. Гүйцэтгэгч ажлын хөтөлбөрийг, эсхүл үе шатны ажлын хуваарийг[16] тодотгосон тохиолдолд бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоог төслийн менежерт гаргаж ирүүлнэ. Бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоог гэрээнд заасан валютын төрөл, ханшаар хийнэ.

---

34.1 Ажлын тоо хэмжээнд барилга угсралт, суурилуулалт, туршилт болон ашиглалтад оруулах зэрэг гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажлын нэр төрлийг тусгана.

34.2 Ажлын тоо хэмжээг гэрээний үнийг тооцоход ашиглана. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын хөлсийг ажлын тоо хэмжээнд заасан тухайн нэр төрлийн ажлын нэгж үнээр тооцож төлнө.

[13] Нэгж үнийн гэрээнд ”үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж сольж, 35.1-ийг дараахь байдлаар өөрчилнө:

35.1 Хэрэв гүйцэтгэсэн ажлын эцсийн тоо хэмжээ нь ажлын тоо хэмжээнд тусгагдсан тухайн нэр төрлийн ажлын тоо хэмжээнээс 25-аас илүү хувиар зөрж, үүнээс шалтгаалсан өөрчлөлт нь гэрээний анхны үнээс 1-ээс илүү хувиар хэтэрвэл төслийн менежер энэхүү өөрчлөлтийн дагуу нэгж үнийг тохируулна.

35.2 Хэрэв ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөний улмаас гэрээний анхны үнэ 15-аас илүү хувиар өсөхөөр бол захиалагч урьдчилан батласнаас бусад тохиолдолд төслийн менежер өөрчлөлтийн дагуу нэгж үнийг тохируулах эрхгүй.

35.3 Гүйцэтгэгч нь ажлын тоо хэмжээнд тусгагдсан аливаа зардлын нэгж үнийн дэлгэрэнгүй задаргааг төслийн менежер шаардсаны дагуу гаргаж өгнө.

[14] Нэгж үнийн гэрээнд “болон үе шатны ажлын хуваарьт” гэснийг хасна.

[15] Нэгж үнийн гэрээнд энэ заалтын өмнө дараахь заалтыг оруулна:

37.2 Хэрэв өөрчлөлтөөр хийгдэх ажил нь ажлын тоо хэмжээнд байгаа ажлын нэр төрөлтэй тохирсон бөгөөд төслийн менежерийн үзэж буйгаар энэ ажлын хэмжээ нь 35.1-д заасан хязгаараас хэтэрсэн, эсхүл түүнийг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа нь нэгж үнийн зардлыг өөрчлөхөөргүй бол уг өөрчлөлтийн зардлыг тооцохдоо ажлын тоо хэмжээнд тусгагдсан нэгж үнийг ашиглана. Хэрэв нэгж үнийн зардал өөрчлөгдөх бол, эсхүл өөрчлөлтөөр хийгдэх ажлын шинж чанар болон түүнийг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа нь ажлын тоо хэмжээн дэх нэр төрлүүдтэй тохирохгүй бол гүйцэтгэгчийн гаргасан үнийн санал нь ажлын тухайн нэр төрлийн нэгж үнэ болно.”

[16] Нэгж үнийн гэрээнд “эсхүл үе шатны ажлын хуваарийг” гэснийг хасна.

**39. Төлбөрийн мэдэгдэл**

39.1. Гүйцэтгэгч нь хийгдсэн ажлын гүйцэтгэлийн тайланг сар бүр төслийн менежерт гаргаж өгөх бөгөөд түүнд нэхэмжилсэн дүн нь нийт гарсан зардлаас өмнө нэхэмжилсэн дүнг хассан хэмжээтэй байна.

39.2. Төслийн менежер гүйцэтгэгчийн ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг шалгаж, түүнд төлөх төлбөрийн дүнг тодорхойлж батална.

39.3. Гүйцэтгэсэн ажилд төлөх төлбөрийн дүнг тооцохдоо үе шатны ажлын хуваарьт заасан бүрэн хийж гүйцэтгэсэн үе шатны ажлын үнэд үндэслэнэ.[17]

39.4. Гүйцэтгэсэн ажилд төлөх төлбөрийн дүн нь өөрчлөлтөөр хийгдсэн ажлын болон нөхөн төлбөрийн зардлыг багтаана.

39.5. Өмнөх төлбөрийн мэдэгдэлд хамрагдсан зардлыг дахин нэхэмжилсэн бол төслийн менежер түүнийг төлбөр хийх дүнгээс хасна.

**40. Төлбөр**

40.1. Төлбөр хийхдээ холбогдох урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгийг хасна. Захиалагч нь төслийн менежерийн баталсан дүнг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд гүйцэтгэгчид төлнө. Хэрэв захиалагч төлбөрийг хугацаанд нь хийгээгүй бол хугацаа хоцруулсан төлбөрт ногдох торгуулийг дараагийн төлбөр хийхдээ хамт төлнө. Торгуулийг төлбөр төлөх ёстой байсан өдрөөс төлбөрийг хийсэн өдөр хүртэлх хугацаанд тооцно. Торгуулийг тооцохдоо төлбөрийн валют тус бүрийн арилжааны зээлийн хүүгийн тухайн үеийн зонхилох ханшийг баримтлана.

40.2. Хэрэв сүүлд ирүүлсэн мэдэгдлээр, эсхүл шүүхийн шийдвэрийн улмаас өмнөх мэдэгдэлд заагдсан дүн нэмэгдсэн бол хугацаа хоцорсон төлбөрт ногдох торгуулийг энэ зүйлд заасны дагуу гүйцэтгэгчид төлнө. Торгуулийг нэмэгдсэн дүнг төлөх ёстой байсан өдрөөс эхлэж тооцно.

40.3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол, бүх төлбөр, суутгалыг гэрээний үнийг бүрдүүлэх валютын хувь хэмжээгээр тооцож төлөх буюу суутгана.

40.4. Нэгж болон нийт үнийг тусгаагүй ажлын нэр төрөлд захиалагч төлбөр хийхгүй бөгөөд тэдгээрийг гэрээнд заасан бусад нэгж болон нийт үнэд орсон гэж үзнэ.

**41. Нөхөн төлбөр хийх нөхцөл**

41.1. Дор дурдсан нөхцөлүүд нь нөхөн төлбөр хийх нөхцөл болно:

(а) захиалагч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлынталбайг ашиглуулах хугацаанд багтаж ажлын талбайн аль нэг хэсгийг ашиглах боломжийг гүйцэтгэгчид олгоогүй;

(б) захиалагч бусад гүйцэтгэгчдийн хуваарьт гүйцэтгэгчийн гэрээний дагуу хийх ажилд нөлөөлөхөөр нэмэлт өөрчлөлт оруулсан;

(в) төслийн менежер ажлыг хойшлуулах шийдвэр гаргасан, эсхүл ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардагдах зураг, техникийн тодорхойлолт, зааварчилгаа зэргийг гаргаж өгөөгүй;

(г) төслийн менежер нь ажлын далд хэсгийг нээх, эсхүл нэмэлт шалгалт туршилт явуулах зааварчилгаар гүйцэтгэгчид өгсөн ба үүгээр зөрчил, гологдол илрээгүй бол;

[17] Нэгж үнийн гэрээнд энэ заалтыг “Гүйцэтгэсэн ажилд төлөх төлбөрийн дүнг тооцохдоо ажлын тоо хэмжээнд заасан бүрэн хийж гүйцэтгэсэн нэр төрлийн тоо хэмжээний үнэд үндэслэнэ.” гэж солино.

(д) төслийн менежер нь ажлыг туслан гүйцэтгүүлэхийг үндэслэлгүйгээр батлаагүй;

(е) хөрсний нөхцөл нь тендерт оролцогчдод өгсөн мэдээлэл (ажлын талбайн судалгааны тайланг оролцуулан), нийтэд зарласан мэдээлэл болон ажлын талбайн хөрсний шинжилгээгээр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл өгөхөөс өмнө төсөөлж байснаас ихээхэн зөрүүтэй;

(ж) захиалагчийн үйл ажиллагааны улмаас бий болсон урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдлыг арилгах, аюулгүй байдлыг хангах, эсхүл бусад үндэслэлээр шаардагдсан нэмэлт ажил гүйцэтгэх зааварчилгааг төслийн менежер өгсөн;

(и) бусад гүйцэтгэгч, засаг захиргааны байгууллага, нийтийн үйлчилгээний газар, эсхүл захиалагч нь гэрээнд заасан хугацаа, бусад нөхцөлийг баримтлаагүйн улмаас гүйцэтгэгч нь хугацаа алдсан, эсхүл нэмэлт зардал гаргасан;

(к) урьдчилгаа төлбөр хугацаандаа хийгдээгүй;

(л) захиалагчийн хүлээх эрсдэл нь гүйцэтгэгчид нөлөөлсөн;

(м) төслийн менежер нь ажил дууссан тухай мэдэгдлийг үндэслэлгүйгээр хугацаа хоцроож гаргасан;

(н) гэрээнд заасан, эсхүл төслийн менежерийн тодорхойлсон нөхөн төлбөр хийх бусад нөхцөл.

41.2. Хэрэв нөхөн төлбөр хийх нөхцөл нь нэмэлт зардал гаргахад хүргэсэн, эсхүл ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажлыг дуусгахад саад болсон бол гэрээний үнийг өсгөх болон/эсхүл ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгана. Төслийн менежер нь гэрээний үнийг нэмэгдүүлэх санал гаргаж, ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

41.3. Гүйцэтгэгчийн зардалд нөхөн төлбөр хийх нөхцөл хэрхэн нөлөөлж буйг харуулсан тооцоо мэдээллийг гүйцэтгэгч ирүүлсэн тухай бүрт төслийн менежер нь түүнийг үнэлж, гэрээний үнийг тохируулна. Хэрэв гүйцэтгэгчийн гаргасан зардлын тооцоог үндэслэлгүй гэж үзвэл төслийн менежер өөрийн тооцоонд үндэслэн гэрээний үнийг тохируулна. Ингэхдээ гүйцэтгэгч тухайн тохиолдлын сөрөг үр дагаврыг арилгахад шаардлагатай арга хэмжээг шуурхай авна гэж тооцно.

41.4. Урьдчилан анхааруулаагүй, эсхүл төслийн менежертэй хамтран ажиллаагүйн улмаас захиалагчийн сонирхол хөндөгдсөн бол гүйцэтгэгчид нөхөн төлбөр төлөхгүй.

**42. Татвар**

42.1. Хэрэв тендер ирүүлэхээс ***[тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 17.6-д заасан тоотой ижил]*** хоногийн өмнөх өдөр болон ажил дууссан мэдэгдэл гарсан өдөр хүртэлх хугацаанд татвар, хураамж, бусад төрлийн төлбөрт өөрчлөлт орсон бол төслийн менежер гэрээний үнийг тохируулна. Гүйцэтгэгчийн төлөх татварын зөрүүний дүнгээр хийгдэх энэхүү тохируулга нь гэрээний үнэд өмнө нь тусгагдаагүй, эсхүл 44 дүгээр зүйлээс хамаараагүй байна.

**43. Валют**

43.1. Хуулийн дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдолд төлбөрийг төгрөгөөс өөр валютаар хийх бол төлбөрийн дүнг тооцохдоо тендер зарласан өдрийн Монголбанкны ханшийг ашиглана.

**44. Үнийн тохируулга**

44.1. Зөвхөн гэрээний тусгай нөхцөлд заасан нөхцөлд үндсэн материал, түүхий эд, ажиллах хүчний зардлын хэлбэлзлийг тусгах зорилгоор үнийн тохируулга хийнэ. Ингэхдээ төлбөрийн мэдэгдлийн нийт дүнгээс урьдчилгаа төлбөрийг хассан дүнгийн төлбөр хийх валют тус бүрийн үнийн дүнг холбогдох үнийн тохируулгын үзүүлэлт($P_c$)-ийг ашиглан тохируулна.

$$\mathbf{P_c = A_c + B_c \; Im_c / Io_c}$$

Энд:

**$P_c$**– гэрээний үнийн "c" валютаар төлөгдөх хэсэгт хийх үнийн тохируулгын үзүүлэлт;

**$A_c$**ба **$B_c$**– гэрээний үнийн "c" валютаар төлөгдөх хэсгийн тохируулга хийгдэхгүй болон хийгдэх хувийн жинг үзүүлсэн, гэрээний тусгай нөхцөлд заасан итгэлцүүр;[18]

**$Im_c$**– нэхэмжилж буй сарын эцсийн хоногт зонхилж буй "c" валютын индекс;

**$Io_c$**– тендерийг нээх өдрийн зонхилж буй "c" валютын индекс.

44.2. Хэрэв индексийн дүн нь түүнийг тооцоонд ашигласнаас хойш өөрчлөгдсөн бол тооцоог залруулж, дараагийн төлбөрийн мэдэгдэлд энэ дагуу тохируулга хийнэ. Индексийн дүнг тооцохдоо үнийн хэлбэлзлийн улмаас гарсан зардлын бүх өөрчлөлтийг энд харгалзсан гэж үзнэ.

**45. Барьцаа хөрөнгө**

45.1. Захиалагч нь гүйцэтгэгчид төлөх гүйцэтгэлийн төлбөр бүрээс гэрээний тусгай нөхцөлд заасан тодорхой хувийг суутгаж үлдээнэ.[19]

45.2. Ажил бүрэн дууссан тухай мэдэгдлийг үндэслэн суутгасан үнийн дүнгийн 50 хувийг гүйцэтгэгчид төлөх бөгөөд үлдсэн хэсгийг чанарын баталгаат хугацаа дууссаны дараа тэр хугацаанд гарсан бүх зөрчил, гологдлыг гүйцэтгэгч арилгасан тухай төслийн менежерийн мэдэгдлийг үндэслэн төлнө.

45.3. Ажлыг бүхэлд нь дуусгамагц гүйцэтгэгч захиалагчид банкны батлан даалт гаргаж өгснөөр уг батлан даалтад заасан дүнтэй тэнцүү хэмжээний төлбөрийг барьцаа хөрөнгөөс урьдчилж авч болно.

**46. Алданги**

46.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги[20] төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

46.2. Хэрэв алданги төлснөөс хойш ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгасан бол төслийн менежер гүйцэтгэгчийн илүү төлсөн алдангийг

[18] $A_c$ ба $B_c$ –гэсэн хоёр итгэлцүүрийн нийлбэр нь валют бүрийн томъёонд 1 (нэг) байна. Энэ хоёр итгэлцүүр нь ихэвчлэн ихэнх валютын хувьд ижил байдаг. Төлбөрийн тохируулга хийхгүй хэсэгт зориулсан A итгэлцүүр нь тогтмол үнийн болон бусад тохируулга үл хийгдэх элементүүдийг тусгасан ойролцоо үзүүлэлт (ихэвчлэн 0,15) юм. Валют бүрийн тохируулгын дүнг гэрээний үнэд нэмнэ.

[19] Барьцаа хөрөнгийн дүн 5 орчим хувь байх бөгөөд ямар ч тохиолдолд 10 хувиас хэтрэх ёсгүй.

[20] Алдангийг ихэвчлэн хоногт 0,05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

даraагийн төлбөрийн мэдэгдэлд тооцох замаар залруулна. Илүү төлсөн алдангид алдангийн төлбөр хийсэн өдрөөс алдангийг буцаан төлөгдсөн өдөр хүртэл хугацааны хүүг ТӨОЗ-ны 40.1-д заасан хувиар тооцож гүйцэтгэгчид төлнө.

**47. Урамшуулал**

47.1. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс өмнө дууссан хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр гүйцэтгэгчид урамшуулал[21] олгоно. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр болоогүй боловч гүйцэтгэгч ажлыг бүрэн дуусгасан бол төслийн менежер энэ тухай мэдэгдэл гаргана.

**48. Урьдчилгаа төлбөр**

48.1. [22]Захиалагч гэрээний тусгай нөхцөлд заасан дүнтэй урьдчилгаа төлбөрийг уг өгөгдөлд заасан хугацаанд гүйцэтгэгчид төлнө. Урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү, ижил валютаар илэрхийлэгдсэн банкны батлан даалт буюу үл маргах нөхцөлтэйгээр банкнаас гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн энэхүү төлбөрийг хийнэ. Гэхдээ энэ батлан даалтын дүн нь гүйцэтгэгчийн эргэж төлөгдсөн урьдчилгаа төлбөрийн хэмжээгээр буурч байна. Урьдчилгаа төлбөрт хүү ногдуулахгүй.

48.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг зөвхөн гэрээг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, байгууламж, материал болон ажил эхлүүлэхтэй холбогдсон зардалд зарцуулна. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг энэ зорилгод ашигласныг нотлохын тулд нэхэмжлэх болон бусад баримтын хувийг төслийн менежерт ирүүлнэ.

48.3. Урьдчилгаа төлбөр нь хийгдсэн үе шатны ажлын дагуу гүйцэтгэгчид төлөх төлбөрийн хэмжээнээс холбогдох дүнг суутгах замаар эргэж төлөгдөнө. Хийгдсэн ажлын үнэ, өөрчлөлт, үнийн тохируулга, нөхөн төлбөр, урамшуулал болон алдангийн дүнг тооцохдоо урьдчилгаа төлбөр, эсхүл түүний эргэж төлөгдсөн байдлыг харгалзахгүй.

**49. Баталгаа**

49.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанаас хоцроолгүй гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн хүлээн зөвшөөрөх дүн, маягт, банкаар гаргуулан, гэрээний үнийг төлөх валютаар илэрхийлэн захиалагчид ирүүлнэ. Гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй байх хугацаа дуусах өдөр нь ажил дууссан тухай мэдэгдэл гарсан өдрөөс хойш 28 дахь өдөр байна.

**50. Ажил-өдөр**

50.1. Зөвхөн төслийн менежерийн урьдчилан бичгээр гаргасан зааварчилгааны дагуу бага хэмжээний нэмэлт ажлын төлбөрийг тендерт дурдсан ажил-өдрийн нэгж үнийг ашиглаж тооцно.

50.2. Гүйцэтгэгч ажил-өдрөөр тооцогдон төлөгдөх бүх ажлын талаар төслийн менежерийн баталсан маягтын дагуу тэмдэглэл хөтөлнө. Бөглөсөн маягтыг төслийн менежер ажил гүйцэтгэснээс хойш 2 хоногийн дотор шалгаж батална.

50.3. Батлагдсан ажил-өдрийн маягтыг үндэслэн төлбөрийг гүйцэтгэгчид төлнө.

**51. Засварын зардал**

51.1. Ажил эхэлсэн өдрөөс чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл хугацаанд гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас, эсхүл дутуу орхисноос үүдэн гарсан гэрээний ажилтай холбоотой материал болон ажилд үүссэн алдагдал, эвдрэл гэмтлийг гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлана.

---

[21] Ажлыг төлөвлөсөн хугацаанаас өмнө дуусгах нь захиалагчид ашигтай бол энэ заалтыг үлдээх ба бусад нөхцөлд буюу ихэнх тохиолдолд хасна. Урамшууллын хэмжээ нь ихэвчлэн алдангийн хэмжээтэй ижил байна.

[22] Хэрэв урьдчилгаа төлбөр байхгүй, эсхүл урьдчилгаа төлбөр байгаа нөхцөлд урьдчилгаа төлбөр хийхийн тулд урьдчилгаа төлбөрийн банкны батлан даалт авах шаардлагагүй гэж үзвэл захиалагч эхний 2 өгүүлбэрийг хасаж болно.

## Д. ГЭРЭЭГ ДУУСГАХ

**52. Ажил дуусгах**

52.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

**53. Хүлээж авах**

53.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш долоо хоногийн дотор захиалагч ажлын талбай болон ажлыг хүлээж авах ажлыг зохион байгуулна..

**54. Эцсийн тооцоо**

54.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаар тайлбарыг 28 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**55. Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага**

55.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

55.2. Хэрэв гүйцэтгэгч 55.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

**56. Гэрээг цуцлах**

56.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

56.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад шалтгаанаар татан буугдсан;

(г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 60 хоногийн дотор төлөөгүй;

(д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(е) гүйцэтгэгч захиалагчийн шаардсан баталгааг хангаагүй;

(ё) гүйцэтгэгчажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

56.3. Хэрэв гэрээний аль нэг тал дээрх 56.2-т заасанаас өөр үндэслэлээр гэрээг ноцтой зөрчсөн тухай мэдэгдлийг төслийн менежерт өгсөн бол төслийн менежер тухайн үндэслэл нь ноцтой зөрчил мөн эсэхийг шийдвэрлэнэ.

56.4. Захиалагч шаардлагатай тохиолдолд дээр дурдсаныг үл харгалзан гэрээг цуцлах эрхтэй.[23]

56.5. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**57. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

57.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөр болон дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.

57.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл гаргасан өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөрийг эдгээр зардлаас хасна.

**58. Өмч**

58.1. Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалж гэрээ цуцлагдсан бол ажлын талбай дээрх захиалагчаас үнийг нь төлсөн бүх материал, байгууламж, тоног төхөөрөмж, туслах ажил болон ажлыг захиалагчийн өмч гэж үзнэ.

**59. Гүйцэтгэлээс чөлөөлөх**

59.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

[23] Захиалагч гэрээг цуцлах шийдвэрийг холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрөлтэйгээр зөвхөн зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргана.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

**Гэрээний тусгай нөхцөлийг бөглөх санамж**

Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн тодорхойлж гаргасан байна. Захиалагч холбогдох хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно:

**55.0** Ашиглалт, засвар үйлчилгээний хуваарь

**8.0** Бусад гүйцэтгэгчдийн хуваарь

**9.0** Голлох мэргэжилтний хуваарь

**14.0** Ажлын талбайн судалгааны тайлан

**1.1** Захиалагч: ***[Захиалагчийн нэр, хаяг]***

**1.1** Төслийн менежер: ***[томилогдсон этгээдийн нэр, хаяг]***

**1.1** Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар нь ***[Тендерийн (шаардлагатай бол урьдчилсан сонголтын) урилгад заасан нэр болон дугаар]***

**1.1** Ажил нь ***[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]***-аас бүрдэнэ.

**1.1** Ажил эхлэх өдөр ***[огноо]***

**1.1** Ажлын талбай нь ***[байршил]***-д байрших ба зураг №…-д зааснаар тодорхойлогдсон болно.

**3.0** Гэрээний баримт бичгүүд нь ***Мог***хэл дээр байна.

**3.0** Гэрээнд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.

**13.0** Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь:

(а) Ажил, байгууламж болон материалын даатгалд зориулж захиалагчийн суутгах дээд хэмжээ нь ***[мөнгөн дүн]*** байна.

(б) Гүйцэтгэгчийн алдаатай зураг төсөлтэй холбогдох ажил, байгууламж болон материалын даатгалд гүйцэтгэгчийн төлөх доод хэмжээ нь ***[мөнгөн дүн]*** байна.

(в) Тоног төхөөрөмжийн даатгалд зориулж захиалагчийн суутгах дээд хэмжээ нь ***[мөнгөн дүн]*** байна.

(г) Тоног төхөөрөмжийн алдагдал, эсхүл гэмтлийн даатгалд гүйцэтгэгчийн төлөх доод хэмжээ нь *[мөнгөн дүн]* байна.

(д) Бусад эд хөрөнгийн даатгалд зориулж захиалагчийн суутгах дээд хэмжээ нь ***[мөнгөн дүн]*** байна.

(е) Бусад эд хөрөнгийн даатгалд гүйцэтгэгчийн төлөх доод хэмжээ нь ***[мөнгөн дүн]*** байна.

(ж) Гэнэтийн ослын буюу амь насны даатгалд гүйцэтгэгчийн төлөх доод дүн нь:

(1) гүйцэтгэгчийн ажилчдад ***[мөнгөн дүн]*** байна.

(2) бусад хүмүүст ***[мөнгөн дүн]*** байна.

**17, 26** Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ***[огноо]***[24]

**21.0** Ажлын талбайг ашиглуулж эхлэх өдөр ***[огноо]***[25]

**25.0** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ***[тоо]***хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.

**25.0** Ажлын хөтөлбөрийг ***[тоо]***хоног тутам тодотгоно.

**25.0** Тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд суутгах үнийн дүн нь ***[мөнгөн дүн]*** байна.

**32.0** Чанарын баталгаат хугацаа ***[тоо]***[26]хоног байна.

**40.0** Төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш ***[тоо]***[27] хоног байна.

**41.0** Дараах тохиолдол нь мөн нөхөн төлбөр хийх нөхцөлд тооцогдоно: ***[тохиолдлуудыг жагсаана]***

**44.0** Гэрээний ерөнхий нөхцөлийн 44 дүгээр зүйлийн дагуу гэрээнд үнийн тохируулга хийж ***[“болно”, эсхүл “болохгүй” гэж бичнэ]***. Итгэлцүүртэй холбоотой дор дурдсан мэдээллийг ***[“хэрэглэнэ”, эсхүл “хэрэглэхгүй” гэж бичнэ]***:

**44.0** Үнийг тохируулах итгэлцүүр нь:

(а) ***[валютын нэр]***-ийн хувьд:

(1) тохируулга хийгдэхгүй хувийн жин нь ***[хувь]*** байна. (итгэлцүүр А)

(2) тохируулга хийгдэх хувийн жин нь ***[хувь]*** байна. (итгэлцүүр В)

(б) ***[валютын нэр]***-ийн хувьд:

(1) тохируулга хийгдэхгүй хувийн жин нь ***[хувь]*** байна. (итгэлцүүр А)

(2) тохируулга хийгдэх хувийн жин нь ***[хувь]*** байна. (итгэлцүүр В)

**44.0** Дотоод валютын[28] индекс нь ***[индексийг заах]*** байна.

**44.0** Заасан гадаад валютын[29] индекс нь ***[индексийг заах]*** байна.

**44.0** Дотоод болон гадаад валютаас бусад[30] валютын индекс нь ***[индексийг заах]*** байна.

**45.0** Барьцаа хөрөнгийн хувь нь ***[хувь]*** байна.

**46.0** Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн ***[хувь]*** байна.[31]

---

24 Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.
25 Ажлын талбайг хэсэгчлэн эзэмшүүлэх бол эдгээр хугацааг жагсаана.
26 Энэ хугацааг ихэвчлэн Иргэний хуульд нийцүүлж авна.
27 Энэ хугацаа 3 сараас илүүгүй байна.
28 Эдгээр индексийг захиалагч тодорхойлно.
29 Эдгээр индексийг гүйцэтгэгч санал болгох ба захиалагч хүлээн зөвшөөрсөн байна.
30 Эдгээр индексийг гүйцэтгэгч санал болгох ба захиалагч хүлээн зөвшөөрсөн байна.
31 Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

**46.0** Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн ***[хувь]*** байна.

**47.0** Урамшуулал олгох хэмжээ нь хоногт гэрээний үнийн ***[хувь]***байна.[32]

**47.0** Нийт ажилд олгох урамшууллын дээд хэмжээ нь гэрээний үнийн***[хувь]***байна.

**48.0** Урьдчилгаа төлбөрийн дүн нь ***[мөнгөн дүн]*** байх ба гүйцэтгэгчид ***[огноо]***-оос өмнө төлнө.

**49.0** Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үнийн ***[хувь]***–тай тэнцүү дүнтэй байна.

Гүйцэтгэлийн баталгаа нь тендерийн баримт бичгийн 7дугаар бүлэгт заасан маягтын дагуу байна.

**55.0** Гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг турших тохируулсан актыг ***[огноо]***-ны дотор гаргаж өгнө. Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг ***[огноо]***-ны дотор гаргаж өгнө.

**55.0** Дээрх материалыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ ***[мөнгөн дүн]*** байна.

**57.0** Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын ***[хувь]***-иартооцно.

---

32 Шаардлагагүй бол “0” гэж бичнэ. Ажлыг хэсэгчлэн дуусгах болон хэсэг бүрийн урамшууллыг зөвшөөрсөн бол энд тусгана.

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ:**

*ХӨВСГӨЛ АЙМГИЙН*
*ЗАСАГ ДАРГА*

_____________*Л.ГАНБОЛД*
(Гарын үсэг)

**ГҮЙЦЭТГЭГЧ:**

*“,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,” ХХК-ИЙН*
*ЗАХИРАЛ*

____________,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,
(Гарын үсэг)

***,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,, АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ***

Дугаар № *ХӨАОНӨГ2020,,,,,,/...............-А/01*

Хөвсгөл аймаг

**НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Нэг талаас ***Хөвсгөл аймгийн Засаг дарга*** **.............**(цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ,,,,, оны ,,,, дугаар сарын ,,,,,,-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль ,Барилгын тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь**,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,, *ХӨ-201../...............-А/…***-г (цаашид “ажил” гэх) ***,,,,,,,,,,,,,,,,,,,(,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,)***төгрөгөөр(цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн:**,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,** төгрөг. Үүнээс :

Үүнээс: Улсын төсвийн хөрөнгө оруулалт
201... онд:**,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,**төгрөг;
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
201.. онд: **,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,**төгрөг;

4. Гүйцэтгэгч нь **,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,** байршилтай **,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,, ажлыг** 201.. оны ,,,, дугаар сарын ,,,-ны өдөр эхэлж, 201.. оны ,,,, дүгээр сарын ,,,,,-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Тендер;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт;
Зураг;

Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь[33]:

Санхүүжилтийн хуваарь;

Ажил гүйцэтгэх хуваарь.

Бусад шаардлагатай баримт бичиг[34];

Гүйцэтгэлийн баталгаа: ,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,, дугаартай гүйцэтгэлийн баталгаа, ,,,,,,,,,,,,,,,,,,,,,,, (,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,) төгрөг.

1.5. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.6. Захиалагч талууд нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ харилцан хүндэтгэлтэйгээр асуудалд хандаж, хэн нэг нь давуу эрх эдлэхгүйгээр хамтын шийдвэр гаргаж ажиллана.

1.7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, хариуцлагыг хүлээнэ.

1.8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

1.9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

1.10. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл бий болсноос бусад тохиолдолд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг сунгаж өөрчлөхийг хориглоно.

1.11. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

1.12.Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэ, ажлын тоо хэмжээнээс бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.

1.13. Гүйцэтгэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Зураг төсөв, инженер геологи, эксперт үнэ: ,,,,,,,,,,,,,, /,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,/ төгрөг
- Захиалагчийн хяналтын зардал: ,,,,,,,,,,,,,, /,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,/ төгрөг
- Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал: ,,,,,,,,,,,,,, /,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,/ төгрөг
- Магадлашгүй ажил: ,,,,,,,,,,,,,, /,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,/ төгрөг
- Барилга байгууламжийн норм, нормативын сан ..,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,,, төгрөг

Зураг төсөвт тусгагдаагүй болзошгүй ажлын зардлыг магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлж болно.

### ХОЁР: ЗАХИАЛАГЧ (ТӨСЛИЙН БАГИЙН) БОЛОН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1 Захиалагч нь “Барилгын тухай” хуулийн 37 дугаар зүйл болон Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолд тус тус заасан чиг үүргийг заавал хэрэгжүүлнэ.

2.2 Төслийн менежер нь гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчнийг, эсхүл төслийн багаас зөвшөөрсөн бусад ажиллах хүчнийг ажиллуулна. Голлох мэргэжилтнийг өөрчлөх тухай гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг зөвхөн санал болгож буй орлох мэргэжилтний чадвар нь дээрх хуваарьт заасан шаардлагын түвшинд, эсхүл түүнээс өндөр түвшинд байх нөхцөлд төслийн баг зөвшөөрч батлана.

2.3 Төслийн менежер нь барилгын үе шатны ажилд хяналт хэрэгжүүлэх гэрээг зохиогч, төслийн багийн гишүүд, эсхүл зөвлөх багтай “Барилгын тухай” хуулийн 33.1.20-д заасан гэрээний загвараар гэрээ байгуулах, дүгнэх барилга угсралтын ажлын бүх үе шатанд ажлын журнал хөтлөн ажил бүр дээр чанар болон технологийн хяналтыг хийх, үе шатны ажил эхлэхийн өмнө барилгын ажилд хэрэглэх материал, бүтээц хийцийн тохиролын гэрчилгээг шалгаж, чанар байдлыг тодорхойлон угсралтын ажилд ашиглах, эсэхийг шийдвэрлэх, үе шатны ажил дуусах бүрт тухайн үе шатны ажлыг шалган баталгаажуулах, баримт бичиг бүрдүүлэх, ажлын тоо хэмжээ болон санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан мэдээг захиалагчид хүргүүлэх,

---

[33] Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино.

[34] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, захиалагчийг үнэн зөв мэдээллээр хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.4. Барилга байгууламжийн үндсэн ажилд хэрэглэсэн материал, бүтээцийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораторид нууцалсан дугаар бүхий дээж өгч тодорхойлуулах, материалын гарал үүсэл, тохиролын гэрчилгээг хянах замаар үнэлэлт дүгнэлт гаргах, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, барилгын ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн актуудыг баталгаажуулах:

2.5 Барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох зардлыг хариуцах,

2.6 Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохиролыг хариуцах

2.7. Барилгын ажилд зураг төсөлд зааснаас өөр материалыг хэрэглэх тохиолдолд захиалагчийн болон зураг төсөл боловсруулсан зохиогчоос зөвшөөрлийг авч, зохих журмаар шинжилгээ, туршилт хийлгэж чанар, стандартын албан ёсны баталгаажилт хийлгэсний үндсэн дээр бүтээцийг өөрчлөхгүйгээр шийдвэрлэх:

2.8. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг батлагдсан зураг төсөл, норм, дүрэм техникийн нөхцөлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн зардлаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх, гэрээг цуцлах эрхийг захиалагчийн томилсон төслийн менежер хэрэгжүүлнэ

2.9 Мэргэжлийн хяналтын болон эрх бүхий байгууллагаас хийсэн үзлэг, шалгалтын дүн, техникийн дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулах

2.10 Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг дүгнэх, барилга, байгууламж, ажил үйлчилгээг ашиглалтад хүлээн авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах.

2.11. Чанарын баталгааны хугацаанд тухайн бараа, ажил, үйлчилгээнд зөрчил, гологдол, эвдрэл гараагүй болон зөрчил гологдлыг арилгасан тухай захиалагчийн томилсон ажлын хэсгийн акт, захиалагчийн мэдэгдлийг үндэслэн барьцаа хөрөнгийг чөлөөлж, гүйцэтгэгчид олгох.

2.12. Төслийн менежер нь ажил худалдан авах гэрээний хэрэгжилтийн явцын талаарх дараах мэдээллийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт улирал бүрийн дараа сарын 1-ний өдөрт багтаан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

- гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчний мэдээлэл
- Ажил худалдан авах гэрээний хэрэгжилтийн явц, үр дүн, гэрээ дүгнэсэн акт
- Ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, үе шатны ажлын гүйцэтгэл
- Барилгад ашигласан материал, хийц, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, дүгнэлт, гарал үүслийн гэрчилгээ
- Барилгын талбайд ажиллаж байгаа инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдын судалгаа
- Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт,
- Барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл
- Захиалагчийн барилга техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт
- Тоног төхөөрөмж угсарсан актууд, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, туршилт тохируулгын акт
- Санхүүжилтийн талаарх мэдээлэл
- Бусад шаардлагатай мэдээлэл

2.13 Захиалагчийн санхүүжилтээр олгогдсон хөрөнгийг өөр зориулалтаар ашиглах, барилга угсралтын ажлын зураг төсвийг захиалагчийн болон зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөн гүйцэтгэх, гэрээний нөхцөл, төсөв, норм дүрмийг зөрчиж ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэх, гарал үүсэл, тохиролын гэрчилгээгүй материал, хийц бүтээцийг ашигласан, мэргэжлийн байгууллагуудын зүгээс тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч санхүүжилтийг зогсоох, гүйцэтгэгчээс татгалзах, гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах хүртэлх арга хэмжээг авч, учирсан хохирлыг төлүүлэх эрх эдэлнэ.

2.14 Төслийн баг нь барилгын ажил дууссны дараа ашиглагч, гүйцэтгэгч, зохиогч, зөвлөхийг тус тус оролцуулан тухайн барилга байгууламжид үзлэг шалгалт хийж, захиалагчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гарган, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлтийн хамт аймгийн орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

## ГУРАВ: ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Гүйцэтгэгч нь “Барилгын тухай” хуулийн 40 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, барилгын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажил эхлэх зөвшөөрөл авах, барилгын ажлын талбайд гал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны горимыг мөрдөх, хөдөлмөр хамгааллын дэглэмийг сахиулах, гуравдагч этгээдийг барилгын ажлаас шалтгаалсан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, байгаль орчин, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2 Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчнийг, эсхүл төслийн багаас зөвшөөрсөн бусад ажиллах хүчнийг ажиллуулна. Голлох мэргэжилтний хуваарьт заасан ажиллаххүчнийг өөрчлөх тухай хүсэлтийг төслийн багт гаргаж шийдвэрлүүлнэ.

3.3 Барилгын ажлыг магадлал хийгдсэн, баталгаажсан зураг төсөл, норм нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих, ил далд ажлын акт, үе шатны ажлын тэмдэглэл, үе шатны ажлыг гэрээнд заасан хугацаанд багтаан гүйцэтгэж, гүйцэтгэлийг захиалагчаар батлуулах, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, ажлын явцад илэрсэн гологдол, зөрчлийг тухай бүрт нь арилгаж, буруу, дутуу хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр нөхөн гүйцэтгэх зэрэг чиг үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.

3.4 Далд ажлын акт үйлдэн фото зураг /ажил эхлэхээс өмнө, ажил гүйцэтгэх явц, ажил дууссаны дараах байдлаар харьцуулсан/ болон гүйцэтгэлийн схем зургаар баталгаажуулж гүйцэтгэлд хавсаргах, давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн аюуллаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

3.5 Ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх ажлын хөтөлбөр, гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай баталгааг гаргаж захиалагчид ирүүлэх

3.6 Гүйцэтгэгч нь Засгийн газрын 2018 оны …... дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу барилгын ажлыг улсын комисст хүлээлгэн өгөх бэтгэл ажлыг хангах, гэрээг захиалагчтай хамтран дүгнэх үүрэгтэй

3.7 Үе шатны ажлын хуваарьт заасан үйл ажиллагааны гүйцэтгэлд нийцсэн санхүүжилтийн хуваарийг гаргаж захиалагчаар баталуулна.

3.8 Барилгын ажилд олон улсын болон үндэсний стандартын шаардлага хангасан, гарал үүсэл, тохирлын гэрчилгээтэй, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, үйлдвэрлэгчийн баталгаа бүхий барилгын материалыг захиалагчтай зөвшилцөн ашиглах, суурилуулах

3.9 Барилгын үйл ажиллагаанд оролцогчдын төлөөллийг барилгын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх, барилгын зураг төсөл, баримт бичигтэй чөлөөтэй танилцах боломж олгох,

3.10 Барилга байгууламжийн ашиглалтын зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл эс үйлдхүүн улмаас үүсэн хохиролыг хариуцах, ажлын талбайд хариуцан хүлээн авсан бүх эд хөрөнгийн бүрэн хариуцлагыг хүлээх

3.11 Барилга байгууламж барих, шинэчлэх засварлахдаа, зам, гудамж, талбай сэтэлж эвдэлсэн, мод, цэцэрлэгжүүлэлтийг зайлуулсан бол тэдгээрийг нөхөн сэргээх

3.12 Барилгын ажилд ашигласан барилгын материал, тоног төхөөрөмж зураг төсөлд заасан техникийн үзүүлэлтийг хангаж байгааг захиалагчийн барилга техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт, гарал үүсэл, тохиролын гэрчилгээ”-г үе шатны ажил эхлэхээс /уг материалыг хэрэглэхээс/ өмнө захиалагчаар хянуулан зөвшөөрөл авсны үндсэн дээр дараагийн үе шатны ажилд ашиглана.

3.13 Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгааны барьцаа хөрөнгийг Төрийн сан банкны 100170051305 тоот дансанд уг баталгааны хугацааг дуустал байршуулна. Барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан өдрөөс эхлэн чанарын баталгааны хугацааг тооцно.

3.14. Гүйцэтгэгч компаний товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний нэр, гэрээний үнийн дүн санхүүжилтийн хуваарь, ажил, эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурийн болон тухайн объектийн байрлах газарт олон нийтэд үзэгдэхүйцээр уг ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацааны туршид заавал байршуулна.

3.15 Барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрт лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан захиалагчаар батлуулах,

3.16 Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгч, түншлэгч ажиллуулахаар тендертээ ирүүлж, тэднээр барилгын ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд түншлэгч, туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүн, эрсдлийг захиалагчийн өмнө хариуцах ба тендертээ туслан гүйцэтгэгч, түншлэгч ажиллуулахаар санал ирүүлээгүй тохиолдолд түншлэгч, туслан гүйцэтгэгч ажиллуулахыг хориглоно.

3.17 Далд ажлын акт үйлдэн фото зураг /ажил эхлэхээс өмнө, ажил гүйцэтгэх явц, ажил дууссаны дараах байдлаар харьцуулсан/ болон гүйцэтгэлийн схем зургаар баталгаажуулж гүйцэтгэлд хавсаргах үүрэгтэй.

3.18 Барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн тохиолдолд гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж захиалагч, зохиогчоор батлуулах

3.19 Гүйцэтгэгч нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд ажлын байргүй, бага орлоготой өрх иргэнээс тодорхой хэсгийг ажлын байртай болгохыг эрмэлзэж, ажлын байртай болгосон иргэдийн судалгаа, тэндэнд олгосон цалин хөлсний мэдээллийг захиалагчид ирүүлнэ..

3.20 Барилга, байгууламж, ажил, үйлчилгээг ашиглалтанд хүлээн авах, болон туршилт тохируулга хийсэн тухай акт зэрэг баримт бичиг албан ёсоор баталгаажаагүй, барилга байгууламжийн ашиглалтад хүлээн авах тухай шийдвэргараагүй байх хугацаан дахь тухайн барилга, байгууламжийн ашиглалт үйлчилгээтэй холбоотой урсгал зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

## ДӨРӨВ: АЖИЛ, МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ ХИЙЦИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| № | материалын нэр, марк | Хэмжих нэгж | тоо ширхэг | Нэгж үнэ /мян.төг/ | Нийт үнэ /мян.төг/ | үйлдвэрлэсэн улс | техникийн тодорхойлолт, холбогдох стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |

## ТАВ: АЖЛЫН ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ

Ажлын үе шатны хуваарийн доорх хүснэгтээр гаргав.

| д/д | Гүйцэтгэх ажлын нэр төрөл | Хэмжих нэгж | тоо | Төсөвт өртөг /мян.төг/ | сар | .... сар | | | .... оны .... сар | | | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 10 хоног | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | |
| 1 | | | | | Төл | Мөнгөн дүнгээр | | | | Мөнгөн дүнгээр | | |
| | | | | | Гүйц | | | | | | | |
| 2 | | | | | Төл | Мөнгөн дүнгээр | | | | Мөнгөн дүнгээр | | |
| | | | | | Гүйц | | | | | | | |
| 3 | | | | | Төл | Мөнгөн дүнгээр | | | | Мөнгөн дүнгээр | | |
| | | | | | Гүйц | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

Санхүүжилтын хуваарийг доорх хүснэгтээр гаргав.

| Д/Д | Барилга байгууламжын нэр | Төсөвт өртөг | 2019 онд санхүүжих | 2020 онд санхүүжих |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |

## ЗУРГАА: БАРИЛГЫН АЖИЛД АШИГЛАХ МОНГОЛ УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ГАРАЛ ҮҮСЭЛТЭЙ БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ ХИЙЦИЙН ЖАГСААЛТ

| № | Бараа, материал, бүтээц хийцийн нэр, марк | Хэмжих нэгж | Тоо | Нийт үнэ /мян төг/ | Үйлдвэрлэгч нийлүүлэгчийн нэр |
|---|---|---|---|---|---|

## ДОЛОО: АЖИЛ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно:

**55.0** Ашиглалт, засвар үйлчилгээний хуваарь

**10.0** Бусад гүйцэтгэгчдийн хуваарь

**11.0** Голлох мэргэжилтний хуваарь

**15.0** Ажлын талбайн судалгааны тайлан

ГЕН 2.0: Хөвсгөл аймгийн Засаг дарга, „„„„„„„„ ажил, ХӨ-2020/„„„„„„„„„-А/01

ГЕН 2.1: Ажил нь дараах иж бүрдлээс бүрдэнэ: Ажил нь захиалагчийн ажлын даалгавар, техникийн тодорхойлол, зураг төсөв, гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерээс бүрдэнэ.

ГЕН 3.0: Гэрээний хэл: Монгол хэл байна.

ГЕН 4.0: Төслийн менежер: Хөвсгөл аймгийн Засаг даргын 2020 оны А/„„„ тоот захирамжаар томилсон төслийн менежерийн багийг төлөөлж, аймгийн „„„„„„„„„„„„„„„„„„„„„ ажилтай „„„„„„„„„.

ГЕН 9.1: Гүйцэтгэгчийн тендерт санал болгосон голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчний танилцуулга, мэдээлэл: /Ажилтны нэр, мэргэжил, албан тушаал, хариуцах ажил, гүйцэтгэх үүрэг гэсэн мэдээллээр гаргасан байна./

ГЕН 17.1: Ажил эхлэх, дуусах хугацаа: Ажил 2020 оны „„ дугаар сарын „„„-ны дотор эхэлж, 2018 оны „„„ дүгээр сарын „„„-ны өдрийн дотор ашиглалтанд орсон байна.

ГЕН 18.1 Гүйцэтгэгч туслах ажлын зураг техникийн тодорхойлолт, зургыг гарган төслийн менежерт ирүүлэх ба гэрэний ерөнхий нөхцлийн 18-д зааснаар туслах ажлын техникийн тодорхойлолт, зураг төслийг батлах ба шаардлагатай бол гүйцэтгэгч зураг, төсөлд холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан байна.
ГЕН 25.1: Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дараа гэрээ байгуулах өдрөөс өмнө төслийн менежерт хүргүүлж батлуулсан байна.
ГЕН 25.2: Захиалагчийн томилсон төслийн баг ажлын үе шатны хяналтыг хийж, төслийн менежер, аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөлөл, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас төслийн багт томилогдсон хяналтын инженер, гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл, зураг төсөл зохиогч, аймгийн онцгой байдлын газрын холбогдох улсын байцаагч зэрэг албан тушаалтнууд ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, барилгын ажилд хэрэглэсэн барилгын материалын техникийн тодорхойлолт, ажлын гүйцэтгэл зэрэг баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулна.

ГЕН 32.1: Чанарын баталгааны хугацаа: Ажлыг ашиглалтанд хүлээн авсан өдрөөс хойш барилга байгууламжийн зүгшрүүлэх тохируулах хугацаа 1 жил байна. Гүйцэтгэгч зөрчил гологдлыг арилгаагүй нөхцөлд, зөрчил гологдол арилгаж дуусах хүртэл хугацаагаар чанарын баталгааны хугацааг захиалагч сунгана.

ГЕН 32.2: Барилга байгууламжийн гадна дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц бүтээц, бохир ус, уур хий, дулаан цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын 3 жилийн хугацаанд дээрх барилга байгууламж, засал, материал, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг гүйцэтгэгч хариуцан засварлана.

ГЕН 32.3: Улс, Орон нутгийн төсөв, Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих барилга байгууламжинд барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д заасан гүйцэтгэгчээс хүлээх үүргийн

биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацааг дуустал захиалагч барьцаална.

ГЕН 34.1: Гүйцэтгэгч нь үе шатны ажлын тодотгосон хуваарь, ажил гүйцэтгэх аргачлал, талбайн зохион байгуулалтын зургыг гэрээ байгуулж, баталгаажуулах өдрөөс өмнө Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан журмын хавсралт маягтын дагуу боловсруулж төслийн менежерт ирүүлж, төслийн менежерийн саналыг тусган сайжруулах үүрэг хүлээх бөгөөд үе шатны ажлын хуваарьт тусгасан үйл ажилллагаа нь ажлын хөтөлбөрт тусгасан үйл ажиллагаатай нийцсэн байна.
ГЕН 39.1:Гэрээний төлбөрийг Сангийн сайдын 2019 оны 282 дүгээр тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын дагуу гүйцэтгэлээр санхүүжүүлэх бөгөөд ажлын гүйцэтгэл 60 доошгүй хувийн биелэлттэй тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 30 хүртэл хувьтай тэнцэх санхүүжилтийг, ажил бүрэн дуусаж, барилга байгууламжийг улсын комисс хүлээн авсны дараа гэрээний үлдэгдэл төлбөр болох 0-аас доошгүй хувийн санхүүжилтийг тус тус олгоно.

ГЕН 40.1: Гүйцэтгэгч гэрээний эцсийн гүйцэтгэлийн тооцоог төслийн менежерт ирүүлж, батлуулан холбогдох баримт бичгийг захиалагчид ирүүлснээс хойш 30 хоногийн дотор захиалагч гэрээний төлбөрийг төлөх бөгөөд хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хоцруулсан төлбөрт 0,1 хувийн торгуулийг дараагийн төлбөртэй хамт төлөх буюу торгуулийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.

ГЕН 45.1: Захиалагч гүйцэтгэгчид төлөх гүйцэтгэлийн эцсийн санхүүжилтээс гэрээний үнийн 5-10 хувьтай тэнцэх хэсгийг чанарын баталгааны барьцаа хөрөнгө болгон захиалагчийн дансанд суутгаж үлдээнэ. Чанарын баталгааны хугацаанд гарсан бүх зөрчил, гологдлыг гүйцэтгэгч арилгасан тухай болон гологдол зөрчил гараагүй тухай мэдэгдлийг үндэслэн чанарын баталгааны барьцаа хөрөнгийг гүйцэтгэгчид олгоно.
ГЕН 45.3: Магадлашгүй ажлын зардлыг зарцуулах шийдвэрийг захиалагчаас томилсон төслийн баг гаргаж, магадлашгүй ажлын зардлаар гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, зураг төсөл боловсруулах үйл ажиллагааг тухайн барилга байгууламжийн зураг төслийг анх боловсруулсан зөвлөх эсхүл мэргэжлийн зөвлөхөөр барилгын зураг төслийн норм, дүрмийн дагуу тодорхойлуулж төслийн менежер батлана. Магадлашгүй ажлын гүйцэтгэл, актыг захиалагчаас тогтоосон албан тушаалтнууд баталгаажуулж санхүүжилтийг олгоно.

ГЕН 46.1: Гүйцэтгэгч ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй.

ГЕН 49: Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанаас хоцроолгүй гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн хүлээн зөвшөөрөх дүн, маягт, банкаар гаргуулан, гэрээний үнийг төлөх валютаар илэрхийлэн захиалагчид ирүүлнэ. Гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй байх хугацаа дуусах өдөр нь ажил дууссан тухай мэдэгдэл гарсан өдрөөс хойш 28 дахь өдөр байна. Гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн, зохих ёсоор биелүүлээгүй, гэрээний хугацааг хэтрүүлсэн эсхүл гүйцэтгэгч гэрээнээс татгалзсан тохиолдолд захиалагч гэрээг цуцлах шийдвэр гаргаж гүйцэтгэгчийн гаргасан гүйцэтгэлийн баталгааг Иргэний тухай хуулийн 234 дүгээр зүйлийн 234.4 зааснаар уг баталгааг байршуулсан банк захиалагчийн шийдвэрийн дагуу гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн өмчлөлд шилжүүлнэ. Гүйцэтгэгч гэрээний үүргээ чанартай хэрэгжүүлсэн тохиолдолд үүрэг гүйцэтгэгчид гүйцэтгэлийн баталгааг чөлөөлж олгоно. Энэхүү гэрээний тусгай нөхцөл нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээг бичгээр байгуулсантай адил үйлчилнэ.

ГЕН 52.1: Гүйцэтгэгч ажлын явцад зам, талбай, гудамж сэтэлж, мод , цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол барилга ашиглалтанд хүлээн авахаас өмнө тэдгээрийг сэргээсэн байна. Нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд барилга ашиглалтанд хүлээн авахыг хориглоно.

ГЕН 55.1: Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагчийн шаардсан ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага, барилгын ажлын гүйэтгэлийн архив, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.9-д заасан мэдээллийн самбар зэргийг 2020 оны „„„ дугаар сарын „„„„„-ны өдрөөс өмнө захиалагчид хүлээлгэн өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй тохиолдолд гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрөөс гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх мөнгийг захиалагчийн дансанд суутган үлдээнэ.

**НАЙМ: ХАРИУЦЛАГА**

8.1. Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.
8.2. Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
8.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.
8.4 Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл гаргасан өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөрийг эдгээр зардлаас хасна.
8.5 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгчээс гаргасан "гүйцэтгэлийн баталгаа"-г захиалагчийн өмчлөлд "үл маргах журам"-аар шилжүүлнэ.
8.6 Төсвийн орлогын бүрдэлтээс шалтгаалсан төлбөрийн саатлыг санхүүжүүлэгч хариуцахгүй.
8.7 Барилгын тухай хуулийн холбогдох заалт болон энэ гэрээг зөрчсөн тал барилгын тухай хуулийн 50, Иргэний хуулийн 352, 353, 354, 355 дугаар зүйлүүдэд заасан үүрэг хариуцлагыг хүлээнэ.
8.8. Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ЕС: ГЭРЭЭГ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ.**

Гэрээг дор дурьдсан үндэслэлээр цуцална. Үүнд:

9.1 Захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээг сунгах болоцоогүй болсон эсхүл ажлын үе шатны хуваарьт заасан ажил хийгдээгүй, чанаргүй гүйцэтгэл гарсан, барилгын ажилын гүйцэтгэлийг хийхдээ мэргэжлийн алдаа гаргасан захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтыг хангахааргүй материалыг ашигласан зэрэг нь эрх бүхий албан тушаалтны дүгнэлтээр тогтоогдсон
9.2 Гүйцэтгэгч гэрээний үүрэг, захиалагчийн болон эрх бүхий хяналт шалгалтын байгууллагын дүгнэлт албан шаардлагыг биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн, эсхүл захиалагчаас хүлээн авсан ажлын талбай, барилга байгууламжийг учирч болох эрсдлээс хамгаалах, зүй зохистой ашиглах арга хэмжээ аваагүй, гэрээний үүргээсээ өөрөө татгалзсан зэрэг тохиолдолдлууд,

**ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

10.1. Гэрээг 5 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

10.2 Энэхүү гэрээний нөхцөлд гэрээний үнэ өөрчлөхөөс бусад асуудлаар нэмэлт гэрээ байгуулж болох бөгөөд уг нэмэлт гэрээ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

**АРАВ: ГЭРЭЭ ДҮГНЭХ**

11.1 Захиалагчийн төслийн баг болон гүйцэтгэгч байгууллага хамтран ажил гүйцэтгэх гэрээг дүгнэнэ.
11.2 Барилга угсралтын ажлын үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг тухайн үе шатанд хийгдсэн ажлын гүйцэтгэл, гэрээний бусад нөхцлийг үндэслэн дүгнэнэ.

10.3 Барилгын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан тохиолдолд төслийн баг, гүйцэтгэгч, ашиглагч, зохиогч хамтран уг барилга багууламжид үзлэг шалгалт хийн техник хяналтын нэгдсэн дүгнэлт, байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс ажиллуулах тухай хүсэлт зэргийг аймгийн засаг даргад ирүүлэх ба аймгийн засаг дарга барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс томилсон шийдвэр гаргана.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ[35]

[35] Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

**Гэрээний жишиг маягтыг бөглөх санамж**

Алдаа залруулах (тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 31дүгээрзүйл), үнэлгээний үед үнийн тохируулга хийх (тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 17.9; гэрээний ерөнхий нөхцөлийн 44 дүгээр зүйл), хувилбарт тендер сонгох (тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 16.1), материаллаг бус зөрүүг (тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 30 дугаар зүйл) хүлээн зөвшөөрсний улмаас тендерт хийсэн аливаа залруулга, нэмэлт өөрчлөлт болон голлох мэргэжилтэн, туслан гүйцэтгэгч, хуваарийн өөрчлөлт гэх мэт харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг болно.

**Баталгааны маягтыг бэлтгэх санамж**

Гэрээний маягт болон тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааны зөвшөөрөгдөх маягтуудыг хавсаргав. Тендерт оролцогчид тендерийн хамт тендерийн баталгааг энэ бүлэгт заасан маягтаар ирүүлнэ.

Харин гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг шалгарсан тендерт оролцогч энэ бүлэгт заасан маягтаар ирүүлнэ. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэх шаардлагагүй бол урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтыг тендерийн баримт бичигт хавсаргахгүй.

Тендерт оролцогчийн ирүүлэх тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа нь энэ бүлэгт заасан маягтын дагуу байх ба агуулгын хувьд өөрчлөлт ороогүй боловч өөр хэлбэр /формат/-тэй ирүүлсэн баталгааг захиалагч зөвшөөрнө.

**МАЯГТ № ГМ-2**

**ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ**
**(БАНКНЫ БАТАЛГАА)**

***[Захиалагч байгууллагын нэр]***

***[Гүйцэтгэгчийн нэр]*** нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь ***[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]*** (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

***[Банкны нэр]*** (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс ***[баталгааны дүн тоогоор, төгрөг][дүн үсгээр, төгрөг]*** –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг ***[захиалагчийн нэр]***(цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан ***[баталгааны дүн тоогоор, төгрөг][дүн үсгээр, төгрөг]***-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний баримт бичигт оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш
/огноо оруулах/ хугацаанд хүчинтэй байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

**МАЯГТ № ГМ-3**

# УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
# (БАНКНЫ БАТАЛГАА)

***[Захиалагч байгууллагын нэр]***

***[Гүйцэтгэгчийн нэр]*** (цаашид “гүйцэтгэгч” гэх) ..… оны … дугаар сарын …-ний өдрийн … тоот ***[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]*** гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний ерөнхий нөхцөлийн 48 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж ***[Захиалагчийн нэр]***-ийн өмнө хариуцлага хүлээж ***[Баталгааны мөнгөн дүн][үсгээр]***-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

***[Банк нэр]*** (цаашид “Банк” гэх) нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс ***[баталгааны дүн тоогоор, төгрөг][дүн үсгээр, төгрөг]***–ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу гүйцэтгэх ажил, гэрээний баримт бичигт оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдөх өдөр /огноог оруулах/ хүртэл хүчин төгөлдөр байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

## ХАВСРАЛТ

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендерийн урилгыг бэлтгэх санамж**

Тендерийн урилгыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухайхууль, "Босго үнэ батлах тухай" Засгийн газрын 2006 оны 22 дугаар тогтоол, Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам"-д заасны дагуу бэлтгэж, зарлан мэдээлнэ.

Тендерийн урилгын зорилго нь эрх бүхий тендерт оролцогчид тендер шалгаруулалтад оролцох боломж олгож энэ тухай шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

Урьдчилсан сонголт явуулсан нөхцөлд урилга болон тендерийн баримт бичгийг зөвхөн урьдчилсан сонголтод шалгарсан оролцогчдод илгээж, тендер шалгаруулалтад оролцуулна.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо[36] : ____________
Тендер шалгаруулалтын нэр: ____________
Тендер шалгаруулалтын дугаар: ____________

***[Захиалагчийн нэр]*** эрх бүхий тендерт оролцогчдоос ***[ажлын товч тодорхойлолт]***–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг*)* бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь ***[дүн]***[37] төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн ***45*** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Тендерийн хамт ***[дүн]***[38] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа[39] ирүүлнэ.

Тендерийг ***[тендер хүлээн авах эцсийн огноо, цаг]***–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг ***[огноо]****-ны өдрийн,* ***[цаг]***[40]*-т* нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх**:**[41]
Дотоодны давуу эрх тооцох эсэх.[42]

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

***[Захиалагчийн тодорхой хаяг***
***(өрөөний дугаар, харилцах албан тушаалтны нэр, утас/факс)]***

[36] Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.
[37] Тендерийн баримт бичгийг түүнийг бэлтгэхэд буюу хувилж олшруулах, шуудангаар хүргэх зэрэгт зарцуулсан өртгөөр үнэлж, тендер шалгаруулалтад оролцохыг хүсэгчдэд энэ үнээр саадгүй олгоно.
[38] Төсөвт өртгийн 1-2 хувьтай тэнцүү байна.
[39] Барааны төсөвт өртөг 30 сая төгрөгөөс дээш бол, тендерийн баталгаа ирүүлэхийг заавал шаардана.
[40] Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусcанаас хойш 1 цагийн дотор байна.
[41] Гадаадын этгээдийг худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй бол “Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй” гэж бичнэ.
[42] Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

**ТЕНДЕРИЙН УРИЛГА**

Огноо : 2020.04.20

Тендер шалгаруулалтын нэр: Ундны усны худаг (Хөвсгөл, Мөрөн сум 10,11,12,13,14 дүгээр баг) гүйцэтгэлтэй ажлын гүйцэтгэгч сонгох**.**

Тендер шалгаруулалтын дугаар: БХБЯ/202001065/1.2.15

***Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газарт*** эрх бүхий тендерт оролцогчдоос Ундны усны худаг (Хөвсгөл, Мөрөн сум 10,11,12,13,14 дүгээр баг) ажил-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн (www.tender.gov.mn цахим системээр) тендер ирүүлэхийг урьж байна. Багцтай .

Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, олны өтөгт гүний худаг

Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг*)* цахим хэлбэрээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь ***50,000*** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн ***30*** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь захиалагчийн санал болгож буй төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **30 хувь байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ/, мөн онуудын санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх,**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын дундаж өртөг: **Сүүлийн 3 жил (2018, 2019 онууд)-ийн хугацаанд доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй авто замын барилга угсралтын ажилтай ижил төстэй ажлыг нийлүүлэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх ба уг гэрээ (ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа нийлүүлсэн тэр гэрээ)-ний үнэ нь энэ тендерт санал болгож буй ажлын төсөвт өртгийн 40 хувиас багагүй байх**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагатай. Үүнд**

**Худаг, уст цэг гаргах**

Тендерийн хамт Багц-1: Мөрөн сумын 10, 13 баг, олны өтөгт гүний худаг – 1,400,000 төгрөг

Багц-2: Мөрөн сумын 10, 11, 12-р багуудад цэвэр усны гүний худгийг смарт тоноглолтоо болгох - 600,000 төгрөг дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

***Тендерийн баталгааны хугацаа 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хүчинтэй.***

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаархи мэдээллийг шалгана.

Тендерийг ***2020 оны 5 дугаар сарын 18 -ны өдрийн 11 цаг 20 минут****–*аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг ***2020 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн, 11 цаг 40 минут****-д* нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх**: Эрхгүй**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Төлбөрийн хийх хэлбэр: **цахим хэлбэрээр.**

Банкны нэр: **Төрийн сан**

**Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар,**
**аймгийн ЗДТГ-ын А байр, 114 тоот өрөө,**
**утас: 70388849, 70388848, 70388821, 95490203, факс: 70388849**